Mongolian Americans have high hopes for both the Bay Area Mongolian community and Mongolia. Some Mongolian Americans hope that an educated Mongolian American will become a U.S. Senate member. Mongolian Americans also want the younger generation to become highly educated. The current generation of Mongolian American immigrant parents laid the foundation for their descendants by making sacrifices, often not developing businesses nor pursuing their own education so that they could dedicate their efforts towards giving their children opportunities. Therefore, they hope the younger generation will go further in life than their parents did.

Mongolian Americans want their peers to learn the US legal system, to get interpreters or attorneys when they have legal issues they don't understand, to realize that they can defend themselves in court, and to obey the law. They also want members of their community to learn English, work hard, and keep an open mind. They hope that as the Mongolian American community grows stronger it helps Mongolia not only economically or technologically but also through education to help people to live better. Many Mongolian Americans hope other Mongolian Americans keep their traditions alive while in America and ultimately return to Mongolia to contribute to society.

When it comes to Mongolia, Mongolian Americans warn that a small country between two big neighbors can easily vanish. China is a global producer and Russia supplies oil to the world, while Mongolia is landlocked with a small population. Some Mongolian Americans want to employ trade barriers and taxes in Mongolia in order to support small Mongolian businesses. They're concerned, for example, that cheap and tender beef from Argentina could easily damage the Mongolian beef industry. Still, Mongolians say they don't want Mongolia to be isolated like North Korea, but rather more international and open minded. Some Mongolian Americans see globalization as good for Mongolia.

Mongolia has a unique economy. Because Mongolians don't produce many products, they must import several things. Mongolia's primary exports are copper, gold, coal, cashmere, and animal skin. Mongolian Americans see it as unfortunate that the nation is not attractive to foreign investment. They are concerned that currently one must invest \$300 to make \$100.

Mongolia is trying to get more international attention. Mongolian Americans see the nation as having more opportunities today than ever before. Mongolian Americans hope that Mongo-

lian leaders start paying more attention to the fields of medicine and education, to the pollution in Ulaanbaatar, and to water quality.

Closing

Tuvans, Darhads, and Mongolian Americans all have vibrant cultures, formidable strength, and prodigious wisdom. I hope the information in this book is of use to you as you seek to craft brilliant futures.

Glossary

Africa – a continent beneath Europe and the Middle East
African American – a black American with ancestral or personal African origins
Arab – a person with origins in the Arabian Peninsula in the Middle East (Southwest Asia)
Australia – an island continent
Beijing – the capital of China
Cambodian – a person from the Southeast Asian country of Cambodia
Canada – a country north of the United States in North America
Cowboy – a person who herds cattle
Del – a traditional Mongolian robe
Europe – a continent west of Asia
France – a country in Europe
Ger – a yurt, a tent supported by a wooden lattice frame and covered in sheep felt
Germany – a country in Europe
Global warming – slow continuous increase in the earth's temperature that causes the climate to change in harmful ways
Gobi – a desert in Asia, most of the desert is in Mongolia
Graphic design – the field of designing images for advertisements and businesses and other institutions
Great Wall of China – the two thousand mile wall built in the third century B.C. to protect the Chinese from nomads
Haiti – an island country near the United States
Himba – an African indigenous people
Italian – a person from the European country Italy
Latino – a person with origins in Spain (a country in Europe) or the region between the continents North America and South America called Central America or South America itself
Japan – a country in East Asia
Kazakhstan – a country that borders Mongolia
Korea – a country in East Asia
Master's degree – typically the next scholarly degree earned after one has completed his or her university education in America
Moscow – the capital of Russia
North Korea – a country in East Asia
Ovoo – altar-like conical piles of stones that host wooden poles tied with colored scarves
Pakistan – a Middle Eastern country
PhD – PhD stands for the Doctor of Philosophy degree which is typically earned after a Master's degree in America
Sami – a European indigenous people
Saudi Arabia – a country in the Middle East
Singapore – a country in Southeast Asia
South Africa – a country in the continent of Africa
Tokyo – the capital of Japan
Uzbekistan – a Central Asian country
Washington D.C. – the capital city of the United States of America, it is not in a state
Ulaanbaatar – the capital of Mongolia
Ulaan Uul – a town in Khövsgöl aimag (province) of Mongolia

Reflections on Grazing and Herding Practices during Communism, the Transition Period, and Democracy

Acknowledgements

I would like to thank Dartmouth College, the Lombard Fellowship program, and the Dougherty Fund for making possible the creation of this work. I would also like to thank my translator/guide Soyloo for her language skills and for providing greater context for the oral history I gathered. Most of all, I want to thank my Darhad sources for collaborating with me in order to help them understand their grazing history and make wise decisions in the future.⁸

Foreword

Bayankhangai is a Darhad Valley user group composed of twenty three families. I interviewed the available members of families old enough to have been herders during communism about herding and grazing practices during three periods: communism, the transition period, and democracy.

In reading this work it is important to remember that the oral history I collected, like all history, is fallible and meaning can be lost in translation, but the sources who participated in this project sought to give me the most accurate information possible, and I aimed to record and compile it as correctly and clearly as I could. Readers should also note that even among small user groups there can be great variation in terms of experience, practice, memory, opinion, etc.

Sources⁹

My sources are listed, with their ages, in the order they were interviewed. Individuals listed together are family and/or were interviewed together.

Gombosuren, 50; Davaajav, 45
Balbar, 41; Gerelee, 41
Munkhbat, 70
Erkhembayar, 51
Davaajav, 63; Moloojoi, 62; Oyuntuya, 30¹⁰
Nyamrenchin, 42

⁸ The author is not responsible for any consequences that come from using this work as a "how to" guide.

⁹ Information given by sources is organized primarily thematically, for cohesion, rather than by source. Sources are acknowledged here rather than in conjunction with the information they contributed.

¹⁰ Oyuntuya, although a child when communism ended, still contributed valuable information.

Communism

Communist Plans

During the communist era, government officials developed plans for grazing and herding animals and for the monthly production of curds and cream, and nomads received salaries for executing those plans. Cattle belonged to the government. People were hired to herd and milk them and were given female and baby goats, but not male goats. Nomads were paid in accordance with how many animals they tended. For example, herding 450 sheep could earn a family 120 tugrik. Nomads earned money for breeding animals, and the highest salary possible was 200 tugrik.

Leadership

During communism there were a few strong leaders whom the masses were expected to follow. The era was marked by a general lack of self-motivation, but the masses were also beneficiaries of a moral education that emphasized principles such as doing hard work and valuing environmentally safe, even if inconvenient, practices. In addition to government officials, nomads whose animals rarely died were selected as bag leaders and remained in their roles until they made poor decisions. If they led wisely, they could remain leaders for life.

Amount of Animals

During communism nomads had fewer animals, particularly sheep, goats, and cows. Still, nomads were supposed to breed a lot. A family entrusted with 100 animals by the government was supposed to have 150 the next year. For this reason, nomads didn't slaughter many animals for meat – even if they had a lot of children to feed.

Grazing

During communism animals grew strong because they were allowed to graze all day, and sheep and goats were allowed to roam freely over night as opposed to being kept in corrals. Naturally, as a result of having more space, they grew fatter. Nomads would change grazing locations frequently, moving four times during the summer or moving both to close or far new spots approximately every two weeks and seasonally to allow the land to recover. To further protect the land, only two or three families would graze in one place. Nomads would carefully make trails to grazing pastures and move to new pastures by following old trails so that the land wasn't damaged. Because of careful grazing practices, nomads were able to cut twenty tons of grass per year.

Otor

Otor is a practice that occurred during spring and again in late August when the grass is especially high. During that time nomads abstain from milking their animals so that they can graze unbothered and get fat for rest of year. The grazing takes place for ten to fourteen days far from nomads' homes where grass is plentiful and is uninhabited. Simply shepherding animals out to graze during the day and returning with them to one's home each night isn't sufficient. Nomads see the tradition of otor as being important to preserve during democracy. All people practiced otor during communism though people tend not to do it now because of the inconvenience.

Labor

Herding and grazing animals during communism was labor intensive. The different types of animals were herded separately from each other, requiring one person to herd sheep and goats and another to herd cattle in a different location. Some shepherds even herded grown cattle separately

from their calves. Animals were milked twice a day. Children worked during their school vacations, and some nomads remember unhappily that there was no day of rest. Still, the government rewarded those who worked hard and allowed people one to two year periods of rest.

Milking

During communism there was more milking and production of dairy products – particularly of sheep. Goats were milked primarily in the autumn.

The shepherd's day began at sunrise. The first chore was herding which lasted until 1:00 when ewes would be milked. In the evening the lambs and sheep would be herded separately and then brought home.

The Transition Period

During the transition period, which began after communism fell in 1990, livestock ownership was privatized. Each family fended for itself. Some nomads say that until 1993 most people obeyed the old communist plans, grazing where the communists had dictated, migrating frequently, and using yaks and camels instead of cars. After 1993 few people continued to follow communist practices since they were no longer compulsory. Other nomads say they were not used to being self-motivated. Some nomads believe the people wasted the first two years of the transition period by waiting for a leader to direct them and not valuing unsupervised hard work.

Democracy

Grazing

Nomads currently migrate only seasonally which leads to overgrazing and retards the growth of grass. Some nomads migrate only nominally – moving four times a year but only three kilometers each time, meaning they essentially live and graze their animals in the same place year round. Overgrazing is further exacerbated by twenty to thirty families living together in one place.

Overbreeding has three causes. Nomads raise two to three times more animals in democracy than they did in communism in order to earn money in the capitalist economy. (Many nomads heavily breed goats for cashmere although goats, because they eat the roots and not just the tips of grass, have grazing habits that are more damaging than those of other animals.) Thus, goats destroy more land. Overbreeding is also linked to a lack of accurate information regarding the time needed for grass to regrow and the belief that the bounty of nature is endless no matter how nature is treated. Overbreeding is linked to overgrazing.

Overgrazing affects most of the land, resulting in nomads being able to harvest only a maximum of five tons of grass per year. Decisions that lead to overgrazing are seen as reflecting a lack of moral education. Nomads believe that people should treat the land with kindness and thoughtfulness, migrating ten to twenty kilometers in order to protect it from harm. Many nomads say that poor grazing practices are due to the absence of communist strictures; others say that democracy cannot be blamed for the poor decisions of individual herders. Ultimately, herders are responsible for the choices they make regarding grazing.

Milking

Some nomads milk their cattle twice a day, while others only do one sunrise milking. Sheep are milked only one month a year, from the tenth of June until the tenth of July as during this time the grass is beginning to grow which contributes to milk of high quality. For the remainder of

summer sheep are allowed to get fat and strong for the rest of the year. Some nomads don't milk sheep at all.

Herding

Individual families often have different herding habits (routines). Each family does its own herding, often guiding animals to certain pastures at 10:00 am and bringing the animals back home at 1:00 pm. Animals are frequently allowed to spend most of the day in the same place. At night sheep and goats are kept in corrals to protect them from thieves and wolves. It's also best to herd cows and calves in opposite directions to prevent calves from drinking too much of their mothers' milk. Nomads say it's better to actively herd cattle and other animals than to merely follow them as people often do in democracy.

Bayankhangai

Bayankhangai has undertaken many projects and has developed its own grazing and organizational plans in lieu of those once provided by the communist government. Under the guidance of the group's founder and leader, Nyamrenchin, and BioRegions founder and president Clifford Montagne, the user group built a fence to shield its winter pasture from grazing so that it could feed animals at a later time or supplement the extra grass the government donates in the case of emergencies. Another practice Bayankhangai is fostering is favoring fewer but good, strong animals instead of raising many animals of a lower quality.

Nyamrenchin says people should base the amount of animals they raise on the number of people in their families thus diversifying their labor. For example, a family of five could have two of its members earn money, two herd animals, and one milk animals. Having all the members of the family try to do all these tasks is wasteful, in his opinion. He believes in the division of labor. A family following his model shouldn't have more animals than three people can care for – perhaps no more than three hundred. These animals would provide the family with food – primarily dairy. Two money earning females could cross stitch or embroider while money earning males could carve wood or make furniture.

Nyamrenchin would prefer that families raised fewer goats, but, as goats are private property, he cannot stop people from raising large numbers of them. He feels the people need a profitable alternative to goats. The government recognizes how goats damage the environment and is helping to limit their impact by cutting the price of cashmere in half.

Generational Differences

Nomads participate in Bayankhangai differently depending on their age and inclination. Young people tend to be more independent and to make decisions on their own while older people remember how to work together effectively. Some elders say that young people don't listen, i.e., that if the group makes plans to cut grass together, young people will do it individually. Other nomads say that some of their peers don't pay attention to their particular grazing practices, leaving the burden of grazing responsibly to be shouldered by others.

Herding Traditions

Nomads see the future of grazing and herding in the past – not in the practices of the communist era but in their own traditions. Traditions such as otor, grazing different animals in different spaces (although goats and sheep may graze together), rearing animals selectively, killing weak animals that won't survive the winter rather than keeping them just for the sake of having large herds, and not overbreeding predate communism and have roots in Mongolian culture.

Бичигдсэн гол

Агуулга

Тува ястан	52
Дархад ястан	65
Америкт байгаа Монголчууд	78
Төгсгөлийн үг	94
Үгсийн тайлбар	95
Социализмын үе, социализмаас ардчилалд шилжих шилжилтийн үе, ардчиллын үеийн бэлчээр болон мал маллагааны тухай бодол эргэцүүлэл	96

Талархал

Энэхүү ажлыг хийх бололцоо олгосон Дартмаутын коллежын Ломбардын нийгэмлэгийн хөтөлбөр болон Дагэртын санд баярлалаа.

АНУ-ын Монтана мужын Их Сургуулийн Биорегион-Эгч Дүү Орнууд төслийн хамт олон миний Монгол руу хийсэн аялалд бүх талаар тусалж, орчуулагч олох, Баянхангай нөхөрлөлтэй холбож өгөх зэргээр тусалсанд маш их баярлалаа. Мөн миний цуглуулсан энэ бүх гайхамшигт аман яриануудыг олох, орчуулахад тусалсан хөтөч, орчуулагч Эрдэнэбилэгийн Соёлмаад баярласнаа хэлмээр байна.

Шэл Шэвэринхаус болон Чойжилжавын Даваадулам нарт Америкт амьдарч байгаа Монголчуудтай холбоо тогтоож ярилцлага авахад тусалсанд баярлалаа. Мөн миний энэ бүтээлийг хянасан Жүди Хэмкэрт баярлалаа. Бүхнээс илүүгээр, өөрсдийн гайхалтай соёл ёс заншлыг мөнхлөн үлдээхэд тусалж надтай хамтран ажилласан Тувачууд, Дархадууд болон Америкийн Монголчууддаа маш их баярласнаа илэрхийлье.

Өмнөх үг

Эртний Монголын ёс заншилд голууд тэнгис далайд цутгадаг гэсэн төсөөлөлтэй байсан ба орчин үед голуудыг ариун нандин бөгөөд амьдралын эх булаг хэмээн үздэг. Энэ номыг *Бичигдсэн гол* гэж нэрлэсэн учир нь уламжлалт мэдлэг, итгэл үнэмшил, амьдралын хэв маяг зэрэг тасралтгүй үргэлжлэх мэдээллүүдийг агуулсан юм.

Номын агуулга бол Монголын жижиг хоёр нүүдэлчин ястан болох цаатан малчид

Тувачууд¹¹ ба Дархад¹² ард түмний социалист нийгэм задран унасанаас хойш барагцаалбал 20 жилийн дараах үеийн ёс заншлын тухай бодол эргэцүүлэл. Эдгээр ард түмний тухай эргэцүүлэл өнгөрсөн үеийн толинд биш харин өнөө үеийн Барууны соёлын үзэл баримтлалууд тэдний амьдралд нөлөөлж байхад нэг хэсэг үед сүйрч байсан эрхийг сэргээх өөрчлөлтийн үед амьдарч буй хүмүүсийн бодол эргэцүүлэл, Чингэс хааны үед үүссэн тэр харгуйг даган урсгал ус мэт өөрчлөгдөж буй бүлэг хүмүүсийн тухай эргэцүүлэл. Мөн энэ номонд Америкт амьдардаг монголчуудын амьдралын туршлагын тухай өгүүлсэн ба даяарчиллын нийгэмд амьдарч буй монголчуудын тухай мэдээлэл, өөрийн орны соёлд тэдний нэгтгэхийг хүсэж байгаа болон хүсэхгүй байгаа Барууны нийгмийн үзэл баримтлалуудын тухай хийж буй шийдвэрүүд шиг Барууны ертөнц Монголд¹³ байгаа монголчуудад эх үүсвэр болно хэмээн тэд итгэдэг.¹⁴

Бичигдсэн голыг бичихдээ би Монголын хойд хэсгээр аялахдаа ярилцлага хийсэн малчид, уламжлалт эмчилгээний эмч, гар урчуудын мэддэг хийгээд уламжлагдан өвлөгдсөн бүх мэдээлэлүүдийг нэгтгэж уламжлалт соёл зан заншлыг агуулсан угсаатны зүйн лавлах бичиг бичихийг, мөн хойд нутгийн монголчуудыг Америкт байдаг нутаг нэгтнүүдийнхээ амьдралыг харах боломж олгох цонх хийхийг зорьсон билээ.¹⁵

Миний номны гол баатрууд бол Тува ба Дархад хүмүүс бөгөөд та бүхний байнгын хүсдэг уламжлалаа ирээдүйд хадгалан үлдээхэд туслахын тулд энэ номыг бичлээ. Мөн гадаадынханыг энэ номыг уншиж танай орны гайхамшигт соёлын тухай улам ихийг мэдээсэй хэмээн хүсч байна.

Үүнийг уншихдаа миний цуглуулсан эдгээр түүх ярианууд бусад бүх аман түүхүүдийн адилаар зарим зүйлүүд нь бодит бус байх эсвэл орчуулгын явцад зарим утга санаа алдагдсан байж болохыг санах нь чухал юм. Гэхдээ энэ төсөлд оролцсон хүмүүс хамгийн үнэн зөв мэдээлэл өгөхийг эрмэлзэж, би чадлынхаа хэрээр зөв бодитой бичиж тэмдэглэж, эмхэтгэхийг зорилоо.

Мөн жижиг ястан хэдий ч итгэл найдвар, амьдралын хэв маяг, үнэ цэнэ, өнгөрсөн түүхээ санан дурсах мэтээр цаг хугацааны олон үед хамааралтай болохыг ойлгох буйзаа. Энэ ном нь Дархад, Тува, Америкт байгаа Монголчуудын уламжлалт соёлын нийлмэл цогц боловч эдгээр ястан үндэстэн бүр тус тусдаа давтагдашгүй өв соёлтой билээ.

Олон төрлийн соёл заншил холилдон зохиолч би Аниунвийяа (Чироки) буюу уугуул америк, америкийн индиан хүний хувьд Америкийн Индианчууд ба Дархад, Тувагийн соёл ёс заншлын хооронд адил төсөөтэй зүйлүүд байгааг ажигласан юм. Америкийн Индианчуудад (тэд омог аймгийн хувьд өөр байдаг) Тува ба Дархад хүмүүстэй адил зүйлүүд нэлээд байдаг. Тухайлбал ариун ургамал шатааж биеэ болон эд зүйлсээ ариутгаж утах, ариутгасан хэнгэрэг цан гэртээ байлгах, ан амьтан агнахдаа өршөөл гуйх, бөө, ардын эмч бариачаас тусламж авах, гар урлал хийхдээ сайн сайхан зүйл бодож оюун санааны сайн зүйлсийг тэр зүйлдээ шингээх гэх мэт.

Түүнчлэн эдгээр гурван ястангууд уламжлалын дагуу юмс үзэгдлийг мөчлөгтэй хэмээн боддог ба ургамал амьтан, голууд, байгал дээр байгаа бүх амьд амьтад сүнстэй байдаг

11 Монголын тува цаатангууд баруун ба зүүн тайгад амьдардаг ба би энэ ажлаа баруун тайгад хийсэн.

12 Би Рэнчинлхүмбэ сумын болон Баянхангай нөхөрлөлийн дархад хүмүүстэй ярилцлага хийсэн.

13 АНУ-д амьдардаг монголчуудыг Монголын Америкчууд гэж бичсэн ба тэд тэнд хууль ёсоор эсвэл хууль бусаар амьдардаг, тэд Америкийн оршин суугч мөн эсэх, тэд тэнд байнга үлдэх эсвэл Монголд эргэж ирэх эсэхийг бичээгүй болно

14 Миний ярилцлага хийсэн Америкт байгаа Монголчууд Сан Франциско ба Окландын зэргэлдээ байдаг хөрш хотуудад буюу Бэй хэмээх монголчууд олноор амьдардаг газарт амьдардаг. Энэ газар Калифорн мужид байх ба АНУ-ын мужууд хоорондоо газар нутгаар зааглагдана.

15 Энэ бүтээлийг аргачлал болгон хэрэглэсэнээс гарч болох ямар нэгэн үр дагаврыг зохиолч хариуцахгүй болно.

бөгөөд хүмүүстэй таарамжтай амьдрахыг хичээж, байгалийн бусад хэлбэр, сүнслэг ертөнцөд итгэдэг.¹⁶ Хэрэв би Америкийн уугуул иргэн биш байсан бол Тува, Дархад соёл заншлын хэд хэдэн онцлог зүйлсийг асууж мэдэхгүй байх байлаа. Миний өв соёл надад энэ хүмүүстэй ярилцлага хийн бичиж авах, илүү дотно харилцах бололцоо олгож энэ нутгийн уугуул иргэдэд тэтгэлэг олох хэрэгцээг өөр орны уугуул иргэн би хийх хэрэгтэй гэсэн миний итгэл найдварыг хурцалж өгсөн юм.

Харамсалтай нь Америкийн уугуул иргэд ба Монголчууд аль аль нь газар нутгаа булаалгах, ариун догшин газрыг нь уул уурхайн үйлдвэрлэл сүйтгэх, хавдар өвчний өвчлөл ихсэх, Америкийн колончлолын үед (Америкийн уугуул иргэдийн тухайд) ба социализмын үед (монголчуудын тухайд) шашин шүтэх эрхийг нь хэлмэгдүүлэх зэрэг олон асуудлуудтай тулгардаг. Дэлхий дээр байдаг бүх эртний уламжлалт үндэстэн Тува, Чироки, Химба, Сами ард түмнүүд олон ижил чанартай бөгөөд мөн олон ижил асуудалтай нүүр тулна. Бидний олонх маань “орчин үеийн” байх буюу Барууны эсвэл даяарчлагдсан гэсэн утгатай худал ярихыг манлайлж баруунжих ба даяарчлал нь зайлшгүй гэж үздэг. Бид бүгдээрээ уламжлалаа үргэлжлүүлэхийн төлөө мөн энэ дэлхийд ирээдүйд бидэнд заналхийлж болох бүхний эсрэг байх арга замуудыг мэдэхийн төлөө их ажилладаг.

Хүчирхэг байхын тулд, ирээдүйгээ тодорхойлохын тулд бид хамтран ажиллах нь чухал гэсэн миний бодлыг Монголд өнгөрүүлсэн энэ цаг хугацаа баталсан юм. Бидний соёл ёс заншлын голууд нийлж урсах үед бид хүчирхэг тэнгисийг байгуулна гэдэгт би итгэдэг.

Зарим мэдээлэлд жишээлбэл “шашин”-ы тухай хэсэгт Тува, Дархад ястан ариун нандин ба шашны бус гэсэн бүлгүүдэд хатуу хуваагдаагүй байдаг. Монголын ба бусад уламжлалт соёлуудын зарим зүйлүүд хоорондоо нэгдсэн байдаг.

16 Энэ номыг бичихэд тусалсан манай байгууллага тодорхой орон нутгийн чанартай бүлгүүдэд уугуул иргэдийн бодол санааг Барууны ажлын хүрээнд албадан оруулдаг.

Нэгдүгээр хэсэг Тувачууд

Оролцсон тувачууд¹⁷

Оролцсон хүмүүсийн нэрс, тэдний нас, мөн энэ дарааллаар ярилцлага өгсөн болно. Нэр нь хамт бичигдсэн хүмүүс гэр бүл, эсвэл ярилцлагыг хамтдаа өгсөн юм. Энд жагсаалтанд Дархад бүсгүй Бямбасүрэнгийн нэр байгаа. Учир нь тэр Тува бөөгийн эхнэр ба цаатангуудтай амьдардаг учир түүний өгсөн мэдээлэл бол Тувагийн тухай юм.

Монголчууд голдуу өөрийн нэг нэрээ хэрэглэдэг ба гэр бүлийн нэр хэрэглэдэггүй. Тэд өөрийн нэг нэрээ хэрэглэдэг хэдий ч бичгийн болон албан ёсны баримтанд эцгийн нэрийг хамт хэрэглэдэг.

Баяндалай 53 настай
Эрдэнэчимэг 46 настай Оюунбадам 38 настай
Бямбасүрэн 36 настай
Баяраа 55 настай
Нагвасүрэн 25 настай
Шархүүхэн 60 настай
Санжаа 58 настай
Дэнхэр 47 настай Атармаа 44 настай
Шонхор 38 настай
Отгон 45 настай Зоригт 41 настай
Өлзий 73 настай Олзвой 40 настай
Дэлгэрдалай 32 настай Болорцэцэг 26 настай
Ганзориг 53 настай Эрдэнэчимэг 51 настай
Гоост 62 настай
Баасанхүү 37 настай

Өнгөрсөн ба одоо үе

Түүх

Чингис хааныг хамгийн том, хөрш зэргэлдээ улсуудыг хамарсан эзэнт гүрэн байгуулахаас өмнө Уйгурчууд Азийн хаант улсыг захирч байсан. Тэдний омог Цэнхэр сувд болох Байгал нуурын орчимд цугларсан үе манай эриний өмнөх 300 жилд тэдний түүх эхэлсэн ба энэ үеэс тэдний соёл ёс заншил дэлхий дахинд хадгалагдан үлджээ. Уйгуруудын хойч үе Вашингтон мужийн интоорын моддын доогуур мөн Хятадын Бээжингийн Цагаан хэрмийн доогуур зугаалж, Узбект ан хийж, Пакистанд худалдаачидтай үнэ хаялцаж, Орост мөсөн дээр гулгаж, Токиод хурдан галт тэргэнд суугаад л. Сибирийн доод хэсэгт нуураас холгүйхэн тэдний өвөг дээдэс үүссэн газарт Уйгурын хойч үе амьдардаг ба тэднийг Тувачууд гэж дууддаг, тэд цаа буга малладаг.

Монголын Тувачууд Оросын Тувагийн Бүгд Найрамдах Улсаас гаралтай ба 1944 онд Орос тусгаар тогтносон Тува улсыг өөртөө нэгтгэсэн тэр үед Тувагийн жижиг

омог салан тусгаарлажээ. Хоёр өөр улсад амьдарч байгаа болохоор зарим гэр бүлийн гишүүд бие биеэсээ хол байх бөгөөд зорчих эрхгүйгээр өөр хоорондоо зочилж очих боломжгүй. Одоогийн байдлаар 60 хүрэхгүй тооны Тува гэр бүлүүд Монголд амьдарч байгаа ба тэд цус ойртохоос сэргийлж өөр үндэстэнтэй гэрлэх шаардлагатай болдог. Гадны судлаачид Тува улсын нутагт ойролцоогоор хоёр зуун мянган тувачууд байдаг гэдэг ч Монголын тувачууд дэлхийд зургаан сая тувачууд байгаа буюу бид их хүн амтай ястаны нэг хэсэг гэдэгтээ итгэлтэй байдаг. Бүх Тувачууд цаа буга малладаггүй гэдгийг Монголын Тувачууд мэддэг ба тэдний орос Тува хамаатан садангууд ямар уламжлалт ёс заншлыг үргэлжлүүлэх юм бол доо гэж гайхдаг. Орос Монголын хооронд хил үүсэхээс өмнө тувачууд хүчирхэг байсан ба тэд соёл ёс заншлын хувьд хоорондоо илүү холбоотой байжээ.

Уламжлалт ёс заншлын өөрчлөлт

Тувачууд бол эртний уламжлалтай хүмүүс боловч энэ нь тэд хувиршгүй гэсэн үг биш юм. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэдний соёл заншил өөрчлөгдөж том үндэстэнтэй харилцан оршихын зэрэгцээ амьдрах арга зам, амьдралын чухал үнэ цэнээ хадгалсаар иржээ. Магадгүй тэд малын арьсан хувцсаа Барууны хувцсаар сольж, торгон дээл сонинчирхан өмсөж болох ч тэд нүүдэлчин амьдралын хэв маягаа энхрийлэн хайрлаж, өвлүүлэн хадгалахыг хүссэн учраас зууныг алгасан үлдээж чадсан билээ.

Социалист удирдлагын нөлөөгөөр 1950-1960-аад оны үед тэдний амьдралд гарсан өөрчлөлт болон хотын хүмүүс яаж амьдардагыг сайн мэдэх болсон зэрэг нь тэдний амьдралын хэв маягын гол өөрчлөлт болсон гэж ихэнх тувачууд боддог. Энэ бол ор, зурагт, радио энэ зуунд анх шинээр гарсан үе байв. Хүмүүс тулгын гурван чулуутай ил гал дээр хоол хийхээс татгалзаж тогоогоо дээр нь тавьж мод түлдэг зуухтай болсон ба хусны үйс Тувагийн нийгмийг доройтуулах үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Хусны шүүс тосдог хувин төмөр хувингаар солигдов. Урцны унинаас зүүлттэй хусны үйсээр хийсэн дүүжин өлгийд нялх хүүхдүүд унтах нь ховордлоо. Хамгийн гол нь бүтэн нэг үеийн өмнө өвөл урцаа бүтээдэг малын арьсыг, зундаа борооноос хамгаалдаг хусны үйсийг бэржээнтэн бүрээсээр сольж урцаа бүтээдэг болжээ. Хусны үйсээр урцны бүтээлэг хийхдээ эхлээд хус модноос үйсийг нь хуулж аваад дараа нь буцалгаж зөөлөн болгоод даавууны дотор барьж оёдог. Бэржээнтэн бүрээс худалдан авах нь дээрх гар ажлыг хөнгөлсөн юм.

Социалист нийгэм 1990 онд задран унахад Тувагийн соёл заншил дахин нэг удаа аажмаар өөрчлөгджээ. Социализмын үед цаатангууд төр засагт албан ёсоор харьяалагдаж цаа буга хариулаад цалин авдаг байсан учраас амьдрал тэр үед одоогийнхоос дээр байсан гэж зарим тувачууд үздэг. Бусад нь ардчилалыг дэмждэг. Аль ч төр засаг удирдсан хамаагүй Тувагийн соёл заншил эргэлзэх зүйлгүйгээр шинэчлэгдэн хувирсаар байх болно.”Залуу үеийнхэний тал хагас нь бидний амьдралын замыг үргэлжлүүлнэ, нөгөө хагас нь өөрчлөгдөнө гэж би боддог. Мөн ямар ч хүн бусдыгаа өөрчлөх гэж илүү ихээр ятгалаа гэсэн ч мэдээжээр бидний уламжлал үргэлжлэх болно, гэхдээ урцнаас гэрт нүүж орох мэтийн зарим өөрчлөлтүүд гарна” гэж Ганзориг сануулан хэлдэг.

Онцгой нэгэн ястаны ба том үндэстэний иргэний хувьд Тувачууд Монголчуудын нэгэн адилаар олон өөрчлөлтүүдтэй нүүр тулгардаг.

Нийгэм улам ихээр Баруунжиж байгаа шиг өсөн нэмэгдэж байгаа уул уурхайн хэрэгцээ, хүрээлэн буй орчны өөрчлөлт ихсэх зэрэг бэрхшээлүүд гарна. Тэд шинэ өөрчлөлтүүдийг хүлээн авахаас айхгүй ч тэдний соёл ёс заншил хэр зэрэг алдагдсаныг Ганзориг мэдэхийг хүсэж байна. Тэр “жишээлбэл бидэнд үндэсний уламжлалт олон төрлийн хувцас байсан боловч би мэддэггүй. Эдгээрийн тухай би ахмадуудаасаа асуух хэрэгтэй байсан юм. Магадгүй бид номноос эсвэл өвөө эмээгээсээ асууж сурах хэрэгтэй”

¹⁷ Энэ бүлэгт ба Дархад, Америкийн Монголчуудын тухай хэсэгт байгаа мэдээдэллийг хувь хүн тус бүрээс биш, бүлэг хүмүүсээс сэдэвчилж авсан. Энд оролцсон хүмүүс өгсөн мэдээдэлтэйгээ холбоотой болно.

гэж ярьсан юм. Тувачууд тэдний соёл заншлаас алга болсон зүйлүүдэд харамсдаг бөгөөд тэд ирээдүйд өв соёлынхоо бусад зүйлсийг алдахыг хүсэхгүй байгаа.

Соёл ёс заншил

Нэр

Монголын Тувачуудыг голдуу “Цаатан” гэж нэрлэдэг ба цаатан гэдэг нь цаа бугыг дагадаг хүмүүс гэсэн утгатай. 1950-иад оны үед арьс өнгөөр доромжлогдон энэ нэрийг авчээ. Тува биш хүүхдүүд сургуулийнхаа Тува хүүхдүүдийг тэдний соёл заншлыг элэглэн шоолж энэ нэрээр дууддаг байжээ.”Энэ нэрээс бид ичдэг байсан, одоо ч ичдэг” хэмээн Эрдэнэчимэг, Оюунбадам нар хэлсэн юм. Түүнчлэн энэ нэр олон Тувачуудад эвгүй санагддаг. Яагаад гэвэл энэ нэр тэдний түүхийг дордуулдаг. Эцэст нь, Цаатан гэсэн бүгд найрамдах улс хэзээ ч байгаагүй ба цаатан гэсэн энэ үг Тувачуудын төрөлх нутаг болох Тувагийн Бүгд Найрамдах Улстай холбогддог холбоосыг тасалдаг. Зарим Тувачууд бид Монголын бусад ястангуудыг тэдний хариулдаг малын нэрээр нь нэрлэхгүй найрсаг зантай хүмүүс гэж хэлж байлаа. Жишээлбэл тэд нэлээд том ястан болох Дархадуудыг “сарлаг дагадаг хүмүүс” гэж орчуулагдах нэрээр дууддаггүй билээ.

Одоогийн байдлаар “Цаатан” гэсэн нэрээр бусад Тувачууд доромжлуулаагүй байгаа гэнэ. “Бидний цаа буга биднийг бусдаас ялгадаг” гэж Баяндалай хэлдэг. Өөр Тувачууд байдаг, харин манай цаа буга биднийг ийм нэртэй болгосон. Ямар ч Тувачууд өөр нэрээр нэрлэгдээгүй байгаа ба тэднийг гадныхан “Дука” гэж нэрлэдэг.

Нэр өгөх заншил

Монголд анх Тувачуудыг ирэхэд тэд тувачуудыг ялгаварлан гадуурхахгүйн тулд өөрсөдтэйгөө адил болгохыг бага багаар хичээж байсан. Ийм шалтгааны улмаас Тувачуудын эхний үеийн олон хүмүүс Монголд төрж монгол нэртэй болжээ. Тувачуудын онцлог шинжүүд Монголчуудтай маш төстэй болохоор цаатан малчид хүүхдүүддээ тува нэр өгөхгүй байх нь өв соёлоо маргагнахад хангалттай нөлөөлөх байв. Одоогоор Тувачууд хэдэн үе Монголд амьдарсан тул тэд өөрсдийн соёл ёс заншлаа үргэлжлүүлэх итгэлтэй болсон бөгөөд хүүхдүүддээ тэд дандаа тува нэр өгдөг.

Тэд хүүхдүүддээ янз бүрийн байдлаар нэр өгдөг ба заримдаа нэрсийн жагсаалт гарган энэ жагсаалтаас өгөх нэрээ сонгоно. Эсвэл бичигдсэн нэрсээс сугалж тэр нэрийг өгнө. Бусад тохиолдолд хүүхдийн угаалга найр хийсний дараа нэрийг нь өгдөг. Хүүхдүүд эцгийнхээ нэрээр овоглож, энэ овгийн нэр нь тэдний нэрний өмнө байна. Жишээлбэл эцэг нь Жон гэсэн нэртэй, охин нь Сюзан гэдэг нэртэй байхад энэ охины нэр Жон Сюзан болох ба Жон бол түүний овог юм.

Зүйр үгс

Зүйр үгс бол тухайн соёл ёс заншлын цэцэн мэргэн ухаан ба үнэ цэнийг илэрхийлсэн үг хэллэг юм. Тувагийн хоёр зүйр үгийг бичив.

1. Хүн ахтай Дээл захтай (Тувагийн ёс заншлын чухал зүйл бол хүндлэл ба хүмүүс өөрөөсөө ахмад хүнийг “ахаа” “эгчээ” хэмээн хүндлэн дууддаг. Түүнчлэн дээлийнхээ зах, ханцуйг хүндлэх ёстой ба хэрвээ дээлийн эдгээр хэсгүүд дээр гишгэвэл бүдүүлэг хэрэг болно. Мөн дээлээ нөмөрч хэвтэхдээ захыг нь толгой тал руу харуулдаг)

2. Хэн нэгэн хүн байнга залхуурч суувал тэр хүн мөнгө олж чадахгүй. (хэрвээ та дандаа унтаад хэвтээд байвал таны амьдрал аз жаргалгүй болно)

Дуунууд

1. 2 настай цаагаар
Үүстэй Жамсаа руу явцгаая
3 настай цаагаар
Хүүлэг Жамсаа руу явцгаая

2. Тандий ба Саяаны уулсын завсраар
Үлэг-Хэм урсгал гол минь бий
Үргэлж бид бидний нутаг Тувагаа
Санан санан дурсана

3. Хойд Тайга (Сибирь)
Миний нутаг
Уудам онгон хүйтэн газар
Хойд Тайгийн ах дүүгээсээ сураг сонслоо
Тэд сайн сууж байгаа гэнэ

Хойд Тайга
Миний нутаг
Уудам онгон хүйтэн газар
Хойд Тайгийн ах дүүгээсээ сураг сонслоо
Тэд сайн сууж байгаа гэнэ

Би тэднээс сураг сонслоо
Тэд сайн байгаа гэнэ

Эдгээр гурван дуу зөвхөн Тува дуунууд. Эхний дуу нь Тувагийн мал цаа бугын тухай, хоёр ба гурав дахь дуунууд хайр сэтгэл, эх нутгаасаа алс хол байгаа хүмүүсийн төрөлх нутгаа санан тэмүүлсэн тухай дуу юм.

Баяр ёслолууд

Наадам бол Монголын их баяр “эрийн гурван наадам” болох нум сумын харваа, хурдан морьдын уралдаан, бөхийн барилдаан бөгөөд мөн Тувачуудын том баяр юм. Өөр нэг том баяр бол Сарны буюу Билгийн тооллын шинэ жил Цагаан сар бөгөөд Тувачууд энэ өдрийн өглөө ширээ тойрон цугларч хонины махтай баярын зоог барьж тэмдэглэдэг. Есдүгээр сард Цаатан наадам хийдэг ба энэ наадмын тухай 2007 онд гадаадынхан олж мэдсэн байна. Энэ наадмын өдөр ууланд авирах, цаа буга, морины уралдаан, яруу найргийн уралдаан, гар урчууд, сийлбэрчидийн үзэсгэлэн, дуучдын тоглолт болдог.

Гар урлал ба бэлэг тэмдэгүүд

Гар урлал ба гоо үзэсгэлэнт зүйлс бол Тувагийн соёл ёс заншилд чухал үүрэгтэй. Өнгийг ихээхэн анхаарч үздэг. Заримдаа мөнхийн амьдралыг бэлэгдсэн хоорондоо холбоотой очир алмаасуудаар хийсэн оёмол тэмдгээр урцыг чимэглэнэ. Урцын дотор талыг цэцэг хатгамалсан дэрнүүдээр чимэглэдэг. Тува охид эмэгтэйчүүд социализмын үеэс эхлэн хатгамал хийдэг болсон бөгөөд тэд өөрсдөө гараараа хээ хуар зурж дараа нь түүнийгээ битүүлэн хатгамалдаг.

Сийлбэрчид хагсуурга модны үндэсний голын зөөлөн хэсгийг хутгаар ухаж аваад

гаанс хийдэг ба энэ гаансаар тамхи эсвэл хагсуурга модны нунтагыг татна. Мөн тэд цаа бугын унасан эврийг сийлбэрлэдэг.

Намар есдүгээр сард цаа бугын эвэр үсэн бүрхүүлээ хаяж хавар гуравдугаар сард эвэр нь унана. Унасан эврийг авч дээр нь хээ хуар зураад хөрөө хуурай ашиглан сийлбэр хийдэг. Эдгээр сийлбэрээ нутгийн иргэд, жуулчдад зарж борлуулдаг ба гар урлал бүр өөр өөр загвартай. Нэмж хэлэхэд сийлбэр хийх нь тэдний чухал ажил юм.

Тувагийн соёлд гол зүйл бол өнгө. Цэнхэр өнгө нь тэнгэрийн өнгө учраас хүндэтгэлийн өнгө, цагаан өнгө ариун нандин, цэвэр ариун байдал, эхийн сүүг илэрхийлсэн утга төгөлдөр өнгө юм. Хар өнгийг нүгэл хилэнцийн илгээсэн муу сүнсний зэвүүцэл төрүүлдэг гэж үздэг.

Тоонууд

Тувагийн соёл заншилд тодорхой тоонуудыг эрхэмлэдэг. Гурвын тоо бол хүчирхэг тоо гэж үнэлэгддэг бөгөөд тэд хүнд юмыг өргөхдөө тоо тоолж гурвын тоон дээр өргөнө. Зуухтай болохоосоо өмнө тулгын гурван чулуунд гал түлдэг байсан. Долоогын тоо мөн онцгой юм. Бөөгийн хүч чадал нас барснаас нь хойш гурав, долоо, есөн (гуравт хуваагддаг тоонууд) жилийн дараа дахин ирдэг байж магадгүй гэж зарим хүмүүс итгэдэг. Энэ хугацаа нь шинэ бөө хүч чадлыг өвөлж аваад хүч чадлаа хэр зэрэг удаан хадгалах вэ гэдгийг тодорхойлно. Хэрвээ хэн нэгэн хүн бөөгийн хүч чадлыг өвлөж авахдаа бөөг нас барсны дараа гурав, эсвэл долоон жилийн дараа авахад түүний хүч чадал зөвхөн гурав юмуу долоон жилийн дараа дуусна гэж зарим нь үздэг.

Харин есөн жилийн дараа авахад бөөгийн хүч чадал үүрд үлдэнэ.(Гэсэн хэдий ч бөө Гоост гуай өөрийнх нь хүч чадал түүний нас барснаас хойш гурван жилийн дараа эргэн ирнэ гэж тодорхойлсон ба энэ нь түүний хүч чадлыг авсан шинэ бөөгийн хүч гурван жилийн дараа үгүй болно гэсэн үг) Мөн гучин зургаа ба гучин есөн ариун ургамал байхад эдгээр нь гурав дахин үржинэ хэмээн итгэдэг байна.

Нийгмийн бүтэц

Отог аймаг ба тэдгээрийн байршил

Тувачууд отгуудад хуваагддаг бөгөөд тэд бүгд ёс заншлын хувьд ижил, отгууд хэмжээгээр адил. Соёон, Балапш, Үрүд, Хэмжиг, Жоод зэрэг отгуудтай.

Отгийнхоо хүнтэй гэрлэдэггүй, өөр отгийн хүнтэй гэрлээд хоёр талынхаа нэрээр үлдэж гэрлэсний дараа эхнэр юмуу нөхрийнхөө аль алины отогтой нийлж болохгүй. Мөн Тувачууд Баруун ба Зүүн байрлалд Шишгэдийн голоор зааглагдаж хоёр хэсэг хоорондоо ойролцоогоор 100 километрийн зайтай оршино.

Гэр бүл

Олон ам бүлтэй байх нь Тувагийн заншил. Эхнэр нөхөр хоёулаа олон хүүхэдтэй байхыг хүсэх ба хүүхдүүдийн зарим нь гэрлээд эсвэл ажил хийхээр явж отгоо орхих үед доод тал нь нэг юмуу хоёр хүүхэд гэртээ үлдэж эцэг эхдээ хань болж тэдэнд тусалдаг. Хүү охин тэнцүү доод тал нь дөрвөн хүүхэдтэй айлыг хамгийн тохиромжтой гэр бүл гэж үзнэ.

Гэрийн ажлыг хүйсийн байдлаар хуваан хийдэг. Эмэгтэйчүүд гэрийн “доторхи” ажил буюу хүүхдээ өсгөх, хатгамал хатгах, хоол хийх, юм угаах ажлыг гүйцэтгэнэ. Тэдний хийдэг гадаах нэг ажил бол мал саах. Эрчүүд “гаднах” ажил болох мод хөрөөдөж хагалах, ан хийх, цаа бугаа хариулах ажил хийнэ.

Тувачууд хүүхдүүдээ эелдэг, хичээнгүй, хүн хүндэлж хайрладаг, ажилсаг, тууштай,

өөрөө өөртөө үнэнч хүн болгож өсгөн хүмүүжүүлдэг. Сайн хүн найзалж нөхөрлөхдөө амархан байдаг гэж тэд ярина. Олон найз нөхөдтэй байгаа нь зөв замаар явж байна гэсэн үг гэдэг. Тэдний амьдралын үнэ цэнэ, баялаг уламжлал аман яриагаар ирээдүй үедээ өвлөгддөг.

Шашин

Бөөгийн шашин

Тувачууд бөөгийн шашинтай хүмүүс. Энэ шашин бол хүн байгал хоёрын хоорондын харилцаа холбоо гэж тэд тодорхойлно. Гол, нуур, булаг шандуудыг чухалчилж үзэх нь усыг амьдралын эх булаг гэж үздэгтэй холбоотой. Чингэс хаан бөө байсан ба энэ шашныг Буриад, Оросын зарим нутаг, Өвөр Монгол, тэр байтугай Америкт дэлгэрүүлсэн гэж зарим Тувачууд итгэнэ.

Бөө нар бусад шашныг хүндэлдэг байхад социалист төр засаг тэдний итгэл үнэмшилийг зориуд хориглож байв. Тэр үеийн эрх мэдэлтнүүдийн тушаал заавраар хүмүүс овоо болон бусад ариун нандин зүйлсийг устгасанд бөө нар их зовж шаналсан. Социализм бол та нарын аврал учраас бөө нар шашны үйл ажиллагаа явуулж болохгүй гэж эрх мэдэлтнүүд тушаасан ба үүнийг дагаж мөрдөөгүй хүнийг алж устгадаг байжээ. Бөө нар бөөгийн зан үйлээ хийж чаддаггүй байсан тэр үед Ганзоригын аав шөнийн цагаар нууцаар шашиндаа залбирдаг байсан хэмээн тэр дурсан санаж байна.

Бөө нар

Тувачуудын амьдралд бөө нар чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэд бөө, удган нар юм. Тэд хүмүүсийг эмчилж, засал хийж, уулс болон өвөг дээдэстэй холбоо тогтоодог. Бямбасүрэн бол Тувагийн бөөгийн ертөнцтэй их дотно холбогдсон Дархад эмэгтэй. Нэг удаа нэг бөө түүнийг нас барсан өвөг эцгийн сүнстэй уулзахад нь тусалсан ба түүний 38 настай нөхөр нь одоо хүмүүст тусалдаг бөө хүн юм.

Бямбасүрэнгийн нөхрийн өвөг эцэг нь бөө хүн байсан. Түүнийг нас барахад түүний цан хэнгэрэг, бусад өмсгөл хэрэглэлийг нь үүрд амгалан нойрсох ууланд тавьсан боловч түүний хүч чадал тэр үед 30 настай байсан Бямбасүрэнгийн нөхөрт өвлөгдөн ирсэн ба тэр бөө болно гэдгээ мэдээгүй байсан. Түүнийг эцэг эх нь ямар өвчнөөр шаналж байгааг нь мэдэж чадахгүй тийм өвчтэй залуу байв. Хэдийгээр бусад хүмүүс бөөгийн шүтлэгтэй байсныхаа төлөө социалист эрх мэдэлтнүүдэд алуулахаас айдаг үе байсан ч түүний эцэг эх түүнийг өвөг эцэгт нь өгсөн бөгөөд тэр бөө бөөлөх ёслолд суралцаж чадсан. Гэсэн хэдий ч эцэг эх нь хүүгээ нэг өдөр бөө болно гэж төсөөлдөггүй байв.

Бямбасүрэнгийн нөхөр өвөг эцгээ нас барахад дахиад өвчилсөн бөгөөд энэ өвчний шалтгаан нь өвөг эцгийн хүч чадал түүний биед орохыг хичээж байсан явдал юм. Тэр үүнийг эхлээд ойлгохгүй байсан тул Улаан-Уул сумын эмч нарт үзүүлсэн боловч тэд түүний өвчнийг оношилж чадсангүй. Эмч нар түүнийг Мөрөн явж эмнэлэгт үзүүлэхийг зөвлөсөн боловч тэр яваагүй гэнэ. Тэгээд тэр өөрийгөө үнэндээ өвчтэй биш, ердөө өвөг эцгийнхээ бөөгийн хүч чадлыг өвөлж авч буйгаа ухаарсан ба энэ бол түүний үүргийг биелүүлж эхлэх цаг болсон байлаа.

Бөөгийн хүч чадал хэзээ ч зүгээр алга болдоггүй учир дандаа хэн нэгэн хүн өвөлж авдаг. Энэ хүч чадал голдуу дараагийн хойч үед очдог боловч зарим хүмүүс үе алгасаж очдог гэж хэлдэг. Бөө бүхэн хүүхэдтэй байх хэрэгтэй ба тэгээд тэдний ач нар бөөгийн хүч чадлыг нь авч чадна. Гэхдээ бөөд үр хүүхэд байхгүй бол бөөгийн хүч чадал өөр нэгэн хамаатанд очдог гэж Бямбасүрэн боддог. Түүний нөхөр өвөөгийнхөө хүч чадлыг авахдаа бөө Гоост гуайн заавар зөвлөгөөг авч бөөгийн ур чадварыг хөгжүүлжээ.

Тэр амьтдын сүнстэй холбоо тогтоох үед шар шувуу, баавгай, бугын дуу авиагаар ярьж, эрэгтэй эмэгтэй өвөг дээдэс нь түүгээр дамжуулан ярихад тэдний дуу хоолойгоор ярьдаг. Тэр сард нэг удаа бөөлж, мөн хүмүүст түүний тусламж хэрэг болох үед, зарим нэгэн тодорхой өдрүүдэд өвөг дээдэстэйгээ уулзаж бөөлнө.

Бямбасүрэнгийн хэлснээр Тувачуудад эмч нар, бөөгийн аль алиных нь тусламж хэрэгтэй байдаг. Эмч нарын эмчилж чадахгүй байгаа монгол болон зарим гадаад хүмүүсийг бөө нар эдгээдэг. Яс хугарах ба бусад гэмтлийн үед эмч нарын тусламж хэрэгтэй байдаг боловч хэн нэгэнд ямар нэгэн ойлгомжгүй асуудал үүсэхэд бөө тэдэнд тусалдаг байна.

Бөө нар хүмүүст туслахдаа байгалиас гаралтай тодорхой эд зүйлсийг ашигладаг. Тэд бөөлөхийн өмнө хийдэг угаалгын ёслолдоо хэрэглэх усыг ариутгахдаа хатааж нунтагласан цэцэгс ариун бөгөөд цэвэр байдаг тул усандаа хийж хэрэглэнэ. Бөөгийн цан хэнгэрэг ба бусад хувцас хэрэглэл их чухал юм. Тиймээс Бямбасүрэн нөхрийгөө эзгүй байхад тэдгээр зүйлүүдийг орхиж болохгүй. Яагаад гэвэл эдгээрт хүн хүргүүлэхгүй байх ёстой учраас тэр харж байх үүрэгтэй ба бөөгийн эдгээр зүйлсийг урцныхаа хамгийн хүндтэй ариун хэсэгт байрлуулна. Бөөгийн цанг согооны арьсаар хийдэг. Бөө бөөлөхөд цан хэнгэрэг тэднийг хөх тэнгэртэй холбож, цанг хийсэн амьтны арьсаар дамжин бөөгийн онгон бууж ирдэг. Бөөгийн өмсгөлийг цаа бугын арьсаар хийж могойн арьс болон модоор чимэглэнэ.

Бямбасүрэнгийн нөхөр хүч чадал онгоноо хүндэлдэг учраас жуулчдад бөөлдөггүй бөгөөд хэрвээ тэр үүнийг хийвэл хүч чадал нь үгүй болно гэж үздэг байна. Түүнчлэн, тоглоом мэт үзэж шүтээнээ бузарлах ямар нэг буруу юм хийвэл тэр олон түмний уур хилэнг хүртэх болно. Заримдаа хүмүүс бөөгийн шашныг буруугаар хэрэглэж гэм нүгэл хийх явдал гардаг. Бямбасүрэн хүмүүс бөө дээр ирэхдээ шоу үзэх гэж ирэхэд дургүй бөгөөд харин жинхэнээсээ тусламж хүсэж ирсэн хүмүүст туслах нөхрийгөө хараад баяртай байдаг.

Нэгэн бөөгийн тухай

Эцэг эх нь Монгол руу цагаачлахаар шийдсэний яг дараа 1947 онд бөө Гоост төржээ. Тэр үед Тувачууд цөөхүүлээ, Дархадуд тооны хувьд нэлээд илүү байсан болохоор тэд Дархад ястаны зүгээс ихээхэн дургүйцэлтэй тулгарсан. Тувачуудад хувийн мал хөрөнгө байхгүй байсан учраас амьд үлдэхийн тулд Дархадудад ажиллахаас өөр аргагүй байжээ.

1977 онд Гоостын амьдралд өөрчлөлт гарчээ. Түүний аав бөө байсан бөгөөд нэг өдөр хүүгээ суулгаад түүнд зориулж бөөлсөн. Маргааш нь Гоост өөрийгөө шинэ хүч чадалтай болсоноо мэджээ. Ингээд түүний гэр бүлийн есөн үеийн бөө нар шиг тэр мөн бөө болсон. Түүнээс хойш гучаад жил түүний тусламжийг хүссэн хүмүүсийг эмчилсээр иржээ.

Хэрвээ та надад итгэвэл та эдгэрэх болно. Та итгэх хэрэгтэй-Гоост

Гоост хүмүүсийг эдгээхдээ бөөлж, бас мөнхийн ногоон ариун арц агуулсан гучин зургаан ургамлын холимогыг хэрэглэнэ. Бөөлөхийн өмнө тэрээр “бөөгийн хоёр нүд” хэмээн өөрөө нэрлэдэг Долоон бурхан одонд мөргөж залбирдаг. Түүний бөөлөх нь их хүндэтгэлтэй бөгөөд тодорхойлж хэлэхэд хэцүү юм. Алтан гадас од бөөгийн эмчилгээ хийхэд бас их чухал. “Хэн нэгний амьдралд муу зүйл тохиолдвол би түүнийг хардаг” гэж тэр хэлэх ба “муу зүйл зайлах болно” гэдэг. Эмчлэхээс гадна түүнд өөр чадварууд байдаг. Жишээлбэл, хүн зочилохоор ирж буйг шувууд түүнд хэлэх гэх мэт.

Тэр гайхалтай чадвартай ч даруу төлөв хүн. Авьяаслаг хэдий ч хэзээ ч өөрийгөө бүхнийг чадна гэж боддоггүй. Ухаалаг хэдий ч бүхнийг мэднэ гэж ов заль гаргадаггүй. “Энэ үнэн эсэхийг би мэдэхгүй, хүмүүс ярихдаа бурхан дэлхий ертөнцийг бүтээсэн гэдэг. Хүмүүс яаж залбирах хэрэгтэйг би мэдэхгүй. Хүн нас барсаныхаа дараа хаашаа очдогыг

би бас мэдэхгүй. Би бол лам биш, би бол бөө хүн” гэж тэр ярина. Гоост гуай дундыг баримталдаггүй хатуу зантай хүн ба Улаанбаатрын хуурамч бөө нар шиг хүмүүсийн хүссэнээр нас барсан хүний сүнсийг дуудаж чадахгүй гэнэ.

Мөн тэр түүний туслалцаа хэрэг болсон хүмүүсийг ялгаварлаж харьцахыг хүсдэггүй. “Тувачууд, Америкчууд, Монголчууд-бид бүгдээрээ хүн. Энэ бол миний зарчим” гэж тэр ярина. Иймээс ч тэр өөрөө арга цусны даралт ихдэх өвчтэй байсан хэдий ч аудитм гэдэг мэдрэлийн өвчтөй хүүхдээ эмчлүүлэхээр Америкаас ирсэн хосод туслахаас татгалзаагүй юм. Тэр хүүхдийн эцэг энэ явдлын тухай дурсамж ном бичиж хэвлүүлсэн боловч ном бичиж байгаа тухайгаа Гоост гуайд хэзээ ч хэлээгүй байжээ. “Миний тухай номонд бичсэн байсныг энэ тухай чи надад хэлж буйтай адилхан гадаадын хүмүүс энд зочилж ирээд хэлэхэд л би зөвхөн мэдсэн” гэж тэр хэлсэн юм. Энэ ном алдартай болсон учраас Улаанбаатарт зарим нэгэн хуурамч бөө нар Гоост хэмээн худал хэлж жуулчдад хуурамчаар бөөлөөд мөнгө олж байна. Түүний эмчилсэн хүүгийн эцэг эх хүүхдийнхээ эрүүл мэндийн байдлын талаар түүнд мэдэгдэж хүүгийн зурагнуудыг илгээж байна гэж амласан боловч Гоост гуай одоогоор аваагүй байгаа.

Тэр эцэг эхийн зан чанарыг үл харгалзан хүүхдийнх нь сайн байгаа эсэхийг Гоост гуай сонирхсоор байлаа. “Тэд намайг мартжээ. Би тэднийг ойлгохыг хичээх боловч би чадахгүй байна. Би өөрөө өвчтэй байсан хэрнээ тэдний хүүхдийг эмчилсэн. Би олон хүнд тусалмаар байна, гэхдээ би чадахгүй байна” гэж тэр ярилаа.

Нэг жилийн өмнөөс түүний цусны даралт нэлээд ихсэж бөө буухаа болих хэрэгтэй болсон бөгөөд өөр ажил хийх нь түүнд бас хэцүү байв. Цусны даралт ихдэх өвчний үе шатаас шалтгаалан түүний гар үе үе мэдээгүй болдог ба зүүн талаараа хөдлөхөд бэрхшээлтэй байгаа гэж тэр хэлсэн. Түүнд зүү тавиулах эмчилгээ эсвэл европ эмчилгээ хийлгэх хэрэгтэй гэж тэр боддог. Тэр эмчилгээний олон төрлүүдийг үнэлэн үздэг өргөн ойлголттой бөгөөд европ эмчилгээ их сайн гэж ярина. Эмнэлгийн ажилчидыг бөөгийн бөөлөх ёслолыг шоу, бөөгийн эмчилгээг бизнес болгодог хуурамч бөө нар шиг битгий хуурч мэхлээсэй гэж тэр хүсдэг. Улаанбаатрын зарим бөө нарын тэр санааг тэр гайхаж жигшинэ. “Бөөгийн цан хэнгэрэг, өмсгөлийг тэдний гэрээс зөөж авч явж болдоггүй, машинаар авч явж байхдаа тэд дээр нь гишгэж болзошгүй учраас тэдгээр зүйлийг Улаанбаатар луу зөөж болохгүй. Ийм ариун нандин зүйлсээ хот руу зарсан бөө үүний үр дүнд одоо өвчтэй болсон гэдгийг би мэдэж байна” гэж Гоост гуай тайлбарлана. Бусад бөө нар болон Гоост гуайг нас барсаны дараа л тэдний ариун нандин зүйлсийг гэрээс нь зөөхийг зөвшөөрнө гэдэг бол үнэн юм. Түүнийг нас барсаны дараа түүний бөөгийн хүч чадал хойч үе болох түүний хүүхдүүдийн хэн нэгэнд эсвэл ач охин, ач хүүд нь өвлөгдөнө. Түүгээр ч үл барам, тэр нас барсан хэдий ч Гоост хэзээ ч жинхэнээсээ явахгүй. “Би нас бараад гурван жилийн дараа миний сүнс эргэж ирнэ” гэж тэр тайван өгүүллэн.

Шүтээн ба байгалийн онгод шүтээн

Тувачууд бөөгийн шашинд шүтээн их чухал. Хөх Тэнгэр бол дэлхий ертөнцийг бүтээхэд онцгой үүрэг гүйцэтгээгүй ч, хүн төрөлхтөний үүслийг түүнд болон өөр бурхан сахиусанд хамааруулж үздэггүй Тувачууд Тэнгэр бол бусад бүх зүйлээс өмнө оршиж байсан гэдэгт итгэдэг. Тэр ч байтугай Тэнгэр бол хүн төрөлхтөний эцэг, газар дэлхий бол эх нь юм.

Мөн Долоон бурхан одыг шүтэх ба сардаа нэг юмуу эсвэл хоёр удаа мөргөн залбирна. Тэд ододтой ярилцан, залбиран гуйж, цайны дээжээ өргөж арц уугиулна. Цайны дээж өргөсний дараа тэнд байгаа бүх залбирагч хүмүүс үлдсэн цайг хувааж уудаг.

Мөргөл залбирал

Бөөгийн шашны чухал хэсэг бол мөргөл залбирал бөгөөд хүмүүс ерөнхийдөө эрүүл мэнд,

аз жаргал, байгал орчин, байгал орчинтой зөв зохистой харьцах, сайхан амьдралын төлөө залбирдаг. Бөөгийн шашинтангуудад залбирал бол адис ерөөл хүртэхээс илүү зүйл юм. Энэ нь хүн ба бусад зүйлсийн хоорондын харилцаа холбоо, бүх амьдралын нэгдлийн баталгааны илэрхийлэл юм. Мөн тэдэнд уулс, рашаан булгууд, голууд, амьтад их дотно зүйлүүд болдог.

Мөргөл залбиралгүйгээр бид оршин тогтохгүй-Баяндалай

Мөргөл залбирал хийх тусгай өдөр байхгүй. Алслагдсан хөдөө газар амьдардаг болохоор бөөгийн шашинтангууд байгал дэлхийдээ эсвэл ойролцоох гол мөрөнд сүү цайныхаа дээжийг өргөж ямар ч үед мөргөж залбирдаг. Тэд аль нэгэн уулыг зүрх сэтгэлдээ шүтдэг бол сүүний дээжээ гурвантаа өргөж арц уугиулж аврал гуйн залбирна. Заримдаа тэнгэр лүү ба одод луу залбиран мөргөнө. Эрчүүд ан хийгээд агнасан амьтан болон ан хийсэн газрынхаа онгод шүтээнээс уучлал гуйж, тухайн агнасан амьтны нэрийг дарууханаар дуудаж “намайг өршөөгөөрэй” хэмээн чимээгүйхэн гуйдаг. Тэгээд анчин арц уугиулж нар зөв дагуу биеэ гурван удаа тойруулан утаж, алагдсан амьтныг хүндэтгэн цайны дээжээ өргөнө.

Хойд нас

Хойд насны тухай олон янзын итгэл үнэмшил Тувачуудад байдаг. Зарим нь үхсэний дараах амьдралд итгэхгүй бөгөөд зарим нь хойч үеийнхээ сайн сайхны төлөө сайн зүйлс хийх хэрэгтэй хэмээн итгэнэ. Бусад Тувачууд Тэнгэр ба Тамд итгэнэ. Тувагийн Тэнгэр бол хэрвээ хэн нэгний сүнс хар зурвасаар дайрч өнгөрөх боломжтой бол түүгээр өнгөрч, тэгээд алтан хашаанд хүрэх тийм газар гэж итгэдэг. Харин Баасанхүүгийн төсөөллөөр ногоон уулстай, мөнхийн ногоон мододтой, жижигхэн байшингуудтай, бас нохойнуудтай. Тувагийн Там бол харанхуй нөмөрсөн газар. Тэнгэрт итгэдэг зарим хүмүүс нас барсаны дараа газар шороонд оршуулахад хүний сүнсийг буга тэнгэрт аваачдаг гэж итгэнэ.

Бусад нь буга ийм үүрэг гүйцэтгэдэг гэж ер сонсоогүй гэх эсвэл үүнийг Христийн шашны (дэлхийн том шашин) итгэл үнэмшил гэж үздэг байна. Өвөг дээдэс болон хувирч ард түмнээ хамгаалах үүрэгтэй бөө нарт л зөвхөн нас барсаны дараах хойд насны амьдрал байна гэж зарим Тувачууд боддог.

Хүрээлэн буй орчин

Байгал орчин

Тувачууд хэлэхдээ бид төр засгийн оролцоогүйгээр, бардам зан ба зөв бурууг хослуулан байгалдаа амьдралаа зохиосоор байгаа гэдэг. Тэднийг эцэг эх нь болсон байгал дэлхий өсгөж хүмүүжүүлсэн ба тэдний эцэг бол Тэнгэр, эх бол уулс, газар дэлхий, ус юм. Тэр ч байтугай, бөөгийн шашингүй хүмүүс хүртэл байгал эхийн ариун нандин зүйлсээр хүрээлүүлэн байдаг. Тэд байгал дэлхийгээ үл хүндэлсэнээс үүсэх хор уршгийг ойлгож мэдэхгүй байгаа байдалд нь байгал дэлхий хариу ял тулгах тэр үед тэд хүнд байдалд орно гэж Тувачууд боддог.

Ариун ургамалууд

Тувачууд гучин зургаа эсвэл гучин есөн ариун ургамалууд байдаг гэж 2 янзаар тайлбарладаг бөгөөд мөнхийн ногоон, арцны төрлүүд, хус мод, хар мод зэрэг нь ариун ургамлын аймагт багтдаг гэдэгт тэд санал нийлнэ. Хүмүүсийг мөнх амьдруулах усыг булгаас зөөж авчирдаг шувууны тухай ардын үлгэрт тэр шувууны ус дусаасан модод мөнх ногоон болсон гэж гардаг.

Ан амьтад

Тувачууд олон амьтдыг ариун хэмээн хүндэтгэнэ. Адуу бол ариун амьтан, яагаад гэвэл сайхан бөгөөд үнэнч. Буга бол байгалийн нууцлаг амьтан учраас дархан цаазтай, цаа буга Тувагийн амьдрах аргын түлхүүр нь болохоор ариун бөгөөд бага зэргийн хүнс хоол болдогыг хамааралгүйгээр цаа бугыг хүндэтгэн хайрладаг байна.

“Цаа буга бол хонь, үхэртэй адил биш, маш бага сүүтэй, мах нь бас хангалттай их биш” хэмээн Баяндалай ярьсан юм. Хонь, үхэр амьдарч чадахгүй тийм хүйтэнд цаа буга сайн амьдрах чадвартай төдийгүй түүнд их өвсний хэрэггүй байдаг. Сүү нь төдийлөн их биш ч зарж борлуулахад хангалттай илүү сүү гарна. Түүнчлэн, цааны сүү чанарлаг ба Тувачуудыг дааруулахгүй байлгах 60 хувийн тослог, 40 хувийн сүү агуулдаг.

Айл бүхэн 20-30 цаатай ба хүнсэндээ хэрэглэж, эврээр нь ямар нэгэн урлагийн бүтээл хийж, мөн цааны нуруун дээр ачаа ачих зэргээр хэрэглэнэ.

Тувачууд өвөрмөц урцанд амьдардаг болохоор цаа буга хүнд гэрийн мод зөөх чадваргүй. Тува хэлээр цаа бугын наснаас нь хамаарч цааг нэрлэдэг. Нэг настай цааг “янзага”, хоёр настай цааг “тасман”, гурван настайг нь “дунгуй”, дөрвөн настайг нь “хуйтай”, таван настайг нь “зарь” хэмээн нэрлэнэ. Цаа буга дунджаар 15 жил амьдрах ба голдуу малчид өөрсдийн бүх эр цааг нэг удаа засдаг.

Цаа буга адуу шиг биш ч давхидаг бөгөөд Тувачуудын морины эмээл хоёр оломтой байдаг бол цааны эмээл зөвхөн нэг оломтой. Түүнчлэн, цаанд хазаар хэрэглэхгүй, харин түүний оронд хүзүүнд нь цулбуур хийж унана. Цаанд мордохдоо дөрөө хэрэглэдэггүйгээрээ моринд мордохоос өөр. Зөвхөн гурван настай ба түүнээс дээш насны цааг уналганд хэрэглэнэ.

Бугыг тэнгэрийн амьтан гэж нэрлэх ба тэнгэртэй янз бүрээр холбож ойлгодог. Нас барсан хүний сүнсийг буга тэнгэр лүү зөөж аваачдаг хэмээн зарим нь итгэнэ. Мөн бөөг тэнгэртэй холбодог учраас бөөгийн цанг бугын арьсаар хийдэг байжээ. Түүгээр ч барахгүй, буга залуудаа маш хурдан давхидаг болохоор тэд нисэж байгаа мэт харагддаг гэж ярилцана. Бугыг үхсэний дараа ясыг нь газарт хэвтэж байхыг ихэнх хүмүүс ерөөсөө хараагүй гэлцдэг учраас бугыг нууцлаг, тэнгэрийн ид шидийн амьтан гэж тооцдог байна. Ардын нэгэн үлгэрт буга үхээд шууд ойн модонд шингэн алга болдог хэмээн гардаг. Гэсэн ч тэдний ариун догшин байдлыг үл харгалзан зарим анчид тэднийг агнан хүнсэндээ хэрэглэх явдал бий.

Адуу, цаа буга, бугыг амьтны төрөл зүйлийн хувьд ариун хэмээн хүндэтгэдэг ба заримдаа тодорхой нэг морь, цаа бугыг ариун нандин гэж сэтэрлэдэг. Заримдаа бөө нар сэтэрлэх малыг сонгож өгнө.

Гэхдээ зарим тохиолдолд цаа хүнийг эсвэл ачаагаа тогтмол нуруунаасаа унагаадаг бол ийм цаанд хүмүүс дургүй байдаг. Адуу, цаа бугын сүрэг бүрт нэг нь илүү дархлагдсан байдаг бөгөөд голдуу азарга, засуулаагүй эр цаа дархлагдсан байна. Ингэж дархлагдсан малыг унадаггүй, саадаггүй, бас алдаггүй. Тэднийг ингэж дархалж тайван байлгаснаар тэд байгалийн жамаараа үхэх бөгөөд тэд сүрэгтээ аз авчирч сүргийнхээ бусад малыг хамгаалдаг. Эдгээр дархлагдсан амьтад бусад амьтдыг бодвол доод тал нь таван жилээр илүү амьдарч болох ба ийм адуу гучин таван жил орчим амьдарна.

Хүрээлэн буй орчноо хамгаалах

Байгалийг тахиж шүтсэнээр хүрээлэн буй орчноо хамгаалахыг голлон анхаардаг соёл заншлыг бий болгодог гэж Тувагийн бөө нар итгэдэг. Ан амьтныг агнахдаа тэднээс аль болох ихээр уучлал өршөөл эрж агнана. Агнасан ангынхаа сүнсийг хүндэтгэж унасан газарт нь арц уугиулж, цай өргөнө. Түүнчлэн, хэрвээ буга харагдах байдал нь ялгаатай, өөр санагдвал анчид түүнийг ариун догшины дохио хэмээн үзэж агнахаас татгалзан орхино.

Ийм ариун догшин бугыг хэн нэгэн авлахаар хайж олоход анчины нүд гэнэт өөрөө хаагдаж, юм харж чадахгүй болдог гэж ярилцдаг. Мөн анчид зарим нэгэн амьтдыг авлаж болохгүй гэдгийг зөн зовингоороо мэдэрч тэр амьтныг авладаггүй байна. Нэмж хэлэхэд, бөөгийн эдгээр хамгаалалт зөвхөн амьтдад байдаг төдийгүй зарим онгон догшин газарт мод огтлохыг хориглох ба цаа бугыг ийм газарт бэлчээдэггүй байна. Эдгээрийг зөрчвөл анчин хүн өөрөө бэртэж гэмтэх, гэр бүлийнхэн нь өвдөх, мал сүрэг нь үхэж цөөрөх мэтээр хор уршиг илэрч магадгүй.

Уул уурхайн олборлолт

Ариун догшин газрын баялгыг хүчээр ухаж ашиглахад байгал дэлхийн шийтгэлийг хүлээдэг хэмээн бөө нар итгэдэг. 2008-2009 оны өвөл Баруун, Зүүн отгийн Тувачууд алт ухаж эхлэхэд хоёр хүн нас барсан. Үүнийг байгалиа буруугаар ашигласны хор уршиг хэмээн тэд бодно. Газрын баялгийг ухах нь хэдийгээр нүгэл хилэнцтэй зүйлд тооцогддоггүй ч Тувагийн отгийн нэг ч хүн одоо алт ухахгүй байгаа. Алт хайгчид бага хэмжээний алт газраас авах нь том хэрэг биш хэдий ч хориглож цээрлэвэл зохих сувдаг сэтгэл юм.

Ариун догшин газар

Тувачууд олон уулсыг ариун догшин гэж үзэх бөгөөд эдгээр уулс нь Агаяйн тайг, Агия уул (энэ уулаар Бусийн гол урдаг), Хүрэн тайга, Улаан тайга, Умай Толгой (хөх шиг хэлбэртэй уул), Гурван Умай уул болно. Эдгээр уулсыг хамгаалах тусгай хууль дүрмүүд байдаг ба хэрвээ уулс уурлаж хилэнгэвэл үер бороо орж хүмүүсийг шийтгэнэ гэж боддог. Хүрэн Тайга, Агия уулын орой руу хэн ч авирахгүй бөгөөд бас тэнд ан хийдэггүй. Хүмүүс Умай ууланд очиж арц уугуулж “бидний ариун уул минь надад туслаач” гэх мэтээр хүслээ хэлэн залбирдаг. Агия уул Оросын хилээс нэг километрийн зайд орших ба Дэлгэрдалайгын бөө байсан өвөг эцгийн хувцас хэрэглэл тэнд байгаа учраас энэ бол халдашгүй газар юм. Дэлгэрдалайг 16 настай байхад аав нь түүнийг дагуулж тэр ууланд очоод хэрвээ түүнийг айхгүй байгаа бол өвөг эцгийнхээ хувцасны хажууд унтвал зүүдэндээ түүнтэй уулзана гэжээ. Тэнд маш олон зэрлэг амьтадтай хэдий ч тэр газар түүнийг аавын хамт хамгийн аюулгүй байлгах газар байсан тул тэд тэнд гурав хоножээ. Түүнээс хойш түүнд ямар нэгэн муу юм тохиолдвол цагаан даавуу аван өвөг эцгийн хувцас байгаа тэр газарт очиж тусламж гуйдаг болсон.

Булаг бол бас нэгэн ер бусын газар бөгөөд Дэлгэрдалай тэнд цаагаа бэлчээж болохгүй гэдгийг мэдэж байсан хэрнээ нэг зун цаагаа тэнд бэлчээмээр санагджээ. Тэр өөрийн тунгаан бодох чадвараа үл ойшоосон бөгөөд байгал дэлхий түүнд хариу ял тулгасан. Хэд хэдэн цаа нь үхэж, эхнэр нь олгойн мэс засалд орж, өөрөө хуруугаа зүссэнээс хуруу нь мэдээгүй, хөдөлгөөнгүй болжээ. Тэгээд Дэлгэрдалай эхлээд жуулчдаас Европын эм тос авч дараа нь рашааны ус ууж хуруугаа эмчилсэн. Рашааны ус цэвэр тунгалаг чанартай учир ариун гэж тооцогддог. Ингэж рашаан уусанаар түүний шарх нь задарсан боловч хуруу нь дахиад хөдөлдөг болсон байна.Хэрвээ тэр Европ эм тосыг хэрэглээгүй байсан бол рашаан түүний хурууны мэдрэмжийг буцааж бий болгох байсан гэдэгт итгэдэг. Түүнд тохиолдсон энэ явдал байгал орчноо хайрлан хүндэтгэхийн чухлыг ойлгуулжээ. Мөн Ятга гол ариун догшин учир голд юм угаах, загасчлахыг хориглодог.

Эм

Ургамлын эм

Эмийн ургамлуудыг харанхуйд, эсвэл бороотой үед түүх ба Бурханы нүднээс нуухын

тулд ингэж түүнэ. Тэнгэр цэлмэг байхад, эсвэл өдрийн цагаар гэгээтэй байхад “шууд” түүвэл байгалиа хүндлээгүй хэрэг бөгөөд маш их бороо орно.Өдрийн цагаар эмийн ургамлыг сайн зорилгоор буюу хүн эмчлэх зорилгоор түүх шаардлагатай бол зөвхөн түүж болох зарим ургамлыг түүж болдог. Мөн тухайн эмийн ургамлын анагаах чадварт итгэж үнэмших нь үр дүнг сайн болгоно.

Аньсны навчийг цайнд буцалгаж уухад ханиадыг эмчилнэ.

Алтангагнуурыг (rhodiolaquadrifida)¹⁸ цайнд буцалгаж уухад бэртэл гэмтлийг эмчилнэ.

Арцыг цайнд буцалгаж уухад ханиад томууг эмчилнэ.

Чонын өвс ходоодны өвчнийг анагаана.

Галбашыг цайнд буцалгаж хэрэглэвэл ходоодны өвчнийг эмчилнэ.

Далийн ягаан халуун бууруулна. Энэ ургамлыг гадаа долоо хоног байлгаад түүж аваад өдөрт гурваас дөрвөн цаг цээжин дээр нь тавьдаг.

Арц (Juniperus) усанд буцалгаж хүн, малд уулгахад халуун бууруулна.

Сурнаг бас халуун бууруулна. Түүгээд халуурсан хүний цээжин дээр өдөрт цөөн цагаар тавьж долоо хоногын турш хэрэглэнэ.

Вансэмбэрүү (Saussurea involucrata) цайнд хийж уухад уушигны үйл ажиллагааг сайжруулна.

Ургамлын бүс эм

Гөрөөсний цус ясны хугарлыг эмчлэхэд сайн ба цусыг шууд уух нь хэрэгтэй байдаг.

Баавгайн зүрх хүний зүрхний эмгэгт сайн бөгөөд зүрхний махыг хатаагаад иднэ.

Хэрвээ өвчтөн махыг шууд идэж чадахааргүй хүнд байгаа бол цайнд буцалгаж хэрэглэнэ. Гурван өдрийн дотор үр дүн нь гардаг.

Баавгайн тос хөлдөлтийг эмчлэхэд сайн.

Баавгайн бөөр хүний бөөрний эмгэгт сайн бөгөөд зүрхний махыг хатаагаад иднэ.

Хэрвээ өвчтөн махыг шууд идэж чадахааргүй хүнд байгаа бол цайнд буцалгаж хэрэглэнэ. Гурван өдрийн дотор үр дүн нь гардаг.

Цаа бугын мах цусны даралтыг бууруулна.

Булганы мах хоолойн өвчинд тустай.

Гэмтлийг эмчлэхдээ Гоост гуай даавуун уяа хэрэглэдэг. Согтуу хүмүүс гэрийг нь нураахад гэмтэл авсан Тува эмэгтэйд тэр таван уяа өгч дараа нь сар бүр нэмж таван өөр өнгийн шинэ уяа өгдөг.

Чонын улаан хоолой хүний улаан хоолойн эмгэгийг эмчлэхэд үр дүнтэй байдаг ба махыг хатаагаад идэж хэрэглэнэ.

Чонын махаар хүний хөлийг эмчлэхэд сайн бөгөөд махаар нь таван том хуушуур хийж идүүлнэ.

Чонын ходоодыг хатааж идэхэд хүний ходоодны эмгэгийг эмчилнэ.

Аялал жуулчлал

Онолын дагуу гар урлалын зүйлсийг нь худалдан авч бэлэн мөнгөний орлого нутгийн иргэдэд оруулдаг жуулчдад Тувачууд баярлан талархдаг. Жуулчдыг хүндлэл хүлээсэн ба хүлээхгүй зочид хэмээн хоёр бүлэгт хувааж болно. Хүндлэл хүлээсэн жуулчид Тувагийн соёл ёс заншил, шашинд талархаж, тэдэнтэй хэрхэн харьцах талаар мэдэхгүй зүйлээ асуудаг. Хүндлэл хүлээгээгүй жуулчид цаа бугыг айлгах, Тувачуудыг зургаа авахуулахыг хүсээгүй байхад нь зураг авах,хийж буй аялалдаа мөнгө төлсөн учраас хүссэн зүйлээ

¹⁸ Ургамлын шинжлэх ухааны нэр томъёог хаалтанд хийв.

хийж чадна гэж боддог.

“Жуулчид бидэнд тусалдаг сайн хүмүүс. Бид байгалдаа амьдардаг баян биш хүмүүс. Манайд ерөнхийлэгч ирээгүй байхад гадаадынхан ирдэг. Нэг гадаад залуу гадаадын оюутнуудыг манай энд авчирч соёл ёс заншлаас суралцаж, соёлын солилцоо хийлгэдэг” хэмээн Гоост гуай ярьсан юм.

Жуулчдыг гэртээ байлгахын тулд Тувачууд өөрсдийгөө золиослох хэрэгтэй болдог. “Хуучны цагт бид хорь хоног тутамд нүүдэг байсан ба одоо бид мөнгө олохын тулд үүнийг өөрчилж байна. Баяжихын тулд биш амьдрахын тулд бид жуулчдад зориулж байгаа газраа илүү удах хэрэгтэй болдог. Үнэндээ бол бид ууланд долдугаар сарын сүүлч хүртэл байдаг боловч жуулчлалаас шалтгаалж бид эндээ л байж байна” гэж Баяраа ярьсан.

Ирээдүй

Тувачууд олон зүйлүүдэд янз бүрийн үзэл бодлоор хандаж, ирээдүйдээ итгэх итгэл нь олон талтай. Тэд Монголын ба Оросын Тувачууд Тува биш, харин Монголчууд ба Оросуудтай илүү адилхан болж байгаа, хурдацтайгаар нэг ижил болон өөрчлөгдөж буй ертөнцөд байгаа жижигхэн ястан гэдгээ үл харгалзан соёл ёс заншлаа үүрд үргэлжлүүлэхийг чин сэтгэлээсээ хүснэ. Тэд тэдний үр удам цаа бугаа үргэлжлүүлэн хариулж, урцанд амьдарч, үе үе нүүж, эмчилгээндээ ургамал хэрэглэж, байгал орчноо хамгаалж, бөөгийн шашнаа шүтэж амьдарна хэмээн итгэж найддаг. Тэд тэдний хүүхдүүд хүнээр заалгаж хэлүүлэлгүй, харин өөрсдөө амьдралд оролцон суралцаж, тэдний уламжлалыг хадгалан үлдээхийг хүснэ.

Тувачууд тэдний хэл, тэдний яс үндэс хоёр ижил нэртэй байхыг хүснэ.

Олон үгс, санаанууд ялангуяа нэрс Тува хэлнээс орчуулагддаггүй тул тэдний хэл хадгалан өвлөгдөж, тэдний хүүхдүүдийн сургуульд тува хэлийг хэрэглэж байхыг хүснэ. Ирээдүйд олон ном зохиол Тува хэл дээр хэвлэгдэнэ гэж тэд найддаг.

Тэдний хүүхдүүд сайн боловсрол эзэмших нь их чухал хэмээн тэд бодно. Тувачуудад хүүхдээ дээд сургуульд явуулах эцэцүү асуудал бөгөөд Тувадаа эргэн ирж тэдний залуу үеийг сурган хүмүүжүүлэх хүсэлтэй оюутанд засгийн газар, бусад байгууллагууд, хувь хүмүүсээс тэтгэлэг аван сургахыг хүсч байна. Одоогоор Тува хүүхдүүд долоон наснаас эхлэн сумын сургуульд есдүгээр сараас тавдугаар сар хүртэл суралцах боловч Тувачууд хүүхдүүдээ орон нутгийн сургуульд сургаж байхыг хүсдэг. Ингэснээр хүүхдүүд жилийн турш эцэг эхдээ тусалж байх боломжтой болно.

Тувачуудын цөөн үе сургуульд хамрагдсан хэдий ч тэд сургуулийг үнэлдэг бөгөөд хүүхдүүдээ олон төрлийн мэргэжилд сургахыг хүснэ. Жишээлбэл, ирээдүй үеэс нь Тувагийн орон нутгийн эмч төрнө хэмээн найддаг. Ингэснээр тэд эмнэлгийн тусламж авахын тулд хот руу явах хэрэггүй болох юм. Тувачууд хүүхдүүдээ Өрнөдийн ба Дорнын ертөнцөөс аль алианаас нь суралцаасай гэж хүснэ.

Монголд бид ийм цөөхүүлээ, тиймээс бидний амьдралын хэв маяг аль болох удаан-зуун дамжин үргэлжлүүлэх гэж би хүснэ. Жишээлбэл, бид цаа бугын малчин байх шаардлагагүй. Бид соёл заншлаа хойч үедээ өвлүүлэхийн төлөө энэ замаар амьдардаг. Бид сарлаг, хонь хариулж болно, гэхдээ бид цаатан хүмүүсийг үлдээхийг хүсэж үүнийг хийдэг. Хэрвээ та нар цөөхүүлээ бол соёл ёс заншлаа алдах, байгал, өв уламжлалаа маргахад их амархан-Гоост

Хоёрдугаар хэсэг Дархадууд

Оролцсон Дархадууд

Энэ ажилд оролцсон Дархадуудын нэрс өмнөх бүлгийн Тувачуудын нэрсийн жагсаалттай адил болно.

Басбиш 60 настай
Лувсан 91 настай
Балжинням 77 настай
Дэнсмаа 77 настай
Довдон 82 настай
Сүхээ 44 настай Мөнхбат 42 настай
Насан 53 настай
Должин 74 настай Бадам 78 настай
Жигжий 71 настай
Одхүү 68 настай
Гомбосүрэн 50 настай Даваажав 45 настай
Балбар 41 настай Гэрэлээ 41 настай
Мөнхбат 70 настай
Эрхэмбаяр 51 настай
Даваажав 63 настай Молоожой 62 настай Оюунтуяа 30 настай
Нямрэнчин 42 настай

Дархадын онцлогууд

“Дархад” нэрийн тухай

Дархад хүмүүс хэрхэн “Дархан шавь нар” гэсэн нэрийн товчилсон нэр болох “Дархад” гэдэг нэрийг авсан тухай хоёр өөр түүх байдаг. Домог болохоор түүхүүдийг, Дархад ястангууд хэрхэн сонгогдсон хүмүүс болсон шиг Дархад ястны дүр төрхөд чухал үүрэг гүйцэтгэх түүхүүдийг түүхчид судалж болох юм. “Дархад гэсэн нэр Чингис хааны үеэс бий болсон. Бид Чингис хаан шиг бөөгийн шашинтай учраас тэр ийм нэрийг бидэнд өгсөн бөгөөд тэр манай алслагдсан сайхан нутгийг бахдан гайхаж байсан гэсэн. Чингис хаан “Та нар бол миний Дархан Шавь нар” (сайн сахилга баттай) гэж хэлсэн ба биднийг тагвар төлөхөөс чөлөөлсөн. Тэр бидний үнэнч шударга занг таньж мэдээд өөрийнхөө бие хамгаалагчид болгожээ. Дархад хүмүүс Чингис хааны булшийг Өвөр Монголоос олоод тэд булшийг нь хамгаалж байдаг гэж зарим хүмүүс итгэдэг” хэмээн Одхүү гуай ярилаа.

Лувсан гуай өөр нэг түүх ярьсан юм. “Буддын шашны тэргүүн “Богд хаан” гэсэн хэргэм зэрэгтэй байсан ба Богд хаанаас өмнө бид Чингис хааны хэв загвар бүхий удирдагчидтай байсан. 1924 он хүртэл Богд хаан манай орныг удирдаж байсан. Тэр үед Дархадын хотгорын хүмүүс хамгийн үнэ хүндтэй цагаан морюу унаад Богд хаантай уулзахаар нийслэл хүрээ лүү, түүний ордон луу явжээ. Тэгээд Богд хаан тэдэнтэй уулзаад “Та нар миний Дархан шавь нар байсан” гэжээ. Дараа нь тэдгээр хүмүүс буцаж ирээд Зөөлөнгийн хүрээг барьсан гэдэг. Социализмын үед ихэнх сүм хийдийг сүйтгэж лам нарыг алж устгасан. Зөөлөнгийн хүрээг бүгдийг сүйтгэсэн боловч Буддын шашны

зарим хүмүүс том бурхан шүтээнүүдийг авч тэдгээрийг булж нуусан. Өнөөдрийг хүртэл тэдгээрийг олоогүй байгаа”.

Соёл ёс заншлын ялгаа

Дархадууд өөрсдийгөө бусад Монголчуудаас олон талаар ялгаатай гэж тодорхойлно. Нэг ялгаатай зүйл нь тэдний хэл, Дархад аялга бөгөөд харамсалтай нь энэ аялгын хэрэглээ багассаар байгаа. Насанд хүрэгсэдийн ойролцоогоор 80 хувь нь төрөлх аялгаар ярьдаг ба хүүхдүүд орон нутгийнхаа сургуульд ярьдаг боловч Монгол хэлээр ярьдаг газарт очоод Дархад аялга хадгалж ярьдаггүй. Гэсэн ч тэд Дархад аялгаар ярих боломжгүй байлаа ч тэдний цус, нутаг ус нь байгаа учраас тэд Дархадууд хэвээрээ үлдэнэ гэж өөрсдөө ярина.

Дархад аялга Дархад соёл заншлыг илэрхийлэх “хоё” гэдэг үгийг агуулдаг бөгөөд энэ үг нь Дархад соёл заншлын өвөрмөц хэллэг юм. Иймээс “хоё” гэдэг үг орчуулагддаггүй, зөвхөн Дархад аялганд байна. Энэ үгийн хэрэглээ олон янз. Асуултыг эелдэг байдлаар асуухдаа, мөн тухайн хүнийг хүндэлж буйгаа илэрхийлэн нэрнийх нь ард хэлдэг. Бас ямар нэгэн зүйл хүсэхдээ илүү эелдэг болгож энэ үгийг хэрэглэнэ. Жишээлбэл “Та суугаач хоё” гэнэ. Иймээс тэд энэ үг аль болох удаан хадгалагдана гэж найддаг.

Мөн Дархад аялгаар ярихад тэд бас эелдэг зан төрхөө харуулж Монгол хэлний стандарт үгсийг ашигладаг. Тухайлбал, эхнэрүүд нөхрөө” чи” гэхийн оронд “та” гэж дуудна. Ийм хүндлэх ёсыг илэрхийлсэн дадал зуршлууд Дархадын сайхан соёл заншил их байна. Хүндлэл бол сайхан сэтгэлтэй бөгөөд ажилсаг бүх хүнд тэдний насыг харгалзан хүртээж буй зүйл юм. Нэмж дурдахад, Дархадууд өөрсдийгөө Монголын бусад ястангуудаас илүү тайван дөлгөөн зантай, тэсвэр хатуужилтай гэж тодорхойлдог.

“Халхууд (Монголын хамгийн том үндэстэн) хэн нэгнийг нас барахад маш их уйлдаг. Оршуулах ёслол олон өдрийн дараа дуусна. Харин бидний хувьд арай өөр. Миний захирлаар ажиллаж байсан сургуулийн багш хань ижлээ алдсан тохиолдолд оршуулах ёслолыг өглөө хийхэд үдээс хойш нь сургуульдаа ажилдаа эргэн ирдэг” хэмээн Одхүү гуай ярьсан юм.

Цагаан идээ

Монголын бусад ястны адилаар Дархадууд олон төрлийн цагаан идээг байгал орчинтойгоо хандах өвөрмөц харьцаан дээр тулгуурлан бэлтгэдэг ба жил бүрийн есдүгээр сард болдог цагаан идээний үзэсгэлэнд хийсэн идээгээ үзүүлж харуулах, бусдын хийсэн зүйлийг суралцахаар оролцоно. Хүйтний улирал урт учраас тэд голдуу өрөм хураах ба Говийн малчид шиг халуун орчинд тэмээний хоормог амархан хийдэгтэй адилгүй юм. Мөн бусад ястангууд үхэр, хонь, ямааны сүүгээр цагаан идээ бэлддэг бол харин дархадууд эдгээр амьтдаас гадна сарлагын сүүгээр бэлддэг байна.

Дархадууд өөрсдийн хийсэн цагаан идээгээ зарж ашиг олдог. Тэд бусад монголчуудад ба гадаадынханд ааруул зардаг төдийгүй Дархадын цагаан идээг худалдаж авахаар Улаанбаатраас хүмүүс ирдэг.

Дархадын цагаан адуу

Чингис хааны үеэс эхлэн үнэлэгдсэн Дархадын цагаан адуу тэдний гол бахархал юм. Монголын бүх цагаан адууны ихэнх нь Дархадын хотгорт байх ба эдгээр адуу үнэнч, хайр даадаг, сайхан үзэсгэлэнтэй. Дайны үеүүдэд унаж хэрэглэдэг байсан бөгөөд одоо жил бүр наадмын үеэр есөн цагаан мориор төрийн тугийг залж байрлуулдаг. Түүнчлэн, хурим эхлэхийн өмнө хүргэний гэр бүлийнхэн хүргэний хамтаар есөн цагаан морьтой очиж бэрийг гэрээс нь авчирдаг уламжлалтай. Бэр нөхөрт гарч байгаа болохоор нэг цагаан морийг унаад хүргэнтэй хамт явна.

Мөн цагаан гүүний сүү эмчилгээний чанартай учир элэгний өвчтэй болон элэгний хавдартай хүнд уулгана.

Ялгаварлан гадуурхагдах

Жижиг ястаны хувиар Дархадууд гадуурхагддаг. Хүүхдүүд шиг атгаг санаатай тэмцэлддэг байснаа олон Дархадууд санадаг бөгөөд Дархад аялгаар ярьдаг гэж хавчиж мөшгөдөг байв.

“1950 онд дөрөвдүгээр ангиас дээш сурах орон нутгийн сургуульгүй байсан болохоор Халх сургуульд орсон ба бичгийн алдаа байнга хийж надад нэлээд хэцүү байсан. Яагаад гэвэл миний ар талынхан бүгд Дархад аялгаар ярьж бичдэг. Бусад хүүхдүүд намайг гоочилж,” Дархад хүү” гэж дуудан шоолдог байсан учраас би сургуулиас гурван удаа оргож байсан.

Би Дархадын орон нутгийн сургуульд сурч байхдаа надад уурлан чавхаар харвах хүртэл нэг Тува хүүхдийг шоолон “цаатан хүү, цаатан хүү” гэж дуудан шоолдог байлаа. Дараа нь би гадуурхагдах хэцүү гэдгийг ойлгосон юм. 1965 оноос хойш бүх Монголчуудын эх оронч үзэл улам их дэлгэрсэн” хэмээн Одхүү гуай яриу.

Энэ эх оронч үзэл ялгаварлан гадуурхагдах явдлыг багасгахгүй байна гэж зарим нь боддог.

Нийгмийн бүтэц

Дархадууд ба Монголын Засгийн Газар

Засгийн газрын ажлын үр дүнгийн талаар Дархадууд янз бүрийн үзэл санаатай байдаг. Зарим нь засгийн газар хүчтэй парламентийн төлөөлөлтэй байж Дархадын хотгорын эрх ашгийг хамгаалах хэрэгтэй гэж бодно. Мөн энэ хүмүүс засгийн газраас өгдөг өндөр настны тэтгэвэрт талархдаг. Бусад хүмүүс засгийн газар тэднийг сайн анхаардаггүй гэж үзнэ. Ардчилсан засгийн газрын эдийн засгийн олон талт бодлогыг зарим Дархадууд эсэргүүцдэг.

70 настай Мөнхбат гуай ярихдаа : “Миний насны хүмүүсийн мөнгөний эх үүсвэр бол зөвхөн тэтгэвэр. Би сар бүр 80 000 төгрөгний тэтгэвэр авдаг ба энэ мөнгөөр 50 килограмм гурил, багахан цай аваад л дуусна. Ард түмэн эдийн засгаар их гачигдаж байгаа. Хүүхдүүдэд 3000 төгрөгний тэтгэмж өгдөг ч үүгээр нэг хувцас авч чадахгүй шүү дээ. Бид хадлан авах, малаа тарилгад хамруулахын тулд малын болон газар ашиглалтын татвар жил бүр төлдөг. Би татварт жил бүр 100 000 төгрөг төлж байна. Хотынхон өндөр цалинтай болохоор тэдэнд их мөнгө биш л дээ, харин хөдөөний бидэнд бэлэн мөнгө их байхгүй учир энэ бол нэлээд их мөнгө юм. Хэрвээ бидэнд бэлэн мөнгө байхгүй үед бид малаар төлж болох боловч ийм тохиолдолд засгийн газар нэг килограмм нь 3000 төгрөгөөр зарагддаг хонины махыг 700 төгрөгөөр тооцож биднээс авдаг. Хөдөөд бэлэн мөнгөний ажил байхгүй. Социализмын үед бид улсаас цалин авахын тулд сайн ажилладаг байсан хэдий ч цалингаараа гурил худалдан авч, бусад хэрэгцээгээ хангаж, сайхан амьдардаг байсан.”

Нөхөрлөлүүд

Зарим Дархад хүмүүсийн нэгдэн байгуулсан нүүдлийн аж ахуйн нэг хэлбэр бол нөхөрлөлүүд. Бүх Монголчууд улсаас тодорхой хэмжээний газар авах эрхтэй болсон боловч нөхөрлөл бол хэсэг газрыг гадаадын иргэнд худалдагдахаас болон бусад монгол хүмүүс буруу ашиглахаас хамгаалж, газрыг хамтран ашиглахаар зөвшөөрөл авсан хэсэг бүлэг нүүдэлчид юм. Газрыг зарах албан ёсны зөвшөөрөл засгийн газраас гарах хүртэл

өрх айл болон бүлэг нүүдэлчид бэлчээрийн зорилгоор уламжлагдан ашигласаар ирсэн. Жишээлбэл, уул уурхайн компаниуд газар худалдаж авахад малчид уламжлал ёсоор тэр газар дээр малаа бэлчээсээр байдаг. Хуулийн дагуу цагдаа нар ирж малчидыг хөөх нь ёс суртахуунгүй хэрэг гэж Дархадууд боддог. Зарим нөхөрлөлийн гишүүд хэрэв тэр газарт алт гарвал нөхөрлөлийн бодлого тухайн газрыг хамгаалж чадах эсэхэд эргэлзэнэ.

Зарим хүмүүс нөхөрлөлийн хамгаалж байгаа газарт одоо амьдарч байгаа болохоор хэрвээ нөхөрлөлд элсэхгүй бол тэднийг нөхөрлөл хөөнө гэж болгоомжлон нөхөрлөлд элдэг. Бусад нөхөрлөлүүд болон засгийн газарт хөөгдөхвий гэсэн бодол олон настайчууд, ялангуяа газар эзэмших талаар ойлголтгүй байгаа хүмүүсийн дунд байна. Ийм шалтгаанаар зарим нэгэн настай хүмүүс, айл өрхүүд хувиараа улсаас газар эзэмшихийг хүсэхгүй байна. Мөн зарим хүмүүс хэрвээ тэд, тэдний гэр бүл, тэдний мал тодорхой газарт төрж өссөн бол тэр газар хуулийн дагуу тэднийх болох боломжгүй бол уламжлалын дагуу тэдний газар болох ёстой гэж шаарддаг.

“Хэрвээ би малаа өөр бэлчээрт аваачихыг хичээсэн ч гэсэн манай мал хуучин дассан бэлчээртээ буцаж очихыг тэмүүлдэг” гэж Мөнхбат гуай ярьсан юм.

Баянхангай нөхөрлөл өвөлждөг газрынхаа нэрээр нэрлэгдсэн. Ардчилалын үед мал хувьчлагдахад Нямрэнчин гадаад орнуудад малаа хамтран хариулдаг найзуудын бүлгүүд байдаг гэж сонсооны дагуу жишиг нөхөрлөл гэж юу болох, эдгээр жишиг нөхөрлөлүүдийг нийлүүлэн ижил төстэй нөхөрлөлүүд байгуулах санаа өвөрлөн Баянхангай нөхөрлөл байгуулахаар бусдыгаа зоригжуулжээ. Социализмын үед жишиг нөхөрлөлүүдийн загвар орхигдсон боловч Баянхангай нөхөрлөл хөгжиж, дэгжин бадрах болно хэмээн Нямрэнчин итгэдэг.

2007 оны гуравдугаар сард нөхөрлөл яг яаж ажиллах ёстойг мэдэхгүй байсан хэдий ч нөхөрлөлийнхөө анхны хурлыг тэр зохион байгуулжээ. Тэгээд 2008 онд Биорегион-Эгч Дүү Орнууд төсөл тэдэнд зориулан боловсон хүчний сургалт хийсэн байна. Тэднийг дэмжих санал тавьсан тус төслийн захирал, төслийг санхүүжүүлэгч Клиф Монтайнед Нямрэнчин санаа бодлоо хэлсэн. Бэлчээрийн зөв дадал үүсгэж, ингэснээр нөхөрлөлийн үйл ажиллагаа явуулж буй газраа бэлчээрийн талхдалтаас хамгаалах зорилгоор 23 айлууд нэгдэн нөхөрлөл байгуулсан юм. Тэд Нямрэнчинг ахлагчаар сонгож нөхөрлөлийнхөө жижиг ажлуудыг эхэлжээ. 2007 онд хавар өвс сайн ургах нөхцлийг үүсгэхийн тулд хашаа барьсан нь тэдний анхны амжилт байв. Нөхөрлөлийн гишүүд өвс хадаж хангалттай хэмжээний хадлан авсандаа тэр өвөл их баяртай байлаа.

“Энэ ажлын гол үр дүн нь бид байгал орчноо хамгаалж ашигтай ажилласан” гэж Нямрэнчин хэлдэг. Дараа нь Биорегион-Эгч Дүү Орнууд төсөл өөр аймгаас цагаан идээний сургагч багш урьж авчран нөхөрлөлийн гишүүдэд олон төрлийн ааруул хэрхэн хийхийг заалган, үзэмжтэй сайхан ааруул хийн зарж борлуулах хэрэгтэйг зөвлөсөн байна. Мөн нөхөрлөлийн зарим эмэгтэйчүүдэд хэрээсэн хатгамал оёхыг зааж өгчээ. Эдгээр төсөл бүр өгөөжөө өгдөг гэж Нямрэнчин итгэдэг.

Хүйсийн байдал

Нэмж хэлэхэд улсын байгууллагууд ба нөхөрлөлүүд хүйсийн байдлын дагуу зохион байгуулагдсан байдаг. Дархадууд эрэгтэйчүүдийг их хүндэтгэнэ. Зарим эрчүүд хэлэхдээ тэд их хүч чадалтай хэрнээ заримдаа үүрэг хариуцлага мартдаг гэнэ. Эрэгтэйчүүд гэр бүлээ хамгаалах үүрэгтэй хэдий ч сүүлийн үед эмэгтэйчүүд гэр бүлийн хамгаалагч болж байгаа бөгөөд гэрийн ажлын ихэнхийг нугална.

Уламжлал ёсоор Дархад эрэгтэйчүүд мод авчирч хагалах, малаа хариулах, мал төхөөрөх зэрэг гэрийн гадаах ажлуудыг гүйцэтгэх бөгөөд мөн тийм хэмжээгээр үнэлэгддэг эмэгтэйчүүд гэрийн доторхи ажил болох хоол хийх, хүүхдээ өсгөх зэргийг

хийнэ. Одоо зарим эмэгтэйчүүд мод хагалах зэрэг гэрийн гаднах ажил хийдэг. Яагаад гэвэл тэдний нөхрүүд эдгээр ажлыг хийхээс хэт залхуурдаг эсвэл тэд салсан эсвэл бэлбэсэрсэн байдаг. Ёс заншлын хувьд эмэгтэйчүүдийн хийдэг гаднах ажил бол зөвхөн мал саах. Эрчүүдэд мал саахыг хориглоогүй боловч тэдний хувьд энэ нь уламжлалт ажил биш юм.

Соёл ёс заншил

Нүүдлийн мал аж ахуй

Дархадуудыг нүүдэлчин ба суурин амьдралтай гэж хоёр бүлэгт хувааж болно. Одоо дэлхийн төрх байдлыг гадаадынхантай хуваалцдаг байгалтайгаа холбоотой нүүдэлчин хүмүүс гэж зарим Дархадууд өөрсдийгөө тодорхойлдог. Суурин амьдралтай Дархадууд төв суурин газар амьдарна.

Өндөр насны эрхэнд тэд суурин газар амьдрах болсон хэмээн зарим нь үзэж байхад нөгөө хэсэг нь зуд болсоны дараа буюу 2000 онд маш их хэмжээний цас орж, таван хошуу малаа ихээр алдсанаас төв сууринд амьдрах болсон байна. Малтай суурин амьдралтай Дархадууд зуны улиралд малаа төвийн эргэн тойронд бэлчээж төвд байлгах ба өвөл нь нүүдэлчин айлын малтай нийлүүлэн хөдөө явуулдаг.

Нүүдэлчин Дархадууд хуанлийн дагуу нүүдлээ төлөвлөдөггүй. Жилийн турш малаа таргалуулахын тулд шинэ бэлчээрт дөрвөн удаа нүүнэ. Улирал солигдох бүрт тэр улирлынхаа бэлчээр нутаг руу нүүдэг бөгөөд өвлийн бэлчээр уулсаар хүрээлэгдэж тусгаарлагдсан, салхинаас хамгаалагдсан газар байна. Малын эмч нар нүүдэлчдийн гэрт жилд хоёр удаа очих ба хаваржаанд очиж малд урьдчилан сэргийлэх тарилга хийж, зусланд очиж мал тоолдог. Мөн тэд яаралтай тусламж үзүүлэхээр ирнэ.

Нэр өгөх

Хүүхдэд нэр өгөх нь Дархадын соёл заншилд их чухал зүйл. Хүмүүс хүүхэддээ дандаа хамаатан садангийн нэрийг эсвэл уулсын нэрийг өгнө. Жишээлбэл, Насангийн охин Даваажаргалд Насанг төрүүлэхээр Мөрөн лүү авч явсан үеэлийн нэрийг өгчээ. Тэр үеэл нь уулын давааны нэр Даваа гэдэг нэртэй. Харин Насангийн нэр бол түүний авга эгч Батнасангийн нэртэй холбоотой. Хуучин цагт нэр бүхэн ямар нэгэн утга илэрхийлдэг байсан ба орчин үед энэ нь тийм ч чухал шаардлагагүй болжээ.

Насангийн дүү ховор тохиолдлоор гурван нас хүртлээ нэргүй байсан. Дараа нь тэднийд нэгэн лам ирж дүүг нь сайн лам болно гээд Насангийн мэдэж байснаар 20-р зууны эхэн үед амьдарч байсан буянт лам “Моломдагва”-н нэрийг түүнд өгчээ. Хэдийгээр түүний дүү лам болоогүй ч гэсэн ер бусын хүүхэд байсан шигээ нэг өдөр бөө болох байх хэмээн Насан бодно.

Сайн өдрүүд

Долоо хоногийн хэдэн өдөр ба сарны буюу билгийн тооллын хуанлийн тодорхой өдрүүдийг Дархадууд сайн өдөр гэж үзнэ. Нүүдэл хийхэд сар бүрийн гуравдах ба ес дэх өдрүүдийг сайн өдрүүд гэнэ. Шинэ ажил эхлэх, нүүх, шинэ дээл хийх, шинэ санал гаргах, үс тайрах зэрэгт долоо хоногийн Даваа, Лхагва, Баасан, Ням гаригууд өлзийтэй сайн. Сар бүрийн гурван бол бидэнтэй холбогдохоор сүнснүүд ирдэг өдөр гэж үздэг учраас энэ өдөр бөө нар хоёр удаа бөөлдөг.

Эхний удаа бөөлөхдөө бөө өвөг дээдсийн онгонтой холбоо тогтоож тэдний ярьдаг байсан аялгаар ярих ба Долоон бурхан одонд сүү өргөнө. Дараагийн удаад бөөлөхдөө Түвд маанийн уншлагыг Долоон бурхан одонд зориулан уншиж сүү, хоолныхоо дээжийг

өргөнө. Дараах маанийг уншина.

Долоон бурхан минь, бидний хонь, ямаа, үхэр, морь, тэмээг
Таван хошуу малыг минь
Байгал орчинд нь хамгаалж хайрла

Хэн нэгэн бөөгийн босгосон овоонд Рэнчинлхүмбэ сумын төвийн бөө бас идээ цайныхаа дээжийг морины уралдаан, бөхийн барилдаан, нум сумын харваа болдог наадмын өдөр өргөдөг.

Хурим

Гэрлэхэд хамгийн тохиромжтой улирлууд хэмээн зун эсвэл намар Дархадын гэрлэх ёслолууд уламжлал болон болдог. Хуриманд бэлдэхдээ бэр шинэ гэр бүлийн шинэ хүн болж байгааг бэлэгдэн өөртөө шинэ дээл, гоёл чимэглэл хийнэ. Тэгээд өглөөний долоон цагаас өмнө хүргэний талынхан гэрийнхээ гадаа хүлээж байх ёстой бэрийг авахаар явсанаар хуримын ёслол эхэлдэг. Хүргэний тал бэрийг аваад хурим луу буцна. Бэр хүргэний хоёр талын хамаатан садангууд хуримын өдрийн турш идэж ууж найрлана. Хуримын үеэр хоол хийх, дуулалдах, шүлэг унших, залбирах, ерөөлийн үг хэлэх мэтээр олон зүйлүүд нийлэн хосолдог. Хуримыг тодорхой хүн удирдахгүй. Орой болоход зочид тарж гэрлэсэн хосыг хуримын анхны шөнө гэрт нь орхино. Дараа өдрийн өглөө гэрлэсэн хосууд хамтын шинэ амьдралаа эхлүүлж анхны цайгаа чанана.

Өнгө

Цагаан ба цэнхэр өнгө Дархадчуудын хувьд билэгдэлийн өнгө юм. Цэвэр тунгалгыг бэлэгдэн Хөвсгөл нуураас цагаан чулуу түүж авчирна. Мөн цагаан өнгийг тэдний гол хүнс болох цагаан идээний өнгө гэж хүндэтгэдэг. Эхэндээ цагаан өнгө бөө нарын өргөл болгон овоонд уядаг даавууны өнгө байсан ба одоо олон хүмүүс Буддын шашны нөлөөгөөр цэнхэр хадгыг хэрэглэдэг болжээ. Цагаан даавуу хэрэглэх нь зөв гэж бөө нар үзнэ. Зарим хүмүүс цагаан өнгийн чулууг Хөвсгөл нуураас авчран цэвэр тунгалгыг билэгдэл болгон сүүний хувиндаа уяж тогтооно. Эрчүүд өөр аймаг руу цэрэгт явахдаа төрөлх нутгийнхаа чулууг дурсгал болгон авч явдаг. Хүмүүс аян замд явж байхдаа баруун гар талаас цагаан туулай гарч ирэн дээлийн өврийг чиглэн өнгөрөхөд (дээлийн энгэр баруун талдаа байдаг) сайн зүйлийн дохио хэмээн бэлэгшээнэ.

Тоонууд

Дархадын соёл заншилд тоонууд их утга учиртай. Хоёрын тоог азгүй гэх ба гурвын тоог хүч чадлын тоо гэж үзнэ. Арван хоёрын тоо хоёрын тоог агуулж байгаа учраас мөн муу тоонд хамааруулдаг. Хүнд зүйл өргөхдөө нэгээс гурав хүртэл тоолж гурвын тоон дээр хүчээ гаргана. Хүннүгийн үед Наадмыг “Наадам Гэгаан” буюу “үндэсний гурван тоглоом” гэж нэрлэдэг байжээ. Яагаад гэвэл Хүннүгийн армийн хүч чадлын бэлэгдэл болсон нум сумын харваа, бөхийн барилдаан, морины уралдааны тоог илэрхийлдэг байсан. Наадмын гурван төрөлд хамгийн амжилттай оролцсон хүн Хүннүгийн армид цэргээр сонгогддог байжээ. Үүнээс үзэхэд энэ дэлхий дээр байдаг тоологддоггүй “зах хязгааргүй” гурван зүйл-далай, тэнгэр, уулс юм.

Дархадын шашны зан үйлд Түвд маанийг долоон удаа уншдаг бөгөөд Долоон бурхан одыг эрхэмлэн дээдлэх тул долоогийн тоог хүндэтгэнэ. Есийн тоо гуравт хуваагдах тул сайн тоонд хамааруулдаг. Бөөгийн шашинд ерэн есөн тэнгэр байдаг гэх ба билгийн тооллын есдүгээр сар бол тусгай сар юм. Наадамд болон хуримын ёслолд есөн цагаан морийг хэрэглэнэ. Билгийн тооллын сар бүрийн гуравдах ба есдөх өдрийг сайн өдөр

хэмээн шинэ ажил эхлэх, шинэ дээл хийх, үс тайрах, шинэ санал гаргах зэрэгт өлзийтэй гэж үзнэ. Гурав, долоо, есийн тоонууд бүгд онцгой тоонууд бөгөөд нэгийн тооноос бусад эдгээр онцгой тоонуудыг эрхэмлэдэг.

Улаанбаатар

Олон Дархад хүмүүст Монголын нийслэл Улаанбаатар бол алслагдсан, харьцангуй хамааралгүй газар юм. Мөн аймгийн төв Мөрөн хот руу олон хүмүүс явдаггүй байна. Сумын сургуулийг төгссөний дараа ихэнх Дархадчууд хөдөө рүүгээ буцдаг. Улаанбаатар луу байнга явдаг хүмүүс гэвэл оюутнууд. Социализмын үед тэргүүний ажилчин, албан хаагчдыг улсаас шагнаж гадаад оронд аялуулахад тэд нийслэлийг дамжин явдаг байжээ. 1950 онд Улаанбаатар таван автобустай жижиг хот байсан гэдгийг ахмадууд дурсан санадаг. Харин одоо хөл хөдөлгөөн ихтэй том нийслэл хот болжээ.

Шашин

Дархадчуудын итгэл үнэмшил

Бөөгийн ба Буддын шашныг хослуулан шүтдэгээрээ Дархадчууд бусад ястангуудаас ялгаатай. Яагаад гэвэл социалист нийгмийн үед энэ хоёр шашныг нухчин дарж байсан ба шашны олон уламжлалт зан үйлүүд, шашны номлолын мэдлэгүүд мартагдсан. Тэр үед цөөн тооны бөө нар өөрсдийн сонирхол, зан үйлийн дагуу ил тод байсан бөгөөд бөө байсных нь төлөө, бөө дээр очсоных нь төлөө хүмүүсийг шоронд хорьж, эсвэл алж устгажээ. Харин одоо ардчиллын үед хоёр шашинг, ялангуяа бөөгийн шашинг шүтэх эрх сэргэсэн байна.

Бөөгийн шашны Тувачуудтай адил хэлбэрийг Дархадчууд шүтдэг гэж тэд хэлэх боловч олон жинхэнэ бөө нар Тувачуудын дунд үлдсэн, социализмын үед Дархадын хотгороос Өвөр Монгол руу зугатаж амь гарсан хэдэн жинхэнэ бөө нараа Дархадчууд алдсан гэж харамсдаг. Мөн Монголоос өөр оронд байсан өвөг дээдсийн онгонууд болон бусад бөөгийн онгонууд социализмын төгсгөл болж тэдний онгонууд өвлөгдөн ирэхийг хүлээж байсан гэж Дархадчууд боддог. Одоо үед бөө нар өвөг дээдсээсээ хүч чадлыг нь өвлөн авч, тэдний онцлог шинжийг илрүүлж байгаа бөгөөд бөөгийн шашны сэргэн мандалт Буддын шашныхаас хүчтэй байна гэж Дархадчуудын итгэл үнэмшил шинэчлэгдэж байгаа. Яагаад гэвэл бөө нар хүч чадлаа өвөлж аваад хэрвээ энэ онгоныг ашиглахгүй бол тэд өвчлөх эсвэл нас бардаг байхад Буддын лам болохыг хүссэн хүн лам болох боломжтой байдаг.

Одхүү гуайн нагац ахыг эцгийнх нь нүдэн дээр шашныг эсэргүүцэгч социалист эрхтэн дархтан нар хороожээ. Тэр ярихдаа “Ардчилал эхэлсэний дараа 1993 онд Мишиг бид хоёр Буддын шашныг дахин сэргээх санаатай хийд барьсан боловч хүмүүс тэнд очихгүй байсан. Тиймээс одоо энэ хийдийг агуулахын зорилгоор ашиглаж байгаа. Хүмүүс Буддын шашнаар тоглохоос айж байсан учраас энэ хийд хоёр жилийн дотор дууссан. Анх зарим хүмүүс хийдтэй болохыг хүсч байсан учраас тэдний хүсэлтээр бид үүнийг барьсан юм. Тэр ч байтугай бид лам нарыг тэнд амьдрахыг урьсан боловч хүмүүс хийдэд очихгүй байсан болохоор тэр лам нар гэртээ буцсан. Бид хийдийн судруудыг хандивлаж, сумын сургуулийн музейд бурханы барималуудыг өгсөн.” гэсэн юм.

Хэдийгээр социализм Буддын ба бөөгийн шашинд хоёуланд нь заналхийлж байсан ч бөөгийн шашны үндсэн аюул занал нь Буддын шашин байсан. Буддын шашны нөлөө хэдэн зууны туршид бөөгийн шашныг сулруулжээ. Энэ нөлөө хоёр шашны сонголтоос нэгийг нь үл ойшоож бөөгийн шашныг өөрчилжээ.

Дархадын хотгорт Буддын шашин яаж дэлгэрсэн тухай нэг таамаглал байх ба энэ нь Манжийн дарангуйллын үед бүх Монголыг захирахаар дөрвөн том аймгууд өөр

хоорондоо байлдсан. Тэдний гурван удирдагчид Манжууд тусална гэж хэлсэн боловч тэднийг хуурсан бөгөөд Манж руу удирдагчийгаа даган явсан олон хүмүүс буцаж гэртээ харихыг хүсч байв. Тэгээд тэд Күн эзэн хаанд хэрвээ тэднийг төрөлх нутгаа дахин нэг удаа харах боломж олговол тэд түүний талд байсаар байх болно гэж хэлжээ. Эзэн хаан тэднийг эх нутагтаа харьж очоод Буддын шашныг нийт хүн ардаа дэлгэрүүл гэсэн болзолтойгоор гэртээ буцахыг нь зөвшөөрсөн байна. Ингээд буцаж ирсэн Монгол цэргүүд Буддын шашныг хүчээр Дархадын хотгорт дэлгэрүүлсэн гэсэн таамаглал байдаг. Мөн Бээжингээс ирсэн шашин нэвтрүүлэгч, номлогчид Буддизмыг хүчээр дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. Тэд том хийд барьж, хивсээр дүүргэн, нэг мянгаас гурван мянган лам нарыг хүссэн газраа сууж болохоор тохижуулсан. Ингээд Буддын шашинтан болсон эсвэл Христийн цөөн шашинтангууд бөөгийн шашны сүр хүчийг сулруулсан гэж зарим Дархадчууд итгэдэг.

Хоёр үеийн өмнө эрүүлийг хамгаалах гол арга бол бөөгийн шашин байжээ. Харин одоо Барууны хөгжил өндөр болж, хүмүүс орчин үеийн анагаахын эмчийг, эмнэлгийг сонгох эсвэл бөөгийн арга заслыг сонгох боломжтой болсон. Зарим хүмүүс эхлээд европ эмнэлэгт хандаад, үр дүнгүй байвал бөө рүү явдаг.

Буддын шашинтан, бөөгийн шашинтан, эсвэл шашин шүтдэггүй ч гэсэн Дархадчууд олон төрлийн өөр бусад сүсэг бишрэлтэй. Овооны дэргэдүүр өнгөрөхдөө нар зөв гурван удаа тойрч, чулуу өргөөд хүслээ хэлэхгүй өнгөрөх нь муу хэмээн итгэнэ. Голоор гаглахдаа өршөөл эрж, эсэн мэнд гатлуулахыг залбиран гуйна. Мөн рашаан булгийн эх байдаг Өлийн даваа, Түрүүний эх зэрэг даваануудын овооны газруудыг ариун нандин хэмээн хүндэтгэнэ. Шинэ хоол цай болж байхад идэж уухгүй орхиж явах нь аз хийморио гэртээ орхиж байгаа хэрэг учир хоол цайгаа идэхгүй гарахаас зайлсхийнэ.

Бөөгийн шашин

Монголын бөөгийн шашин маш урт түүхтэй ба Чингэс хаан хүртэл бөө байжээ. Дархадын бөөгийн шашин тэдний өвөг дээдсийн онгон сүнс ба бодит амьдрал хоёрын хоорондын харилцаан дээр суурилсан байдаг. Өвөг дээдэс бодит амьдралаас хүлээж авсан хүндлэлийн хариу болгож тусгай сайн нөлөө үзүүлэх ба үл хүндэлсэн хариу болгож муу зүйлсийг учруулдаг. Хэн өдөр тутмын амьдралдаа итгэж хэрэглэж байна, эсвэл хэн хааяа тохиолдлын маягаар хэрэглэж байна гэдгээс хамааруулан хүмүүсийн амьдралыг өвөг дээдэс зохиодог гэнэ. Үүнээс үзэхэд хүмүүс өвөг дээдсээ зөв хүндэлж чадвал аз хийморьтой сайхан амьдарч болох ажээ. Бөөгийн шашин бол байгал дэлхийгээ хүндлэх тухай сургадаг бөгөөд байгалдаа ойр амьдрах нь бөөгийн шашны итгэл үнэмшлийг хүчтэй болгодог. Тэдний итгэл үнэмшил ямар хэмжээтэй байх нь хувь хүнээс өөрөөс нь хамаардаг.

Бөө нар өвөрмөц заншилтай. Бөөгөөс тусламж хүсч байгаа хүн бөөгийн гэрт өөрөө очих ба гэртээ бөөг урьж аваачиж болох боловч жинхэнэ бөө нар бөөгийн эд зүйлсээ гэрээсээ гаргаж өөр айлд аваачдаггүй. Тэд айлд туслахаар очвол хүч чадлаа ашиглан онгон сүнстэйгээ ярилцан мэргэлж өгдөг.

Бөө бүхэнд тодорхой биелүүлэх үүргүүд байдаг ба Тэнгэрт мөргөх тусгай өдөртэй. Энэ өдөр хэзээ байх нь билгийн тооллын бөөгийн төрсөн өдөр болон тухайн сарын таагүй муу өдрүүдээс хамаардаг. Билгийн тоолол арван хоёр жил амьтны дарааллаар явагдах (Хятадын сарны хуанлигтай адил) ба дараах дарааллаар байна: хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай. Жилд нэг удаа эсвэл сард цөөхөн өдөр бөөгийн ар талын хүмүүс тусгай өргөл өргөнө. Мөн эдгээр хүмүүс байгалдаа ойр амьдрах тул тэнгэрт залбиран цайныхаа дээжийг өдөр бүр өргөдөг.

Бөөгийн шашны өөрчлөлтүүд

Олон Дархад хүмүүсийн адилаар Жигий гуай бөөгийн шашныг ба бөө нарыг шүтэж хүндэлдэг хүн. Тэр 19-р зууны сүүлч үед Тэнгис голд нутагладаг байсан алдартай бөө “Жимбээ”-ийн тухай нэгэн түүх ярьдаг. Тэр зуунд эрэгтэйчүүд сүх, цахиур хэт, хутга, аягаа бүснээсээ зүүж явдаг байсан ба ингэж хувийн хэрэгслээ авч явснаар хувийн эрүүд ахуйн дэглэм барьж чаддаг байжээ. Ан агнах, мод огтлохдоо хутгаа хэрэглэнэ. Залуу хүмүүс айлд ороод аюулгүй байдлыг хангаж хутгаа гутлынхаа түрүү лүү хавчуулдаг. Нэгэн өдөр Жимбээ бөө дээр зочилж ирсэн залуу эрсийг тэрээр гадаа хутгануудаа нуу, нуусан хутгыг чинь олно гэв. Тэгэхэд залуу эрс хутгануудаа өтөг бууцанд болон нүхэнд нуужээ. Тэднийг гэрт орж ирэхэд Жимбээ гуай “хөөе залуусаа, энэ та нарын хутга мөн үү” гэж асуужээ. Бөөгийн онгон сүнс тэр хутгуудыг Жимбээ гуайд авчирч өгсөн байна.

Одоогийн ихэнх бөө нар Жимбээ бөөгөөс хүч чадлаар дутуу. Учир нь хэдэн зууны Буддын шашны муу нөлөөтэй залгаад социализмын хавчлага дарамт их байсан. Социалист нийгэм эхэлсэний дараахан зуу зуун сүм хийдийг сүйтгэж, мянга мянган лам, бөө нарыг устгасан. Хүмүүс бөө болох, бөөгийн шашин шүтэхээс айдаг байв. Хүүхдүүдийг шашны холбогдолтой зүйл сурахыг хориглож, бөө нар зан үйлээ залуу үеийнхэнд заахыг зогсоосон. Энэ түүхээс үзэхэд одоогийн бөө нар өмнөх үеийн бөө нараас хүч чадлаар дутуу ажээ.

Жинхэнэ ба хуурамч бөө нар

Дархадын соёл заншилд бөө нар гол үүрэгтэй. Харамсалтайгаар, зарим “бөө” нар хууран мэхлэгчид байдаг. Туршлагагай Дархадчууд бөөгийн хуурч байгаа эсэхийг мэдэх аргууд бий гэж хэлнэ. Бөөг жинхэнэ эсвэл хуурамч гэдгийг мэдэхийн тулд бөөгийн яриаг сонсож, царай болон төрх байдлыг нь ажиглах хэрэгтэй. Мөн тэд туслагч түшээтэй байх ба эхнэр нь эсвэл хүүхдүүдийнх нь нэг энэ үүргийг гүйцэтгэнэ. Хэрвээ бөө бөөлөх үед биеэс нь сүнс нь гарахад тэд ухаан алдах бөгөөд ийм үед түшээ нар бөөг бэртэж гэмтэхээс хамгаалж байдаг. Тэгэхгүй бол тэд бөөлж бүжиглэж үсэрч байхдаа гал руу унах, толгойгоор мөргөн унаж магадгүй байдаг. Ийм бөөгийн ёслолын үед бөө нар өөрийгөө хянах чадвараа алдах тул жинхэнэ бөөд түшээгийн хамгаалалт хэрэгтэй. Хуурамч бөө нар хуурамчаар бөөлж, бэртэхээс өөрийгөө хамгаалж чадна. Мөн жинхэнэ бөө өвөг дээдсийнхээ онгон сүнстэй харилцахдаа сүнсний хэлээр буюу хуучны Дархад эсвэл Тува аялгаар ярих тул түүний ихэнх үгийг бусад хүмүүс ойлгох боломжгүй юм. Жинхэнэ бөөг бөөлөхөд цаг агаарын байдал заримдаа хурдан өөрчлөгдөнө. Жишээлбэл, тэнгэр бүрхэг үүлтэй байснаа түргэн цэлмэх гэх мэт. Мөн чоно болон бусад амьтад дуу авиа гаргах талтай. “Намайг залуу байхад сайн мэргэлдэг жинхэнэ бөө нар байсан. Одоо зарим хуурамч бөө нар худлаа мэргэлж эсвэл хүмүүсийн өнгөрсөн амьдралд тохиолдсон зүйлсийг худлаа таамагладаг. Тувагийн бөө нар хамгийн хүчтэй бөгөөд Дархад бөө нар ч бас сайн юм. Миний нөхөр Тувагийн бөөгийн удамтай хүн. Би бөөд итгэхийг хүсдэг ч хуурамч бөөгөөс айдаг” хэмээн Дэнсмаа ярьсан юм.

“Бид сайн бөөгийн босгосон овоонд нэг хуурамч бөө тахилга өргөж байхыг харсан. Овоог тахихдаа тэр овоог босгосон бөөд хүндэтгэл үзүүлж буй хэрэг бөгөөд тахилгын зэрэгцээ нум сумын харваа, хурдан морины уралдаан, бөхийн барилдаан болж жижиг наадам хийдэг. Хүмүүс хэлэхдээ овооны тахилга хийсэн бөө жинхэнэ бөө байдаг гэдэг. Гэхдээ магадгүй тэр бөө хуурамчаар бөөлсөн болохоор онгон сүнс нь ирээгүй байх. Гэсэн ч энэ бөөгийн сайхан ёслол байлаа, яагаад гэвэл тэр бороо орохыг зогсоосон” гэж Должин Бадам нар ярилаа.

Байгал орчин

Ан амьтад

Дархадын соёл заншилд амьтдыг ихээр хүндэтгэнэ. Бүх зэрлэг амьтад байгалд амьдрах учир ариун догшин, буга болон загасны тодорхой төрлүүд сүнстэй байдаг хэмээн тэд итгэдэг. Ялангуяа хандгай ба буга дархан цаазтай амьтад. Учир нь тэд маш үзэсгэлэнтэй бөгөөд тэдний амьдрал хүний буруу үйлдлээс хамаарч болох тул магадгүй хүн ба амьтдын тэнцвэрт харьцаа өөрчлөгдөх талтай.

Довдон хэлэхдээ “Таны алсан буга магадгүй муу төрлийн өвсийг идэж байсан байж болох юм. Тэгээд сайн өвс ургана. Хэрвээ бугыг алж устгаад байвал бэлчээр муудаж магадгүй” гэсэн юм.

Бугыг өнчрүүлэх нь үнэхээр зэрлэг хэрэг гэж тэд үзнэ. Мөн Дархадын хотгорын цагаан адууг эрхэмлэн хүндэлдэг.

Уул уурхайн олборлолт

Олон Дархадчуудын, ялангуяа ахмад хүмүүсийн хувьд уул уурхайн олборлолт хийх нь муу ёрын зүйл юм. Энэ нь бидний өвөг дээдсийн сануулан хэлж байсанчлан хүн төрөлхтөнийг аюулд учруулан байгалийг сүйтгэж буй мэт харагдана. Ашигт малтмалаа ухуулсан газруудын лус савдаг хилэгнэж, байгал өөрийгөө хамгаалж, маш их цас орж зуд болох вий гэж Дархадчууд айдаг. Олон Дархадчууд уул уурхайн олборлолт зөвхөн муу хор уршгын шалтгаан болохгүй бас үйлдвэрлэлийн мөнгө авчрах сайн шалтгаан болно гэж итгэнэ. Мөн тэдний нэг ажигласан зүйл бол алт угааснаас гол горхи хатаж ширгэх асуудал үүсдэг. Хөгийн гол том гол байсан ба тэнд алт ухсанаас голын ус татарч байгаа. Түүнчлэн, алт олборлогчид алт ялгахын тулд хүний эрүүл мэндэд муу нөлөөтэй химийн бодис хэрэглэж эдгээр бодис голын ус руу орсоноор цэвэр усны эх үүсвэрийг бохирдуулж байна. Алт олборлогчидоос байгалиа хамгаалахад тэдний нас өндөр тул цаашид байгал орчинд юу тохиолдох бол хэмээн ахмадуудын сэтгэл зовнино. Тэр ч байтугай цагдаа нар хууль бус олборлолтыг зогсоож чадахгүй байна.

Боловсрол

Социалист ба Ардчилсан боловсрол

Дархадчууд социалист ба ардчилсан боловсролын хэлбэрүүдийг янз бүрээр үздэг. Тэдэнд социализмын үеийн боловсролын чанарыг шүүмжлэхэд хэцүү. Яагаад гэвэл тэр үед бүх хүмүүс ажилтай, мэргэжилтэй байсан. Ардчилсан нийгэмд ажилгүйдэл их байгаагын гол шалтгаан нь ажил хайгчид боловсрол муутай байдаг. Харин социалист нийгэмд ажилтай хүмүүсийн түвшингээр боловсролын системийн чанартай эсвэл чанаргүй байсныг хэн ч үнэлж чадаагүй юм. Яагаад гэвэл тэр үед хэн нэгэн муу боловсрол эзэмшсэн байсан ч ажилтай болдог байлаа. Зарим Дархадчууд ардчиллын өнөөгийн нийгэмд тухайн ажилд өргөдөл гаргагч тэнцэх эсэхээ батлахыг энэ нийгмийн өрсөлдөөн шаарддаг ба бүх хүмүүс хангалттай цалин авахгүй байгаа гэж боддог. Ардчилал хүмүүсийг амьдралын доогуур түвшинд аваачсан гэж тэд үзнэ. Нөгөө талаар, ардчиллын ачаар бүх зүйл нээлттэй болж үйлчлүүлэгч, оюутнууд, өвчтөнүүд гэх мэт бүх хүн хамгийн сайн үйлчилгээ авах эрхтэй гэдгээ илэрхийлэх боломжтой болсон. Гэсэн ч багш нар өнөөдөр сайн боловсрогдож гарч байгаа хэрнээ тэд сурагчдаа төдий л хайхрахгүй, хичээлээ чин сэтгэлээсээ заахгүй байна хэмээн Дархадчууд боддог.

Сургуулийн захирал байсан Одхүү багш хэлэхдээ: “Би сурагчдад Барууны боловсрол эзэмшүүлэхийг хүсдэггүй. Одоогийн засгийн газрын боловсролын салбарын дарга миний

шавь байсан. Би түүнд уламжлалт, ёс суртахуунд суурилсан боловсрол эзэмшүүлэх хэрэгтэй гэж зөвлөсөн боловч тэд миний зөвлөгөөг дагаагүй. Социализмын өмнө болон социалист нийгэмд багш нар шавь нартаа зан суртахууны хүмүүжил олгоход голлон анхаарч ёс суртахуунд суурилсан боловсрол эзэмшүүлэхийг зорьдог байсан” гэсэн юм.

Өнөөгийн ба ирээдүйн боловсрол

Дархад хүүхдүүд бусад хөдөөгийн хүүхдүүдийн адил сумын дотуур байртай сургуульд суралцдаг. Тэдний эцэг эхчүүд дотуур байранд мах өгнө. Энэ сургууль ерөнхий боловсрол болон ургамал, амьтны аймгийн талаар заана. Өмнө нь бас хатгамал оёхыг заадаг байжээ. Эцэг эхчүүд хүүхдүүддээ боловсрол олгоход голлох үүргийг гүйцэтгэсээр байгаа ба тэдний өдөр тутмын амьдрал, мал маллах, шашин шүтлэг, соёл ёс заншлын тухай ярьж заадаг байна.

Олон хүмүүс сургууль хүүхдүүдэд ёс суртахууны боловсрол олгох, байгал хамгаалах сэтгэлгээг бий болгох зорилгоор сургалтын хөтөлбөртөө эдгээрийг оруулж, мөн Англи хэлийг сайн заах хэрэгтэй гэж үздэг. Хамгийн эхний санаачлагатай зүйл бол байгал дэлхийгээ хайрлах үзлийг бий болгож, хайр гамгүй ханддаг хандлагыг багасгах хэмээн Дархадчууд итгэдэг. Дараагийн чухал зүйл бол тэд гадаад хүмүүстэй англиар ярьж даяарчлагдаж буй дэлхий ертөнцийн чиг хандлагыг олж мэдэх явдал гэнэ.

Нэгэн багшийн тухай

Одхүү гуай 1977-2007 онуудад сурган хүмүүжүүлэгч, сургуулийн захирлаар ажиллажээ. Тэр гурван хүүхдийн эцэг бөгөөд өөрийн дадлага туршлага, үзэл бодлоо боловсролын салбарт зориулсан хүн.

“Өмнө нь уламжлалт боловсрол сайн байсан. Гол чиглэл бол ахмадуудаа хүндлэхийг сургах. Социалист нийгэмд багш нарыг их хүндэтгэж, сурагчид багшдаа мэндлэнэ. Харин одоогийн зарим хүүхдүүд багш нарынхаа нүдэн дээр архи ууж, багш нарыгаа болон бусад ахмад хүмүүсийг үл ойшоодог болжээ. Өнөөгийн байдлаар сурагчид бичиг үсгийн боловсрол эзэмшдэг хэдий ч ёс суртахууны боловсрол эзэмшиж чадахгүй байгаа. Би сургуулийн захирлаар ажиллаж байхдаа зарим нэгэн өөрчлөлт хийх хэрэгтэй байгаа тухай ярьж хэлэхийг оролддог байсан боловч сайн чадаагүй. “ гэж ярьсан юм. Түүний хийхийг оролддог байсан өөрчлөлтүүд гэвэл:

1. Биеийн тамирын боловсрол олгох хичээл
2. Уншихын чухлыг залуу үеийнхэнд ойлгуулах. Хүүхдүүд хангалттай уншдаггүй учир
3. Энгийн заах аргаас гадна хүүхдүүдээр туршилт хийлгэх мэтээр шинэ санаачлага, харилцан туршлага солилцох идэвхтэй байдлаар хичээлийг явуулах
4. Багшаар удирдуулж сурахын оронд сурагч өөрөө бие дааж сурахыг нь дэмжиж урамшуулах, ялангуяа гадаад хэл сурах тал дээр
5. Сургалтын хөтөлбөрт оюун ухаан хөгжүүлэх тоглоом оруулах
6. Сурагчийн бахархал, өөртөө итгэх итгэлийг урамшуулах тэмцээнүүд зохиох

Эрүүл мэнд

Оточ

“Бурхан бол чи өөрөө” гэж оточ Басбиш гуай хэлдэг. “Та өөрөө өөрийнхөө бурхан. Хүмүүс бол бурхад. Би хүн эмчлэхдээ бодол санаагаа ба энергээ ашигладаг. Миний зарчим бол зүгээр л хүмүүст туслах. Олон ястан үндэстэнүүд жишээлбэл, Дархад, Африкийн Америкууд, Дөрвөд (Монголын нэг ястан) байдаг ч бид бүгдээрээ ижилхэн төрхтэй. Надад дөрвөн нүд байхгүй, танд дөрвөн хөл байхгүй. Хэдийгээр бидэнд хэлний

зааг байгаа ч бид бүгд ижилхэн. Ямар нэгэн атгаг санаа бидний дунд байхыг би хүсэхгүй”
“Би европ эм тариа хэрэглэдэг байсан боловч, үүнээс татгалзах хэрэгтэй гэдгийг би одоо мэднэ. Олон жилийн өмнө намайг 20 настай байхад миний зүрх өвдсөн. Тэр үед би европ эмчилгээ хийлгэсэн ч надад сайн нөлөөлөөгүй. Хүний бие эх дэлхийгээс, байгалиас төрдөг гэдгийг би ойлгосон. Бид байгалийн нэг хэсэг учир өөрсдийгөө эмчлэхдээ байгалийн бусад зүйлсийг ашиглаж болно гэдгийг ухаарсан юм. Тиймээс би оточ болохоор шийдсэн. Хүмүүс эрүүл байх хэрэгтэй шүү дээ.”

“Би арван нэгэн хүүхэдтэй. Тэднийг эмнэлэгт очих шаардлагатай үед бид очиж чаддаггүй байсан ба хөдөө амьдарч буй хүмүүст энэ бол боломжгүй байдаг. Тэгээд би хүүхдүүдээ эрүүл болгохын тулд уламжлалт эмчилгээг хэрэглэдэг байлаа. Хүүхдүүдээ эмчлэхдээ би Лувсаншарав, Цэрэнжамц гэдэг оточуудаас зөвлөгөө авдаг байв”

“Би ургамал цуглуулж, өвөг дээдсээсээ уламжилж авсан мэдлэгээ ашигладаг. Ардын эмчилгээ Чингэс хааны үеэс үүсэлтэй. Жишээлбэл, зарим бэртэл гэмтэлийг эмчлэхдээ халуун төмөр ашигладаг байсан. Ийм үндсэн эмчилгээг одоо хүртэл европ эмчилгээнд хэрэглэж байгаа ба энэ аргууд зөвхөн хувьсан хөгжсөн. Жишээлбэл, Баруунд шархыг ариутгаж цэвэрлэдэг”.

Бид нүцгэн төрж биднийг даавуунд ороож нүцгэн оршуулдаг. Бид зүгээр л байгалийн нэг хэсэг-Басбиш

Эм

Анисны навч хоолойны өвчин ба ханиадыг эмчилнэ.

Бүргэдийн савар-олон зуун жилийн настай бүргэдийн савар Насанд өвлөгдөн иржээ.

Охиноо төрүүлсэний дараахан түүний хөх хавдаж өвдөхөд нөгөө бүргэдийн савраар гурван удаа маажсанд хөх нь эдгэрчээ.

Цагаан гүүний сүү элэгний өвдөлт намдаах ба элэгний хавдартай хүнд хэрэглэнэ.

Таван салаа ходоодны өвчнийг ба шархыг анагаана.

Өөрчлөлт

Ардчиллаар олсон өөрчлөлтүүд

1990 онд болсон ардчилал Дархадын соёл заншилд олон өөрчлөлтүүдийг авчирсан.

“Нийгэм өөрчлөгдөх нь сайн ба муу талтай. “ Усыг нь уувал ёсыг нь дага” гэдэг зүйр үг байдаг. Тэр ч байтугай бид суурин амьдралтай болох хэрэгтэй гэж би бодох болсон. Бид нийгмийн өөрчлөлтөөс суралцаж муу зүйлсээс зайлсхийхыг хичээнэ. Гэрт амьдарснаас дүнзэн байшинд амьдрах нь илүү тохьтой. Бидэнд цахилгаан бас зурагт байна. Бидэнд одоо лаа хэрэггүй болж харанхуйд байх хэрэггүй болсон. Яагаад гэвэл нийгмийн байдал өөрчлөгдсөнөөр хүмүүс гадаад орон луу аялж, сайн боловсрол эзэмшиж сайн ажилтай болж, бусад орны соёл ёс заншлаас суралцан гадаад хэл суралцаж байна” гэж Довдон гуай ярилаа.

Гомбосүрэн, Даваажав гуай нар харин үүнтэй санал нийлэхгүй ингэж ярьсан юм. “Бид гэрт амьдардаг байснаа өөрчилж дүнзэн байшинд амьдрах болсон. Бид гэрээ санадаг, яагаад гэвэл гэр бол илүү ухаалаг хийгдсэн зүйл. Гал түлэхэд гэр хурдан дулаацна. Дөрвөлжин байшин дугуй хэлбэртэй гэрийг бодвол удаан дулаацдаг тул одоо бид нэлээд удаан галлах хэрэгтэй болсон. Ардчилал сайн хэдий ч юмны үнэ өөрчлөгдөх шалтгаан болдог. Гэрийг жилд дөрвөн удаа нүүлгэх ёстой бөгөөд нүүдлийн үеэр гэрийн аль нэг юм байнга эвдэрнэ. Социализмын үед бэржээнтэн бүрээс, бусад хэсгүүдийг худалдаж авахад бидний чадал чинээ хүрдэг байсан. Байшинг засварлахгүйгээр хэдэн жил болж болно”

Зарим хүмүүс ардчилал хэтэрхий их эрх чөлөөг бий болгосон гэнэ. Эдгээр Дархадууд

эрх чөлөөт байдал тамхи, мансууруулах бодис, согтууруулах ундаа, ялангуяа архины буруу хэрэглээг үүсгэсэн хэмээн ярина. Ардчилсан чөлөөт байдал нь зурагтын хөтөлбөрт болгоомжтой хандахыг бас шаарддаг. Энэ нь хүүхдийн харааг муутгаж, сургууль болон гэрийн даалгавар хийхийн оронд савангийн дуурьт тэдний сонирхолыг татдаг гэж зарим хүмүүс шүүмжилж байхад зарим нь үүнийг хайхардаггүй. Мөн зурагтыг сайн эсвэл муу зүйл гэдгийг шүүхэд Дархадын соёл заншилд зурагт нь одоо хүртэл хэтэрхий шинэ зүйл юм гэж зарим хүмүүс хэлдэг.

Залуу үеийнхэн эрх бөгөөд залуу гэж зарим хөгшид бодно. Тэд есдүгээр сар хүртэл хөл нүцгэн явж, байгалдаа зохицон амьдарч, хүүхэд байсан хэрнээ их ажил хийж, ахмад хүний гуйлтыг хэзээ ч татгалзахгүй байж, эцэг эхийнхээ үгэнд дуулгавартай ордог байснаа санадаг. Одоогийн залуус гадаа гарч ажил хийхээс дургүйцэж, орчин үеийн хөгжил дэвшил тэдний хийх гэрийн ажлыг өмнөх үеийнхэнээс амархан болгосныг үл харгалзан тэд ахмадуудынхаа үгэнд ордоггүй гэж боддог.

“Би сүхээр мод огтолдог. Харин одоо залуучууд хөрөөгөөр ч мод огтолдоггүй” гэж Дэнсмаа гуай хэлсэн юм. Нэгэн ахмад настай хүн ярихдаа “Цэргийн албан үүрэг таван жил байсан ба цэргийн анги бааз руугаа мориор явдаг байлаа. Одоогийн залуус ердөө нэг жил цэргийн алба хааж цэргийн анги руу машинаар очдог гэлээ.

Хоолны дэглэмийн өөрчлөлт

20-р зууны хоёрдах хагас үеийн туршид өөрчлөгдсөн нэг гол зүйл бол хоолны дэглэм юм. Нэг үеийн өмнөх Дархадууд 2-р сараас 11-р сар хүртэл буюу жилийн хагаст голдуу цагаан идээ иддэг байсан ба үлдсэн хугацаанд нь мах хэрэглэдэг байжээ. Гэсэн хэдий ч социалист нийгмийн үед дулааны улирлын хоол хүнсний нэг хэсэг нь хүнсний ногоо болсон ба тэдгээрийн агуулдаг амин дэмүүдийн үнэ цэнийг олон Дархадууд үнэлж үздэг. Мөн орчин үеийн Дархадууд өөх тосноос татгалзан тэдний хэлдгээр биеэ цэвэрлэж хүнсний ногоо ба жимсийг “ямаа шиг идэх” дуртай болсон гэж бусад хүмүүс ярьдаг. Ийнхүү өөрчлөгдөж буй Дархадын хоолны дэглэмийг тавь, жаран насандаа эрүүл мэндийн асуудалтай тулгарсан хүмүүст болон элбэг бус байх ерэн настай хөгшчүүдэд нэлээд хэрэглэнэ.

“Намайг хүүхэд байхад ахмадууд залуу үеийнхэнд дуртай байсан. Одоо энэ өөрчлөгдсөн. Яагаад гэвэл бид Хятадын импортын хүнс, органик бус хүнс хоол хэрэглэж эхэлсэн” хэмээн Дэнсмаа хэлсэн юм..

Дархадын уламжлалт хоолны дэглэм энгийн байсан. Тэдний зарим нь нүүдэлчин амьдралын голлох хүнс болох цагаан идээ, мах, гурилнаас хориос гучин насандаа уйдаж эхэлдэг гэнэ. Тэд уйдсан гэж хэлж байгаа ч энэ нь хоолны зуршлын өөрчлөлтийн ард байсан түлхэх хүч байлаа. Уламжлалт болон шинэчлэгдсэн дэглэм хоёрын дундыг барьсан өөрчлөлтийг бий болгох болон өнгөрсөн үеийн ба өнөөдрийн эрүүл хооллолтыг хослуулах хэрэгтэй гэж Дархадууд дүгнэдэг.

Ирээдүй

Ирээдүй хойч үедээ соёл ёс заншил, зан үйл, уламжлалаа өвлүүлэн үлдээх нь амин чухал гэж Дархадууд боддог. Тэдний ихэнх нь тэдний үр хүүхэд нүүдэлчин амьдралын хэв маяг, бөөгийн шашин, өргөл өргөх, байгал орчноо хамгаалах зэрэг үйлийг нь үргэлжлүүлэхийг хүснэ.

Гуравдугаар хэсэг

Америкийн Монголчууд

Оролцсон Америкт амьдардаг Монголчууд

Монголчууд ерөнхийдөө өөрийн нэг нэртэй байх ба Америкт амьдардаг Монголчууд эцгийн нэрээ эсвэл ургийн овгийн нэрээ гэр бүлийн нэр болгон дандаа хэрэглэнэ.

Америкт амьдардаг Монголчуудын ихэнх нь Монголын хотын оршин суугчид буюу нүүдэлчин биш, мөн тэдний ихэнх нь Халх үндэстэн ба Тувачууд, Дархадчууд биш. Тэд Монголд ба Америкт байхдаа хөдөөний Тувачууд, Дархадчуудад тохиолддоггүй салалт мэтийн асуудалтай тулгардаг бөгөөд тэд янз бүрийн зорилготой байдаг. Яагаад гэвэл тэд Америкт барууны амьдрал, Монголын хотуудын баруунжсан амьдралд амьдарч байсан ба тэдэнд үргэлж Баруунжих эерэг хандлагууд, даяарчлал, Тувачууд, Дархадчуудын хийдэг уул уурхайн олборлолт шиг үйлдвэрүүд байдаг. Үүний эсрэгээр, Тувачууд ба Дархадчууд уламжлалын үнэ цэнийг Америкт байгаа Монголчуудыг бодвол илүү ихээр ойлгож, ингэснээр уламжлалаа хамгийн эн тэргүүний зүйл хэмээн үргэлжлүүлдэг илүү уламжлалт ертөнцөд амьдардаг.

Дэмбэрэлийн Цэрэндорж, 46 настай, Буриад, Дорнод аймгийн зүүн хэсэг
Цэвэлваанчигын Төмөрсүх, 43 настай, Халх, Өвөрхангай аймаг
Осорын Бадамцэцэг 42 настай, Халх, Дорнод аймаг
Ганзүрх 37 настай, Дархад, Улаанбаатар
Чойжилжавын Даваадулам 42 настай, Халх, Улаанбаатар
Сарнай 28 настай, Халх, Улаанбаатар, ээж Одгэрэл 53 настай, Халх, Улаанбаатарт амьдардаг, охин дээрээ зочилж ирсэн.

Цагаачилсан туршлагаууд

Цагаачлал:Хэн, Яагаад, Ямар хугацаагаар

Зарим Монголчууд бусдыг бодвол цагаачлах илүү сонирхолтой байдаг. Тэд хотын хүмүүсийг бодоход нүүдэлчин малчид Америкийн амьдралд дасан зохицохдоо хэцүү байдаг ба Америкийн амьдралыг нүүдэлчид маш бага мэддэг гэж ярьдаг. Хэн нэгэн нүүдэлчин малчин Америк руу цагаачлахыг хүсэж байвал эхлээд Улаанбаатарт амьдарч үзэх хэрэгтэй гэж Америкийн Монголчууд зөвлөнө. Зарим нүүдэлчид цагаачилдаг бөгөөд тэнд байгаа Монголчууд тэдний тэвчээрт итгэж Америкийн амьдралд таарч тохироход нь тусалдаг.

Голдуу оюутнууд Америк руу цагаачлах боловч бас дунд ба ахмад насныхан ховорхон цагаачлахад Америкийн Монголчууд баярлана. Тэдний зарим нь Америкт амьдрах амархан ба тэдэн дээр зочилж очсон бүх Монголчууд энэ оронд дуртай байдаг гэлцэнэ.

Америкийн Монголчууд олон шалтгаанаар цагаачилдаг. Ихэнх нь мөнгө олохоор эсвэл сургуульд сурахаар ирнэ. Тэд боловсрол эзэмшиж ажил хийж эхлэхэд бэлэн болоход эсвэл ямар нэгэн бизнэс эхлэхэд хэрэлцэхүйц хангалттай мөнгө цуглуулчихаад эх орондоо буцдаг. Монголд олох мөнгөнөөс илүү өндөр цалин эрж хайж, мөн илүү тохилог сайхан амьдралыг хүсэж Америкт татагдан ирнэ. Тэд хэлэхдээ хамгийн бага хөлс авдаг зөөгч (ажлын эрхтэй зөөгч хүнд цагийн хамгийн бага хөлс ажил олгогч төлдөг) сайн ажиллаж гарын мөнгө авахад л тэр хүн нэлээд их мөнгө олдог гэнэ. Амьдрал сайн тэр ч байтугай амар хялбар байх газар бол Америк бөгөөд гурав, дөрвөн ам бүлээ тэжээх өндөр цалин авдаг газар хэмээн

тэд ам уралдан ярих юм. Тэд сайн ажлын төлөө ирэх ба өмнө нь цагаачилж ирсэн гэр бүлийнхэнтэйгээ амьдарч дараа нь бусад хамаатнуудтайгаа холбоотой болдог.

Монголчууд анх ирэхдээ хэдийгээр эх орондоо чадварлаг боловсон хүчин байсан ч голдуу хамгийн бага цалинтай, гэхдээ Монголын ханшаар бол өндөр, хамгийн муу ажлуудыг хийж эхэлдэг. Ихэнхдээ эрэгтэйчүүд барилга дээр ажиллаж эмэгтэйчүүд зөөгч хийнэ. Эцсийн эцэст тэд Монголд хийж байсан ажлаа мэргэжлийн түвшинд хүргэж дээшлүүлдэг байна. Эмэгтэйчүүд нягтлан бодогч болох нь элбэг.

Америкийн Монголчууд тэнд цагаачлахаар ирсэн ихэнх Монголчууд эх орондоо буцдаг гэдэгт итгэх ба тэдний Америкт амьдрах хугацааны дундаж хэмжээ бол таван жил гэж тооцоолдог. Зарим Монголчууд оюутан болж ирээд магистерийн болон докторын зэрэг автлаа тэнд суралцдаг бөгөөд эх орондоо их дээд сургууль төгссөн, бусад эрдмийн зэргүүдийг авсан олон хүмүүс ч Америкт ирдэг байна. Бусад нь Америкийн байнгын оршин суугчид болдог. Яагаад гэвэл тэд хүүхдүүдтэй бөгөөд тэдний хүүхдүүдэд “хаана байсан ч тус болох” Америкийн соёл заншлыг ойлгож мэдэх, Англи хэл сурах боломжуудыг олгодог гэж тэд үзнэ. Гэсэн ч ихэнх Монголчууд, хүүхдээ Америкт төрүүлж өсгөсөн ч байсан тэд “ямар ч асуудалгүйгээр” гэр бүлээ аваад эх орондоо буцахыг тэмүүлдэг. Тэд ураг төрлийн дотно холбоогоор ах дүү, хамаатан садантайгаа амьдрах амьдралаа санадаг гэж үүнийгээ чухал шалтгаан болгон иш татан тайлбарлана.

Олон Америкийн Монголчуудыг гэртээ буцаж харь хэмээн бусад Монголчууд нь зоригжуулна. Америкийн Бэркли дэх Калифорнийн Их Сургуулийг сэтгүүл зүйн магистерын зэргээр төгссөн монгол эмэгтэй 2009 оны 11-р сард Монголчууд олноор амьдардаг Бэй гэдэг газар очжээ. Тэр эмэгтэй одоо Монголын Үндэсний Телевизийн захирлаар ажилладаг бөгөөд тэндхийн Монголчуудад Барууны маягийн хөгжил, нийгмийн өөрчлөлтүүд Монголд хэрхэн явагдаж байгаа тухай тэдэнд ярьж өгсөн. Түүний үзэл бодлын гол дүгнэлт нь сайн боловсрол эзэмшсэн Америкийн Монголчууд эх орон, ард түмэндээ хэрэгтэй байгаа тухай байсан гэнэ.

Тэдний зарим нь АНУ-д үүрд үлддэг. Тэдэнд монгол цус, монголоо гэсэн зүрх сэтгэл байдаг учраас байнга эх орон, ард түмэндээ тусалсаар байна гэж тэд хэлнэ. Жишээлбэл, Осорын Бадамцэцэг хэлэхдээ тэр Америкт хэрэгтэй, яагаад гэвэл Америкийн шүүхэд Монголчуудад орчуулга хийн цагаачлах асуудлуудад нь тусалдаг. Хэрвээ хүмүүс хүүхэдтэй бол өөрийн насыг харгалзан үзэж Америкт үүрд цагаачлах эсэхээ шийдэж болно. Монголдоо буцахыг хүсэх эсвэл өөртөө юмуу гэр бүлийнхэндээ Америк боловсрол эзэмшүүлэхийг хүсэх хоёрын дунд олон хүмүүс эргэлзэн гацдаг. Заримдаа тэд Америк оронд сурахаар эсвэл ажиллахаар ирэхдээ хүүхдүүдээ Монголд орхиод ирнэ. Ахмад настай цагаачид бараг дандаа гэр лүүгээ буцахыг хүснэ. Харин зарим Америкийн Монголчууд тэнд хүүхдээ төрүүлж өсгөсөн бол Монголдоо амьдрахыг хүсэх эсэхдээ гайхан эргэлзэнэ. Тэд хүүхдийнхээ монгол хэлний чадварт санаа зовох ба заримдаа тэд хүүхдээ “хэт америкжуулахгүйн” тулд хүүхдүүдээ Монголд өвөө эмээтэй нь амьдруулахаар явуулдаг. Мөн зарим хүмүүс хүүхдүүдээ Монголд бас Америкт хоёр оронд өсгөхөөр төлөвлөх ба ингэснээр хүүхдүүд хоёр үндэстэнийг харьцуулан эцэст нь сайхан амьдрах болно гэж найдна.

Монголчуудын тархан суурьшилт

Монголд амьдардаг Монголчууд олон газар луу цагаачилдаг. Аль хот руу эсвэл аль улс руу явах нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Монголчууд өөр өөр хугацаанд өөр өөр газрыг сонгох ба Америкийн нийт Монголчууд ойролцоогоор 15 жил тэнд байгаа. Мөн тэд сайхан боломж байгаа газар луу явдаг. Ихэнхдээ тэдэнд ажил олж өгөхөд туслах найз нөхөд, хамаатан садангууд өмнө нь очихсон байгаа тэр газрыг сонгоно.

Монголчууд эх нутгаасаа өөр оронд явахын өмнө цагаачлалын сайн ба муу талуудыг судалж үздэг. Жишээлбэл, Солонгост байгаа Монголчуудыг хэцүү амьдрал руу зүглэж байна гэж Америкийн Монголчууд бодно. Түүнчлэн Солонгост байгаа Монголчууд хоол, байранд бага зардал гаргах тул гэр лүүгээ их мөнгө явуулах боломжтой хэдий ч сурах ба ажиллахаас өөр зүйл хийхэд боломж багатай гэж тэд үздэг. Солонгост заавал мөрдөх ёстой цагаачлалын хатуу хууль нь Монголчуудын хатуу журамтай амьдралын тусгал болж ингэснээр Солонгост үүрд цагаачлахын эсрэгээр тэд ихэнхдээ эх орондоо буцдаг. Нөгөө талаас нь харахад, Америкийн Монголчууд Солонгост байгаа нутаг нэгтнүүдээ бодвол илүү уян хатан цагаачлалын хуулинд захирагдаж, их мөнгө хийх боломжоор хангагдах боловч тэд мөн амьжиргааны өндөр өртөг, илүү үнэтэй эрүүл мэндийн даатгал төлдөг юм. Тэд Монгол руу, гэр лүүгээ чадахын хэрээр их мөнгө илгээхийг хүсэхийн зэрэгцээ энэ оронд боломжтой бүхнийг хийж ашигладаг. Тэд мөнгөө зугаатай үрж, “бусад Америкчууд шиг амьдрах” бөгөөд аялал зугаалга хийж, зоогийн газар хооллон, хөгжилтэй арга хэмжээнүүдэд оролцож чадна.

Техаст 2000 он хүртэл нэг зуун Монголчууд байжээ. Тэнд төрөл бүрийн ажил, боловсрол эзэмших сайхан боломжууд, байрны үнэ болон амьжиргааны өртөг бага байснаараа бусдын сонирхолыг татдаг байсан. Мөн Канад орон цагаачдад нээлттэй сайхан орон мэт санагдах ба Англи хэл эхлэн суралцагчдын түвшинд ярьж ойлгодог олон хүмүүс байдаг газар юм. Үүний эсрэгээр АНУ-н Луизанна, Алабама, Флорида муж улсуудад Англи хэлний түвшин доогуур хүмүүс ярьж ойлголцоход хэцүү газрууд гэгдэх учир байрны хөлс, амьжиргааны өртөг бага хэдий ч Монголчууд эдгээр мужуудад амьдрахыг хүсдэггүй байна. Одоо олон Монголчууд Япон хэл сурч, тийшээ цагаачилж байгаагийн зэрэгцээ сумо бөхийн дэвжээнд нэлээд хүчирхэг болж байгаа.

Америкийн Монголчууд олон орноор Монголчууд нэлээд их цагаачилдаг гэж боддог. Зарим хүмүүс нийт монгол цагаачдын 20% нь Баруун Европ, 30-40% нь Америк, 30% нь Казакстан руу явдаг гэж тооцоолдог. Үлдсэн багахан хувь нь Герман, Солонгос, Япон, Орос, Хятад, Австрали, Канад, Сингапур луу явдаг байна. Бусад Америкт байгаа Монголчууд бодохдоо нийт монгол цагаачдын тал хэсэг Солонгос руу, гуравны нэгээс их нь Америк руу, үлдсэн хэсэг Европ ба Япон луу явдаг гэнэ. Олон хүмүүс хууль бусаар цагаачлах тул нийт монгол цагаачдын албан ёсны тоог гаргахад хэцүү юм. Монголчууд хэрхэн дэлхий даяар тархсан нь Америкийн Монголчуудын хувьд чухал бөгөөд яагаад гэвэл бусад Монголчууд цагаачлалын талаархи өөрсдийн ойлголт дээр үндэслэн гадаад орнууд руу цагаачилдаг.

АНУ-д Монголчууд бөөнөөрөө байдаг цөөхөн газар байна. Газар бүр өөрийн оршин суугчдын санаачлагаар соёл ёс заншлын сургуультай байх бөгөөд тэд дандаа найз нөхөд, хамаатнуудынхаа цагаачилж очсон газар очиж амьдарна. Нэг жишээ нь Калифорн мужийн Бэй гэдэг газарт хамгийн олон Монголчууд байх ба гурваас дөрвөн мянга орчим байна. Энэ нутаг нэгтний бүлгийн хүрээ хурдан тэлж байгаа бөгөөд 2000 онд энэ газарт зөвхөн 1500 орчим Монголчууд байсан бол 2002 онд хоёр мянга болжээ. Тэд тэндхийн дулаахан, сайхан цаг агаар, амьжиргааны харьцангуй бага өртөг, олон янзын соёл заншил, тайван амгалан байдал, нийгмийн нам гүм байдал, Монголын хотуудтай харьцуулахад өндөр хөгжилтэй байдаг нь дуртай.

Америкийн Монголчууд олноор амьдардаг газруудыг томоос жижиг рүү нь авч үзвэл дараагийн томоохон газар нь Вашингтон хот, Калифорн мужийн Лос Анжелос хот, Вашингтоны Сиатл (хот биш, муж) Илиноис мужийн Чикаго гэх мэт. Мөн Калифорн мужийн Сакрэменто-д монголчууд байдаг. Вашингтон хотын монголчууд Монголын элчин сайдын яамтай сайн харилцаатай байдаг.

Хууль ёсны ба хууль бус цагаачлал

Америкийн Монголчууд хууль ёсоор болон хууль бусаар аль алианаар нь цагаачилна. Тэд тухайн оронд хууль ёсоор байх визний хугацааг хэтрүүлэн үлддэг боловч АНУ-д цөөхөн Монголчууд амьдардаг учир Латино цагаачлалын албанд ханддаггүй гэж хэлнэ. Хэрвээ тэд гэмт хэрэг хийх, байнга согтуугаар жолоодох зэргээр баригдах шалтгаан гаргахгүй бол Бэй-д амьдрах нийт Монголчуудын талаас илүү нь Америкт хууль бусаар байдаг. Хууль бус цагаачдын нэг асуудал бол тэд эх орондоо зочилж очиж чаддаггүй. Хэрвээ тэд Америкаас явбал буцаж ирж чадахгүй учраас энэ оронд мөнгө олохоор ирсэн хүүхэдтэй хүмүүс хүссэн зорилгодоо хүрч явахад бэлэн болтлоо энэ орныг орхиж чаддаггүй байна.

АНУ-н ба Монголын засгийн газраас Ганзүрх хэдэн Монголчууд виз аваад визнийхээ хугацаанд тэдний хэд нь эх орондоо буцаж ирдэггүй тухай асуужээ. Үүний хариуд ойролцоогоор 17000 Монголчууд тэнд байх ба тэдний 80% нь эргэж ирдэггүй гэсэн байна. 9-р сарын 11-ны террорист халдлагаас өмнө тэд цагаачлалын нөхцлөө хялбарханаар өөрчилж чаддаг байсан ба аялалын визтэй очсон хүн оюутны визээр сольж, оюутны визтэй хүн ногоон карттай болж, байнгын оршин суугч болох эрхтэй болсон. Харин одоо визний нөхцлийг солих эсвэл виз сунгахад хэцүү болжээ. Яагаад гэвэл цагаачлах асуудлаар ажилладаг өмгөөлөгч хуульчдын цалин хөлс өндөр ба цагаачлалын бодлогод гэнэт өөрчлөлт гарсан болохоор олон Монголчууд энэ оронд хууль ёсны дагуу байхыг оролдохоос шангарсан. Америкт хууль бусаар өссөн хүүхдүүд сургуульд суралцаж болох хэдий ч тэндхийн оршин суугчид биш юм. Эдгээр хүүхдүүдийг эх оронд нь буцаахыг шаардах бөгөөд магадгүй тэд монгол хэлээр ярьж чаддаггүй, бас монгол соёл ёс заншлаа мэдэхгүй байж болох юм.

Монголчууд ба Америкчуудын бие биеэ үзэх үзэл бодол

Америкийн Монголчууд бодохдоо Америкчууд Монголын тухай маш бага мэддэг хэдий ч Монголчууд Америкийн тухай бага ч болов мэдэхийг зорьдог гэнэ. Тэд Монголчууд тэр орны соёл заншлын бүх зүйлийг мэдэхгүй боловч Америкчууд хэрхэн ажиллаж амьдардагыг сайн мэднэ хэмээн талархалтай ханддаг. Хөрөнгөтөн нийгмийн сайн, муу талуудыг олж харах бөгөөд түүнчлэн, Америкчуудын дэлхий ертөнцийн талаархи сонирхол бол хил хязгаараа бусад орнууд руу өргөтгөх гэж ойлгоно. Бусдын тухай илүү ихийг сурч мэдэхийг хүсэж байна уу эсвэл хэрэгтэй байна уу аль нь ч байсан өөрсөддөө болон дэлхий ертөнцийн тухай мэдлэгтээ сэтгэл хангалуун байдаг Америкчуудтай харьцуулахад бусдын амьдралыг ойлгохыг хүсдэг сониуч хүмүүс гэж Америкийн Монголчууд өөрсдийгөө тодорхойлдог. Үүнтэй уялдан Америкчууд сургуульд хүүхдүүдэд Монголын тухай заадаггүйг Монголчууд гайхна.

Тэд Чингэс хаан, Монгол нэг үе Оросын колони орон байсан, мөн Америкт мэддэг Монгол хоол болох монголын шарсан мах буюу үнэндээ бол Хятадаас авчирсан үхрийн махаар Америкчуудын Монголын тухай ойлголт хязгаарлагдана гэж хэлдэг. Зарим Америкчууд Монголчуудын тухай ерөөсөө сонсоогүй байдаг. Хэрвээ тэдний зарим Монголын тухай сонссон бол тэнд машин, барилгууд байдаг эсэхийг байнга сонирхож асууна. Зарим барууныхан Монголчуудыг ууртай догшин, ширүүн хүмүүс байдаг мэтээр төсөөлдөг. Мөн тэд Америкийн Монголчуудыг хараад бусад Азийн орны хүмүүсээс ялгаж хэлж чаддаггүй ба тэднийг Хятад эсвэл Солонгос хүн мөн үү гэж асууна. Сарнай өөрийгөө Монгол хүн гэж хэлэхэд гадаадынхан хариуд нь “Камбожи гэнээ?” гэж дандаа асуудаг гэнэ.

Бадамцэцэг хэлэхдээ Америкчууд Монголын амьдралын тухай янз бүрийн үзэл бодолтой гэнэ. Тэр өөрөө гэрт өсөөгүй, хотод байранд өссөн. Тэр хүүхэд байхдаа сурагчдын амралтаар гэрийнхэнтэйгээ тэдний үеэлийнд хөдөө очиж амарчээ. Тэгэхэд Бадамцэцэг өглөө эрт босож, гэрийн ажилд туслан голоос ус зөөх хэрэгтэй байдаг байсан

тул түүнд энэ бүхэн хэцүү санагдаж, эвгүй байсан. Түүний нэг гадаад найз Монгол руу аялж, гэрт амьдарч байгаад ирсэнийхээ дараа Бадамцэцгийг гэрт хэзээч амьдарч үзээгүй, бас морь унаж чадахгүйг сонсоод их гайхжээ.

АНУ-ын засгийн газар Монголчуудын тухай өөрийн үзэл бодолтой. Ганзүрхийн уншсан 2004 оны Монголын тухай тайланд бичиг үсэгт 98% нь тайлагдсан боловч Монголчууд залхуу, амласан амлалтандаа хүрдэггүй гэж Монголчуудыг тодорхойлсон байжээ. Бид амьжиргааны хэрэгцээг хангадаг таван хошуу малаа малласаар ирсэн болохоор улс орон даяараа удаан хугацааны турш өлсгөлөн байж үзээгүй учраас бид салан задгай, залхуу зантай гэж Ганзүрх үүнийг тайлбарладаг. Ганзүрхийн хэлснээр Монгол орон их өлсгөлөнд хэзээ ч нэрвэгдэж байгаагүйгээрээ олон зууны туршид өлсөж байсан Зүүн Азийн орнуудаас ялгаатай байдаг гэнэ. Яагаад гэвэл эдгээр орнууд үер, ган гачигт эмзэг газар тариалангийн орнууд юм.

Америкийн Монголчууд өөрийн орныг хөгжлөөр Америкаас 70-100 жилийн хойно байгаа гэж тодорхойлдог. Бусад нь хоёр оронд аль алинд нь амьдрал адилхан байна, гэхдээ Монголд тэд олон хүмүүстэй уулзаж, илүү олон найзуудтай, уйдаггүй гэж хэлнэ. Баруунд байхын бас нэг ашигтай тал бол өвөрмөц соёл заншилтай, өөр хэлтэй Монголын тухай гадаадынхан тэндхийн монголчуудаас илүү ихийг мэдэх болно гэх бөгөөд Монголчууд бол ямар ч зүйлийг сурах чадвартай, бусадтай адил хүмүүс гэдгийг дэлхий ертөнцөд таниулахыг хүсдэг гэж тэд ярина.

Эх оронтойгоо холбоотой байх сайхан.

Америкийн Монголчууд эх оронтойгоо олон янзаар холбоотой байдаг. Тэдний зарим нь удаан хугацаагаар Монгол руугаа явж болох ногоон карттай учир гэр бүлийнхэнд нь бусад хүмүүс тусалж байх зуур Монголд тогтмол зочилж очно. Тэднийг гэрээ санахад ар гэрийнхэн нь Монголоос тараг, цай, ааруул явуулна. Эх орондоо байхаас цөөхөн найзуудтай байж, нийгмийн амьдралын идэвх муутай байдаг учраас байнгын асуудалтай учруулдаг орон гэж настайчууд үзэх тул тэд Америкт байнга амьдрах дургүй.

Тэд эх оронтойгоо болон Монголчуудтай техник, технологийн хөгжлийг ашиглан холбоотой байдаг. Гэр лүүгээ интэрнэтээр захиа бичиж, хайртай хүмүүстэйгээ Yahoo Messenger ашиглан харилцаж, Монголын тухай мэдээ мэдээллүүдийг интэрнэтээс унших гэх мэт. Мөн тэд утсаар ярина. Арван жилийн өмнө Америкаас Монгол руу ярихад нэг минутын яриа таван долларын үнэтэй байсан бол одоо Монгол доторхи ярианы үнэтэй адил хямд болсон тул тэд магадгүй өдөржин утсаар ярих үе байдаг.

Америкийн Монголчууд эх орны телевизүүдийн сувгууд болон кинонууд үзэх боломжтой. Монгол телевизийн зарим сувгууд Америкийн амьдралыг Монголд үзүүлж, Бэй гэдэг газарт байх Монголчууд эх орны сувгуудыг интэрнэтээр үздэг. Мөн цөөн сувгуудын нэвтрүүлүүдийг Монголд гарснаас нь хойш нэг өдрийн дараа интэрнэт холбогч ашиглан гэртээ зурагтаар үзэж чадна. Нэмж хэлэхэд, Монголын хоёр сувгийг сансрын антеннаар зурагтаар үзэх боломжтой.

Америкийн Монголчуудын энэрэнгүй сэтгэл

Америкийн Монголчууд эх орондоо байгаа нутаг нэгтнүүддээ янз бүрээр туслахыг хичээдэг. Сарнайгийн оролцдог “Нялхсаа аварцгаая” нэртэй Монголчуудын байгууллага байдаг ба тэд Монголын Эх Нялхсын Төвийн Нярайн эрчимт эмчилгээний тасагт эмнэлгийн тоног төхөөрөмж олж өгөхөд тусалдаг. Өөр нэг байгууллага гэр оронгүй Монголчуудыг хоол хүнсээр хангадаг. (Монголын хүн амын тал нь гэр оронгүй болон өлсгөлөн байхын аргагүй уламжлалт нүүдлийн мал аж ахуйн хэв маягаар амьдрах боловч ийм асуудлууд голдуу Улаанбаатарт байдаг)

Америкт амьдардаг Монгол хүн бүр гэр лүүгээ юм явуулдаг. Өмнөх жилүүдэд тэд мөнгө явуулдаг байсан бол одоо голдуу эд зүйлс илгээнэ. Тэдний гэрийнхэндээ илгээх мөнгө Монголын эдийн засагт чухал тус нэмэр болох бөгөөд зарим Монголчууд хилийн чанадаас ирэх мөнгөнд найдан тэр мөнгөөр амьдардаг. Яагаад гэвэл Монголчуудын цалин сард ойролцоогоор нэг зуун долларын хэмжээнд хэлбэлзэх ба хоол хүнс, амьжиргааны өртөг Монголд өндөр байдаг. Америкт байгаа Монголчуудын ар гэртээ явуулж буй бэлгэнүүд татваргүй байх хэдий ч Ганзүрх банкуудтай хамтран Монгол руу илгээгдэх бэлгийн хэмжээг тогтоохыг хичээсэн бөгөөд чухам яг хэр зэрэг их зүйл илгээгддгийг хэлэхэд хэцүү юм. Тэр яагаад үүнийг сонирхсон бэ гэхээр Америкийн Монголчууд нутаг нэгтнүүддээ маш их тусалдаг учир Монгол орон Америкийн Монголчууддаа мөн адил туслах хэрэгтэй гэж Ганзүрх боддог. Монгол улс тэднийг эх орондоо боломжийн хямд байртай болгох тал дээр туслахыг тэр хүсдэг хийгээд хилийн чанад дах Монголчуудаа дэмжих төрийн бус байгууллага 2004 онд байгуулжээ.

Монголд гамшиг тохиолдоход тэд тэр даруйд нь тусална. 2009-2010 оны өвлийн зуд болоход мөнгөн хандив цуглуулж, Монголчууддаа туслах эд зүйлсийг хандивлажээ.

Ялгаварлан гадуурхагдах

Монголын ястангууд хоорондын, Монголчууд болон Азийн бусад ястангуудын дунд байх ялгаварлан гадуурхах явдалтай харьцуулахад Америкт энэ байдал бага ажиглагддаг гэж Америкийн Монголчууд тодорхойлдог. Монголд дийлэнх болох халх үндэстэнгээс бусад ястан хүмүүс тодорхой албан тушаалд дэвшихэд халхууд тэднийг 100% монгол биш гэж дандаа хэлэх ба ийм үед жижиг ястангууд эмзэглэдэг. Мөн жижиг ястангууд хэлний аялганаасаа зовж шаналдаг байна.

“Тамд хоёр тогоо байдаг. Эхний тогоонд Монголоос бусад энэ дэлхийн бүх үндэстэнүүд байхад харин нөгөө тогоонд Монгол үндэстэн байна. Эхний тогоог чөтгөрүүд манана. Нөгөө тогоог хэн ч манахгүй. Учир нь тэр тамын тогооноос хэн нэгнийг гарахыг хичээхэд Монголчууд түүнийг татаад буцааж унагаана” хэмээх зүйр үгээр Монголын ястангууд бие биеэ ялгаварлан гадуурхдаг гэж Ганзүрх тайлбарласан юм. Бэй гэдэг газрын Монголчууд бие биеэ ялгаварладаггүй. Яагаад гэвэл тэд тэнд хэтэрхий цөөхүүлээ учраас Монголын өөр өөр ястангууд бие биеэ дэмжих хэрэгтэй байдаг гэж тэндхийн Монголчууд ярьдаг. Хэдийгээр тэд ястангуудын ялгаатай талуудын талаар ярилцах боловч өөр хоорондоо ялгаварлан гадуурхдаггүй.

Монголд зарим Монголчууд Хятад хүмүүст дургүй. Зарим хүмүүс Манжийн колончлолоос болоод ингэх болсон гэж хэлнэ. Зарим Монголчууд хятад хүнтэй нөхөрлөөд дараа нь тэдэнд залилуулдаг тал байх бөгөөд Хятад Монголын эрлийз хүмүүсийн өв уламжлал байнга ялгаварлан гадуурхах асуудалтай нүүр тулдаг. Мөн Хятадыг эсэргүүцэх Монголчуудын үзэл социалист төр засгийн тархи угаах ажиллагаанаас үүссэн гэж зарим нь үзэх ба Монголд жинхэнэ Хятад хүнийг үзээгүй хэрнээ зөвхөн Хятадыг эсэргүүцэх үзэл суртал байдаг гэж ярина. Зарим хүмүүст 1950-1960 онуудад багассан Хятадыг эсэргүүцэх үзэл одоо хүртэл байдаг. Одоогоор Хятадуудад Монголчуудын дургүйцэл нүүрлээд байгаа. Яагаад гэвэл Хятад улс Монголын газар нутагт санаархдаг мэтээр ойлгогдох болсон. Чингэс хаан хятад хүн байсан эсвэл үнэндээ Монгол бол Хятадын нэг хэсэг гэх мэтээр Хятадын улс төрчид буруу бодлого барьж дайралт хийж байгаа. Ердөө гуравхан сая хүн амтай жижиг улс гэдгээ Монголчууд баттай мэддэг учраас Хятадыг эсэргүүцэх үзлийн нэг шалтгаан бол Хятадын ноёрхолоос айх айдаас юм.

Америкийн Монголчуудын зарим нь тэд Америкийн Хятадуудтай эвтэй байдаг гэдэг. Тэд Америкийн холимог тогоонд (өөр хоорондоо ялгаатай соёл заншилтай хүмүүс Америкт хамтдаа холилдсон гэсэн утгатай үг) холилдохыг үзэн яддаг. Хятадын нутаг

нэгтнүүдээсээ тэд өөр гэж Америкийн Монголчууд Америкийн Хятадуудын тухай ярина. Тэндхийн хятад хүмүүс сайн бизнесмэнүүд шиг харагдаж, Америкийн Ази хүмүүсийн үлгэр жишээ болсон цагаачид юм. Жишээлбэл, Америкийн Монголчуудад байхгүй сайхан соёлын төв Америкийн Хятадуудад Окландад байдагт тэд баярладаг.

Хятад хүмүүс ямар оронд байгаагаа тоодогдуйд нь дургүй хүрдэг гэж зарим монголчууд хэлдэг. Тэд ингэх нь ёс суртахуунгүй гэдгийг мэдэх боловч тэдний дургүйцэл “цусанд маань” байгаа гэнэ. Тэд дургүйцлээ тодорхойлохдоо өдөр бүр дургүйцэх мэдрэмж төрөөд байдаггүй ч хэрвээ хятадууд Монгол хүнийг зодох эсвэл маргалдах мэтээр доромжлохыг харвал эмзэглэнэ гэдэг. Америкчуудаас Монголчуудыг эсэргүүцэх дургүйцлийг Америкийн Монголчууд мэдэрдэггүй хэдий ч Ази хүмүүст дургүй байдлыг мэдэрдэг гэнэ. Америкчууд ажилд Ази хүмүүсийг хөлсөлж авдаг.

Цагаачлалын түүхүүд

Монголчуудын Америк руу аялсан түүхүүд өөр хоорондоо өвөрмөц ялгаатай бөгөөд энгийн байдаг. Дараах цөөн түүхүүд нь Америкийн Монголчуудын түүхүүд юм.

Осорын Бадамцэцэг

Бадамцэцэг 42 настай, Монголын зүүн хэсэгт байх Дорнод аймагт төрсөн бүсгүй. Тэр 16 настай охинтой эх хүн бөгөөд бусад ихэнх монголчуудын адил халх хүн. Дорнодод өсөж, ерөнхий боловсролын сургууль төгссөнийхөө дараа Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуульд суралцахаар Улаанбаатар луу нүүсэн. Хоёрдугаар дамжаа төгссөний дараа Орос хэлний багшийн мэргэжлээр сурч байсан учир Оросод сурахаар явжээ. Түүнийг 1991 онд Монголд буцаж ирэхэд социалист дэглэм нуран унаж, ардчилсан чөлөөт эдийн засгийн үе эхэлсэн байсан. Бүх зүйл түргэн өөрчлөгдсөн бөгөөд Бадамцэцэг болон бусад монголчууд зөвхөн Оросын соёл заншлыг мэддэг, Барууны ёс заншлыг мэддэггүй байв.

Социалист нийгмийн үед хүмүүс эдийн засгийн хувьд зөвхөн нэг ижил түвшинд байсан бөгөөд нэг ч хүн ядуу эсвэл баян байгаагүй. Бадамцэцгийн бодлоор тэр үед хүмүүст эдийн засгийн сонирхол байгаагүй. Жишээлбэл, өндөр боловсролтой мэргэжил эзэмшихийг зорьвол эмч гэх зэргийн мэргэжилтэй болдог байсан гэнэ. Сургуулиа дүүргэсний дараа тэр гэрлэж, охин төрүүлж, гар урлал хийдэг болсон боловч түүний шинэ гэр бүлд санхүүгийн бэрхшээлүүд тулгарчээ. Нөхөр нь ажилгүй байсан учраас Англи руу яваад ирсэн, их сургууль хамт төгссөн сайн найз нь түүнийг Англи хэл сурч сайн ажил олж хийгээд, нээлттэй ажиллах чадвараа хөгжүүлэхийг зөвлөсөн. Бадамцэцэг найздаа хүүхэдтэй эх хүн гэдгээ сануулж хэлэхэд найз нь түүнд шинэ боломжууд хайхад нас чинь сайхан залуугаараа байна гэж хэлжээ. Тэгэхэд түүний нөхөр түүнийг Баруун луу явж суралцаад сайн цалинтай ажил хий хэмээн зоригжуулсан байна. Гэхдээ тэр гэр бүлээ орхиод явахдаа уйтгар гунигт автаж байсан ч 1994 онд ерөөсөө мэдэхгүй байсан Англи хэлийг сурахаар Англи орныг зорьжээ.

Англид байхад нь Монголын амьдрал түүнд их хатуу хэцүү санагдаж эхэлсэн бөгөөд Барууны хөрөнгөтөн оронд сайн ажил хийвэл хөрөнгө мөнгө олж болохыг ухаарч, Монгол улс яагаад энэ оронтой ижил замаар яваагүйг гайхдаг байлаа. Тэгээд хорин хэдэн насандаа шинэ санаа бодол өвөрлөн Монголдоо буцаж ирсэн. Урьд нь хар, цагаан санагддаг байсан ёс суртахуун илүү нарийн ялгаатай санагджээ. Муу гэж санагдсан хүн ч сайхан сэтгэлтэй байж болохыг ойлгож, “эх хүнээс төрсөн” бүх сайн ба муу өөрийн таньдаг хүмүүсийг санахыг оролдсон.

Монголд Англи хэлтэй хүний хэрэгцээ гэнэт бий болж, тэгээд тэр Гэгээрлийн яаманд ажиллаж эхэлсэн боловч тэр төслийн хөрөнгө мөнгө дуусч төслийн ажил дууссан байна. Санхүүгийн хувьд тогтвортой болохын тулд оюутны визээр Америк руу явахаар шийджээ.

Тэр тийшээ ганцаар явж, нөхөр нь Монголд үлдсэн байна.

Америкт байрны хөлс төлөх, хоол худалдаж авах, амьжиргааны бусад зардал төлөх шаардлага гарч, бас гадаад оюутны хувьд сургалтын төлбөр их өндөр байв. Гэвч түүнд энэ орон таалагдсан бөгөөд Монголоос маш өөр, олон янзын байр байдалтай байлаа. Тэр Англид байгаа нөгөө сайн найзтайгаа холбоо барихыг хүссэн ба тэр найз нь түүнийг Америкт цагаачлах боломжуудыг хайхыг ухааруулж өгсөнд маш их баярласан юм.

Тэгээд Бадамцэцэг сургуулиа хаяж зоогийн газарт ажил олжээ. Тэр үед охин нь 7 настай байсан ба охиныгоо сайн боловсролтой болж сайн Англи хэлтэй болгохыг хүсч, түүнийг Америкт авчрахаар хөөцөлдөж эхэлсэн. Нэг жилийн дараа түүний хүсэл биелсэн байна. Хамгийн анх охиноо Америк сургуульд оруулахад тэр ямар ч Англи хэлгүй байсан учир сургуульд дургүй, Монголдоо буцахыг хүсчээ.

Тэгээд тэр охиндоо “За ойлголоо. Гэхдээ чамайг буцаах мөнгө надад хэрэгтэй байна. Хоол хүнсээ авахын тулд би сайн ажиллах хэрэгтэй байна. Чиний буцах замын зардал хэрэгтэй байна” гэж хэлэв. Түүний охин Монгол руугаа буцахыг шаардах бүрт тэр түүнд “Би боловсролтой болох хэрэгтэй байна, чи Англи хэл сурах хэрэгтэй байна” гэж хэлдэг байв. Тэдэнд эхний хоёр сар их хэцүү байсан ч охиндоо гэрийн багш хөлсөлсөн учраас охин нь сургуульд өөрийн насны түвшинд суралцаж эхэлсэн. Охиноо хувийн жижиг сургуульд оруулж Англи хэлний дөрвөөс зургаа дах анги хүртэл хоёрдогч хэлний ангид явуулж (хүүхдүүд энгийн ангид орохын тулд Англиар хангалттай сайн ярьдаг болох хүртлээ суралцдаг анги) дараа нь тэр дээд түвшиний долоодугаар ангид элсэн орсон байна.

Бадамцэцэг Сан-Франциско дах амьдралдаа хайртай. Хамт ажилладаг нэг хүн түүнд сайхан цаг агаартай гоё газар гэж зөвлөсний дагуу тэр энэ хотод нүүж ирсэн. Тэр үүнтэй санал нийлж байв. Сан-Франциско бол нийтийн унаа сайтай сайхан жижиг хот санагдсан бөгөөд тэр жолоо барьж чадахгүй болохоор энэ нь түүнд хэрэгтэй зүйл байлаа. Хятадууд, Япончууд, Оросууд, Италичууд, Германчууд, Арабууд гээд л бүх орны хүмүүс амьдардаг энэ газарт амьдрах тэр дуртай байсан. Энэ хотод тэр одоо 10 жил амьдарч байна. “АНУ бол аз сорьсон газар. Гэхдээ та амжилтанд хүрвэл хүссэн бүхнээ авч болно. Та ажил хийвэл бүх зүйлтэй болж чадна. Энд та мэргэжлийн өндөр түвшинд байх хэрэгтэй ч та сайн ажиллаж чадвал эцсийн эцэст таны мөрөөдөл биелнэ” гэж тэр хэлдэг.

Бадамцэцгийн Англид өнгөрүүлсэн цаг хугацаа нь түүнийг Баруунд байнга амьдрах хүсэлтэй болгосон гэж боддог. Энэ бол Барууны орон байсан бөгөөд тэр дэлхий бөөрөнхий гэдгийг ухаарсан юм. Түүнд бусад үндэстэнүүд соёлжсон, орчин үеийн санагдах ба Монгол яагаад ийм өөр бас ядуу байдгийг гайхжээ. Социализм түүний тархийг угаасан байсан гэж тэр бодно.

Чойжилжавын Даваадулам

Даваадулам 42 настай, Улаанбаатар хотоос ирсэн, 1997 онд Америкт цагаачилж ирсэн хүн. Тэр анх Америкт ирэхдээ тэнд байнга цагаачилж үлдэхийг зориогүй, зөвхөн 6 сар амьдраад буцна гэж төлөвлөсөн байсан. 1990-ээд онд ирсэн ихэнх Америкт байгаа Монголчууд буюу шинэ зууны эхний үеийн хүмүүс эх орондоо буцна хэмээн төлөвлөдөг байжээ. Одоо олон Монголчууд Америкт үлдэхийг хүсэж ирдэг.

Даваадулам Америкт нягтлан бодогчоор ажиллаж сайхан тохьгой амьдардаг. Америкт байгаа Монголчууд эх орондоо байнга очиж уламжлалт соёлоо хадгалж байх хэрэгтэй гэж тэр ярина. Мөн эдийн засаг сайтай газар амьдарснаар ашигтай байхын зэрэгцээ уламжлалаа хадгалсан Монгол хүн байх замаар энд амьдарна гэж үздэг. Түүний аав Орост сурч байсан тэр үед Даваадулам жижигхэн охин байсан. Москвад өнгөрүүлсэн цаг хугацаа түүнийг Барууны амьдрал бэлтгэж байсан учраас тэр үеийг үнэлдэг.

Ганзүрх

Ганзүрх 37 настай, Улаанбаатарт төрсөн, Дархад ястан. Америкт 1999 онд ирсэн бөгөөд 2 охины эцэг хүн.Охидууд нь 3 настай, 9 сартай. Москвад дөрвөн жил суралцаж дараа нь Америкт ганцаараа ирсэн. Тэр ирэхээсээ нэг жилийн өмнө Америкийн соёл заншлыг үзэж танилцуулахаар ахыгаа явуулжээ. Тэгээд тэр энэ оронд ирсэн цагаасаа Монголчуудынхаа дунд идэвхтэй нэгэн байв. Тэр анх ирээд Америк орны соёл заншил, нийгмийн амьдрал, алсын ирээдүйгээ мэддэггүй боловч өөр хоорондоо дотно, бие биендээ тусалдаг, ойр дотно хэсэг Монголчуудыг олсон. Тэгээд тэр Бэй хэмээх энэ газарт Монголчуудын анхны холбоог байгуулж, хувь нэмрээ оруулахаар шийджээ. Түүний холбоо баяр ёслолууд, тухайлбал 7 сарын 11-ны наадам, 11 сарын 26-ны Улс тунхагласны баяр, Цагаан сарыг тэмдэглэхэд Америкийн Монголчуудад тусалдаг.

Ганзүрх Америкт амьдрахаар үлдсэн хэдий ч Америк орон таалагдаагүй учир эх орондоо буцсан олон хүмүүсийг мэднэ. Англиар сайн ярьдаг ахынхаа тусламжтайгаар тэр ямар нэгэн бэрхшээлтэй тулгаралгүй ажилтай болжээ. Одоогоор тэр Америкт сайхан амьдарч байгаа хэдий ч насан туршдаа энд үлдэж чадах эсэхээ мэдэхгүй байгаа.

Ганзүрх бизнэсмэн хүн ба Монголын поп од Сарантуяаг Америкт авчран Монголчууддаа зориулж тоглолт зохион байгуулсан байна. Калорода мужийн Дэнвэр, Калифорнийн Сан-Франциско, Вашингтон хот, Илинойсын Чикагод тогложээ. Тэр дараагийн бизнэс төлөвлөгөөндөө мөнхийн хөл хөдөлгөөнтэй Бэй гэдэг газарт Монгол гэр байхгүй учир гэр музей байгуулах санаатай байна.Ганзүрх Америк оронд дуртай. Яагаад гэвэл энэ газарт хүмүүс хүсэл мөрөөдлөө гүйцэлдүүлэх боломжтой гэж үздэг.

Сарнай

Сарнай 28 настай, Улаанбаатраас ирсэн, Халх үндэстэн. Тэр Америкт таван жил амьдарч байна. Хоёр хүүхдийн эх хүн бөгөөд хүүхдүүд нь 8 настай, 2 настай. График дизайны болон урлагын чиглэлээр сурч байгаа ба мэргэжлийнхээ хувьд өсөх чадваруудыг эзэмшихийг хүсэж энд ирсэн бөгөөд сургуулиа төгсөөд Монголдоо буцах төлөвлөгөөтэй байгаа.

Сарнайгийн найзууд Сан-Францискод байдаг тул тэр тэнд очиж амьдарсан. Тэр урьд нь Солонгост очиж үзсэн бөгөөд гадаадын өөр оронд очиж үзээгүй. Түүний Америкийн тухай анхны сэтгэгдэл нь таагүй байсан. Бүх зүйлүүд, модод, замууд, тэр ч байтугай хүмүүс нь түүнд хэтэрхий том санагдсан гэнэ. Монголд байхдаа тэр эрүүл мэнд, агаарын бохирдол, хүнсний аюулгүй байдалд санаа зовдог байсан бол Америкт эдгээр асуудлууд бага гэж тэр боддог. Тэр Монгол руу байнга холбоотой байж, сургуулийнхаа амралтаар хэд хэдэн удаа нутагтаа зочлоод иржээ.

Монголдоо буцахад айх зүйл түүнд байгаа ба авилгал, хээл хахууль болон ажилд ороход хэрэгтэй танил талын сүлжээ. Эдгээр асуудалтай тэмцэхийн тулд тэр одооноос судалж холбоо тогтоохыг хичээж байгаа бөгөөд тэгээд нутагтаа очоод ажил олох болно. 2009 онд Сарнай Монголд очоод Техникийн Их Сургуульд зочлоход тэд түүнийг сургуулиа багшаар ажиллуулахаар сонирхож байсан гэнэ. Зарим Монголын ажил олгогчид ажилтануудыг ажилд авахдаа шударга хандахыг хүсдэг гэж Сарнай найддаг. Бас нэг өөр зүйл бол түүний хүүхдүүд Америкийн ёс заншил дунд өссөн Америкийн иргэд бөгөөд түүний 8 настай хүүхэд Монголд дасахад хэцүү байж магадгүй гэж санаа зовно.

Нийгмийн бүтэц

Монголын болон Америкийн засгийн газрууд

Америкийн Монголчууд хоёр орны засгийн газарт их анхаарал хандуулдаггүй хэдий ч Америкийн засгийн газрыг бодвол Монголын засгийн газарт илүү анхаарлаа чиглүүлдэг.

Ардчилал хөгжөөд хорин жил болсныг үл харгалзан Монголын засгийн газар “нэг далайгаас нөгөө далай руу” худалдагдсан гэж тэд үздэг байна. Их хурал шаардлагагүй зүйлд мөнгө урж, орж ирсэн санхүүжилтийг идэж шамшигдуулдаг ба Их Хурлын гишүүд бол Монголдоо хамгийн баян хүмүүс бөгөөд том бизнэсүүд,тансаг гэр орон, машин өмчлөдөг гэж тэд хэлнэ.Тэдний Их хуралд орохын гол шалтгаан бол зөвхөн хувийнхаа амьдралыг дээшлүүлэх гэж Америкийн Монголчууд боддог. Цөөн хэдхэн гишүүд улс орныхоо төлөө анхаардаг боловч тэд алуулж болзошгүй аюултай нөхцөлд байдаг гэж үзнэ. Америкийн Монголчууд хэлэхдээ засгийн газрын хэлж байгаа бүх зүйлүүд худлаа ба ард түмний ядуу болон дундаж ангийнханд Монголын засгийн газрын доройтол завхрал хариуцлага хүлээх ёстой гэдэгт итгэдэг гэнэ. Түүнчлэн, Монголын хуулийн систем шударга биш бөгөөд хуулиуд нь мөнгөтэй хүмүүст амар хялбар, ядуу хүмүүс шүүхийн байгууллагуудад итгэхэд хэцүү болсон. Монголын засгийн газар зөвхөн ард түмнийхээ төлөө илүү ихийг хийгээд зогсохгүй Америкт амьдардаг Монголын цагаачдад туслах хэрэгтэй гэж тэд боддог. Засгийн газар тэдний төлөө ажиллах байгууллага байгуулж, холбоотой байхад нь тусалж, хууль бусаар Америкт байгаа Монголчуудад эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой болгоход туслахыг тэд хүсдэг. Америкийн Монголчууд 2009 онд ерөнхий сайд тэдэнд баярлаж талархсанаа илэрхийлсэн шиг Монгол орон тэдний эх орондоо илгээдэг мөнгөнөөс тодорхой хэмжээгээр хамаардаг тул Монголын засгийн газар тэдэнд өртэй гэж тэд боддог. Яагаад гэвэл тэдний зарим нь хуваалцах хангалттай мөнгөтэй үедээ Монгол руу сар бүрийн хэрэгцээний мөнгийг тэтгэвэрт гарсан эцэг эхдээ эсвэл төрсөн ах дүүдээ илгээнэ. Олон ядуу хүмүүс засгийн газарт итгэхээ больсон тул засгийн газартай тэмцэлдэхээ больсон. Тэд амьжиргааны наад захын хэрэгцээний талаар гомдоллоод нэмэргүй болсон ба үүний оронд Америкийн Монголчуудын тусламжийг хайдаг.

Америкийн Монголчууд Монголын засгийн газрын ажилчид болон бусад ажил олгогчидын танил талын сүлжээ гадаадад боловсрол эзэмшсэн мэргэжилтэнгүүдийг гомдоодог гэж ярина. Заримдаа тэдний эх орондоо байгаа найзууд нь тэднийг Монголдоо буцаж ирээд ажилтай болох танил талын сүлжээний эсрэг тэмцэхийг зоригжуулах боловч тэднийг буцаж ирэхэд заримдаа Монголчуудад Америкт байсан Монголчууд манай орны байдлыг мэдэхгүй, тэд Америкдаа л байх хэрэгтэй гэсэн хандлага байдаг гэж тэд хэлж байлаа.Гэсэн ч тэд байдал дээрдэж байгаад талархаж, иймэрхүү завхрал өөр хэлбэрээр Америкт ч байдаг гэж ярьсан.

Америкийн Монголчууд Америкийн засгийн газрыг шударга гэж их бахархдаг гэнэ. Тэд Америкийн засгийн газар гэмт хэргүүдийг үнэн шударгаар шүүж, гэр оронгүй ядуу хүн, эсвэл баян хүчирхэг хүн байсан ч ялгаагүй шийтгэл оногдуулдаг гэж үздэг. Мөн тэдэнд Америкт тохиолддог хуулийн гол асуудал бол согтуугаар жолоодох гэмт хэрэг байдаг. Олон хүмүүс хэлэхдээ тэдэнд Америкийн засгийн газар бараг анхаарлаа тавьдаггүй шиг тэд Америкийн улс төрийг төдийлөн сонирхдоггүй бөгөөд тэдэнд улс төрийн төлөөлөл юмуу, парламентийн гишүүдийг ухуулах ухуулга байхгүй гэдэг. Америкт байгаа зарим Монголчууд тэндхийн оршин суугч биш учраас сонгууль өгч чаддаггүй.

Нутаг нэгтнүүдийн бүлэг

Бусад Азийн орнуудын нутаг нэгтнүүдийн бүлэг Бэй гэдэг газарт олон зуун жилээр амьдарч хувийн байшин, хувийн бизнэс эрхэлдэг байхад харин эндхийн Монголчуудын нутаг нэгтний бүлэг зөвхөн 10-15 жил болж байгаа. Америкт байгаа Монголчууд тэднийг анх Америкт ирэхэд нутаг нэгтний бүлэг, хэлний чадвар, ер нь юу ч тэдэнд байгаагүй бөгөөд цөөхөн Монгол хүмүүс өөр хоорондоо харилцдаг байсан гэж тайлбарлана. Бусад Азуудад тэдний эх орноос ирсэн өөр хоорондоо нийгэмших том нутаг нэгтний бүлэг байдаг. Зөвхөн Монголчуудын нутаг нэгтний бүлэг жижиг боловч эмэгтэйчүүдийн, эмч

нарын, хөнгөн атлетикчидын гэх мэт өвөрмөц байгууллагуудтай. Мөн сургуультай бөгөөд энэ сургууль крилл цагаан толгой, монгол хэл, ёс заншил заадаг.

Бэй хэмээх энэ газрын Монголчууд үнэхээрийн хөгжилтэй, хөдөлгөөнтэй нутаг нэгтний бүлэгтэй. Монгол руу буцахаар зорьж байгаа хүмүүс ч бүлгийн үйл ажиллагаанд тэндхийн оршин суугч шиг л идэвхтэй оролцоно. Нутаг нэгтний бүлгийн хамгийн том үйл явдал бол Наадам, Цагаан сар гэх мэтийн баярыг тэмдэглэх. Мөн тэнд гэр төв байх ба жил бүрийн соёлын арга хэмжээнүүд Калифорн мужийн Рало Алто дах Станфордын Их Сургуульд байдаг гэр төвд зохиогддог. Нутаг нэгтний бүлэг сар бүр арга хэмжээ зохионо.

Гэр бүл

Эх орондоо байгаа Монголчуудыг бодвол тэд Америкт гэр бүл төлөвлөлтийг арай өөр хийнэ. Ургийн асуудал тийм ч чухал биш. Америкийн Монголчууд өөрсдийгөө Монголын Монголчуудаас илүү бие даасан бодолтой гэж тодорхойлдог.Өнөө үед Америкт хүүхдүүд аюултай буюу хүүхдээ анхаарахгүй орхивол хүүхдийн хулгайд алдах аюултай байдалд байх тул хүүхдүүдээ монголын хүүхдүүд шиг эрх чөлөөтэй байлгаж чаддаггүй. Тэд хүүхдүүдээ биеэ цэвэрхэн авч явах, ороо хураах, бусдыг, ялангуяа ахмадуудыг хүндлэхийг заахыг хичээнэ. Гэхдээ тэдний ахмадууд магадгүй тэдэнтэй хамт амьдардаггүй, Монголд байгаа. Тэд гэртээ гэр бүлийнхэнтэйгээ төрөл хэлээрээ ярьж, хүүхдүүдээ крилл үсгээр уншихыг заах ба мөн уламжлалт тоглоомоор тоглохыг зааж өгдөг. Заримдаа Монголын үнэт зүйлсийг хүүхдүүдээ сургахад тэдэнд бэрхшээлтэй байдаг. Бадамцэцэг охиныгоо “америкжсан” гэж хэлдэг. Түүний охин заримдаа “таны надтай ингэж ярихад чинь би дургүй”, “та намайг ойлгохгүй байна”, “би том болсон, надад битгий заагаад бай”, гэх мэтээр дургүйцдэг гэнэ. Тэр охиндоо түүнийг Америкын иргэн ч Америкийн Монгол хүн гэдгийг нь сануулан хэлдэг. Мөн тэр түүнд “ Чи Америкийн соёл заншлыг түргэн сурсан чинь сайн хэдий ч өөрийн зан заншлаа хадгалж, хоёр соёл заншлыг аль алиныг хадгал “ гэж захьдаг.

“Түүний оюун ухаан илүү Америк шинжтэй, түүний багш нар, найзууд нь түүнд Америк орчинг мэдрүүлдэг боловч гэртээ Монгол орчинд байдаг. Би өөрөө энд сургуульд сурч байсан туршлагагүй болохоор би тэр чигээрээ Монгол эмэгтэй. Миний бодлыг миний охин дургүйцдэг. Тэр намайг бусдаас өөр хүн, бас өөр байхыг хичээдэг гэж боддог” гэж Бадамцэцэг ярьсан юм.

Хүйсийн байдал

Монголд хүйсийн байдлын нөлөө аажмаар өөрчлөгдөж харин Америкт ихсэж байгаа гэж Америкийн Монголчууд хэлнэ. Америкт байгаа монгол эмэгтэйчүүд зарим харийн орны эмэгтэйчүүд шиг хэтэрхий чөлөөтэй ч биш, эсвэл хэт дарангуйлагдсан ч биш байхыг хүсдэг гэж Америкт байгаа нэгэн монгол залуу хэлсэн юм. Тэд монгол эмэгтэйчүүдийг соёл заншлаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ нээлттэй байхыг хүсдэг бөгөөд хосууд бие биеэ хүндэлдэг байх хэрэгтэй гэж боддог. Америкийн Монголчуудын хүйсийн ялгаа Монголын хотуудад амьдардаг хүмүүсийнхтэй төстэй гэж тэр залуу тодорхойлсон. Одоогоос хорин жилийн өмнө монгол эмэгтэйчүүд гэртээ л байна гэж сэтгэдэг байсан бол одоо ихэнх хотын эмэгтэйчүүд ажил хийдэг. Америкийн Монголчуудын ихэнх нь эрэгтэйчүүд гадаах ажлаа, эмэгтэйчүүд гэрийн доторхи ажлаа хийдэг Монголын хөдөө амьдардаггүй байсан хүмүүс юм. Америкт байгаа эрэгтэй эмэгтэй аль ч хүйсийн хүмүүс ялгаагүй гэрээсээ хол газарт мөнгө олохын төлөө ажилладаг гэнэ. Аль хүйсийн хүмүүс хэдий хэрийн мөнгө олдог нь чухал биш юм. Америкт ирээд эхний үед эрчүүд дандаа барилгын ажил, эмэгтэйчүүд зөөгч хийдэг. Эмэгтэйчүүд дээд сургуулиа төгсөөд л голдуу нягтлан бодогч болно.

Америкийн Монголчууд эмэгтэйчүүд Монголд бас Америкт хаана ч байсан боловсрол

эзэмшихийг хичээдэг ба Монголын их дээд сургуулиудын нийт оюутнуудын 80%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг гэж хэлдэг. Монгол эрэгтэйчүүдийг бодвол эмэгтэйчүүд дандаа илүү амжилтанд хүрч, илүү сайн ажилтай байдаг. Монгол эмэгтэйчүүд амьдралыг удирдан авч явах бөгөөд энэ нь эрэгтэйчүүдийг бодвол тэднийг илүү их бие даасан байдалд дууддаг гэж тэд бодно.

Америкт байгаа монгол эмэгтэйчүүд хэлэхдээ монгол эрэгтэйчүүдээ эмэгтэйчүүд илүү хүчтэй, сайн боловсрол эзэмшиж, санхүүгээ барих чадвартай болсон нэг шалтгаан нь Монголын хот суурин газруудын гэр бүлүүд охидуудаа гэрлэснийхээ дараа гэр бүлийн зохисгүй харьцаанд өртөх вий дээ гэсэн болгоомжлол юм гэдэг. Тэгээд эцэг эхчүүд охидуудаа илүү анхаарч, тэдний боловсролд анхаарал тавьдаг тул тэд илүү хүчирхэг болж, хэн нэгнээс хамаарахгүй амьдрах мэргэжил мэдлэгтэй болдог байна.

Хотын монголчууд голдуу 20 насандаа гэрлэж дараа нь салах нь элбэг. Салсаныхаа дараа эмэгтэйчүүд хүүхдийнхээ төлөө хариуцлага үүрч, илүү сайн ажил хайж, эсвэл хувийн бизнес эхлүүлэх мэтээр хичээдэг байхад эрэгтэйчүүд голдуу эцэг эхдээ өөрийгөө даатгадаг. Заримдаа ажлаасаа халагдах тохиолдолд эмэгтэйчүүд улам тууштай хатуужилтай болдог байхад эрэгтэйчүүд бууж өгөх тал бий.

Америкийн Монголчуудын дунд гэр бүлийн хүчирхийлэл өндөр үзүүлэлттэй байх ба учир нь ихэнхдээ нөхрүүд нь архичин байдаг. Тэд тайван байж ярилцаж сурах хэрэгтэй гэж Америкийн Монголчууд хэлж байв. Мөн тэд монголчууд Америкийн хуулийг ойлгодоггүй бөгөөд нөхөр нь эхнэрээ цохих, алгадах болон хүчээр бэлгийн ажил хийхийг шаардах үед тэдний хөршүүд цагдаа дуудна гэдгийг мэддэггүй гэж ярина. Америкт байгаа Монголчууд гэр бүлийн зохисгүй харьцааг гэр бүлийн асуудал гэж үздэг байхад Америкийн цагдаа өөрөөр үздэг. Цагдаа нар тэднийг шоронд хийж, хорьж шийтгэнэ (тэднийг хохирогчдын ойр байхыг хууль бус гэж үзнэ). Америкийн Монголчууд үүнийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх буруу арга гэж боддог. Гэр бүлийн зохисгүй харьцааг хуулиар шийдсэнээр хүүхдүүд эцгээсээ тусгаарлагдаж, бие биеэ санах байдлыг үүсгэнэ гэж тэд харамсдаг. Дүүргийн хуулийн ажилтанд (гэмт хэрэгтэй тэмцэхэд тусалдаг засгийн газрын ажилтан) нэг удаа л гомдол санал бүртгэгдсэн бол тухайн гэр бүл хуулийн оролцооноос “аврагдаж” чадахгүй.

Баяр ёслолууд

Америкийн Монголчууд Окландын Бэй хэмээх газарт байдаг Монголчуудын нутаг нэгтний бүлэг зэрэг байгууллагуудын туслалцаатайгаар Монголын баяр ёслолуудыг тэмдэглэдэг. Тэд нутаг нэгтний орон нутгийн төвд ахмадуудаа хүндэт зочноор урьж, эсвэл гэрт нь очиж Цагаан сарыг тэмдэглэнэ. Ахмадуудаа золгож, цай, мах, буузаар дайлна. Энэ үеэр тэд үдэшлэг зохиож, зурагт үзэж, монгол дуугаа дуулж, нэг нэгэндээ бэлэг өгнө. Ээж аавууд нь Монголд байгаа хүмүүст Цагаан сар хэцүү санагддаг. Тиймээс тэд эх орондоо байгаа эцэг эх рүүгээ утсаар ярьж, ээжүүдээ цэцэг илгээх ба эцэг эх нь тэнд байгаа найзуудынхаа гэрт зочилно.

Америкийн Монголчууд Цагаан сар ба Хятадын шинэ жил Монголд болон Хятадад дандаа ижил өдөр таардаггүй, яагаад гэвэл Монголчууд Буддын шарын шашны шинэ жилийг, харин Хятадууд Буддын улааны шашны шинэ жилийн хуанлийг дагадаг гэж тайлбарлана.

Жил бүрийн 7 сард “ Алтан хаалга” цэцэрлэгт хүрээлэнд эрийн гурван наадам болох морь уралдах, сур харвах, бөх барилдах тэмцээн зохиож наадам тэмдэглэдэг.

6 сарын 1-нд Эх Үрсийн баяр тэмдэглэнэ. Социалист нийгмийн үед Олон улсын Эмэгтэйчүүдийн баярыг 3 сарын 8-нд тэмдэглэдэг байсан бөгөөд 1990 оноос хойш 6 сард тэмдэглэх болжээ.

Даваадулам найзуудын хамт Оклендад анх удаа Олон улсын Хүүхдийн баяр тэмдэглэхэд тусалсан гэнэ. Тэд цэцэрлэгт хүрээлэнд гүйлтийн болон дууны тэмцээн хүүхдүүдийн дунд зохиож, бүх зочиддоо зориулан хоол хийжээ. Баяр ёслолыг зохион байгуулах нь нутаг нэгтний бүлгийн эв нэгдлийг сайжруулдаг гэж тэр боддог.

Шашин

Бэй гэдэг газрын Монголчууд шашин шүтлэгээр ялгаатай. Тэдний тал орчим хувь нь цагаачилж ирэхдээ Христийн шашинтан байсан эсвэл Америкт ирсэний дараа энэ шашныг шүтэх болсон. Тэдний олонх нь Америкийн Солонгосчуудтай нэг сүмд явна. Нөгөө хагас нь Буддын шашин шүтэх ба шашны төв, сүм дуган, хийдийн үйл ажиллагаа явуулдаг Оклендын Буддын хүрээлэнд очиж мөргөж залбирдаг. Тэдний сүсэг бишрэл Далай ламын айлчлалыг хүлээж авахад хангалттай байсан байна. Америкийн Монголчуудын хүн ам нэмэгдэхийн хэрээр мөн Монголын Мусалман шашинтан үүсч байгаа гэнэ. Америкийн Монголчуудын ихэнх нь бусад нутаг нэгтнүүдийн адил шашин шүтдэггүй буюу шашны хувьд “чөлөөтэй”. Эдгээр Америкийн Монголчууд сүсэг бишрэлд итгэдэггүй бөгөөд үндсэн асуудал болох Америкийн шашны эрх чөлөөг үнэлдэг.

Хүрээлэн буй орчин

Хүрээлэн буй орчны хамгаалал

Америкийн Монголчууд тэдний эх орон нэгтнүүд шигээ хүрээлэн буй орчноо хүндэлдэг. Тэд Калифорны сайхан ногоон байгалийг бахдан биширч, тэндхийн оршин суугчид байгалийн нөөц баялгыг байнга хүртэж байдаг гэж бодно. Дэлхийн дулаарал бол Америкийн Монголчуудын анхаарал татсан зүйл. Тэд үүнийг Сан-Францискогийн хүйтэн, Лос Анжелосын их бороо, Хайти дах газар хөдлөлт, Европын их цас, Монголын 2009-2010 оны өвлийн зуд гэх мэт ер бусын цаг агаар ба байгалийн гоц үзэгдэл гэж ойлгодог.

“Хүмүүсийг газар дэлхийгээ хайрлахгүй байгааг би хараад гудамжинд хэнэггүй алхаж яваад хүүхэд гомдоож байгаа хүмүүсийг харж байгаа юм шиг санагддаг. Хүмүүс газар ухааж, газрын баялгаа мөнгөнөөс өгч байгааг харахад нярай хүүхдийг хөнөөж байгаа мэт харагддаг. Хүмүүс яагаад ийм зүйл хийдэг байнаа?. Би дайны эсрэг байдаг. Хүмүүс яагаад тайван амгалан ярилцаж чаддаггүй байнаа? Одоо газар дэлхий хүмүүст уурлаж, даяарчлалаас шалтгаалан хүрээлэн буй орчноо хөнөөж байгаад хариу ял тулгаж байна” гэж Бадамцэцэг ярьсан юм.

Америкийн Монголчууд хөдөөний монголчууд зуд болсноос засгийн газарт уурлаж байгаа боловч байгалдаа уурлаагүй, байгал өөрийгөө хамгаалж байгааг нотолсон гэж хэлдэг. Бүх амьдралынхаа туршид байгалдаа амьдарсан, байгалийн гамшгаас зовж зүдэрдэг, зуд болоход нөлөөлөх засгийн газрын шийдвэрүүдийн эсрэг тэмцэхийг хүсч байгаа ч үүнийг хийхэд хүч хүрэхгүй байгаа нүүдэлчин малчдыг Америкийн Монголчууд өрөвддөг. Мөн тэд дэлхийн дулаарлаас болж зовон шаналж байгаа Монголын хөдөөгийн хүн амыг аюулаас аврахын тулд АНУ болон бусад үйлдвэржсэн хүчирхэг орнууд хандлагаа өөрчлөх хэрэгтэй гэж боддог.

Уул уурхайн олборлолт

Америкийн Монголчууд уул уурхайн олборлолтын талаар нэгдсэн үзэл бодолтой. Өмнөд Африкийн уул уурхайн түүх бол газрын баялаг ихтэй байсан орон уул уурхайн олборлолтыг замбараагүй хийснээс баялаг нь дууссан тухай анхааруулах домог болсон түүх гэж тэд үздэг. Үүний эсрэгээр, Саудын Арабын уул уурхайн олборлолт илүү сайн загвар болно гэж боддог. Сайн хамтрагч нар ашигтай олборлолтын үйлдвэрлэлийн

түлхүүр болно гэж тэд хэлнэ. Монгол орон хоёр том орнуудтай зэрэгцэн орших тул Орос, Хятад улстай биш, харин АНУ, Герман, бусад Европын холбооны улсууд, эсвэл Япон, Солонгос зэрэг орнуудтай хамтран ажиллах боломжуудыг хайх нь зүйтэй гэж тэд боддог гэнэ. Мөн тэд Монголчууд уул уурхайн хамтын ажиллагаа хийхдээ технологийн хөгжил өндөр, бас интернэтийн сүлжээтэй орнуудыг сонгох бодлого барих хэрэгтэй хэмээн үздэг.

Зарим Монголчууд уул уурхайн олборлолтыг ашигтай гэж үзэж байхад зарим хүмүүс буруу ашиглавал хүрээлэн буй орчноо сүйтгэнэ гэж анхааруулдаг. Одоогоор маш олон хүмүүс газрын баялгаас ашиг олохыг хүсэх ба уул уурхайн компаниудад гишүүнээр элсээгүй эдгээр хувь хүмүүс байгалд хортой аргаар хувиараа байнга олборлодог. Америкийн Монголчууд буруу аргаар олборлолт хийх нь амьдралаа алдах, голуудыг хатаж ширгэхэд хүргэнэ гэж анхааруулж байна. Зарим Америкийн Монголчууд уул уурхайн үйлдвэрлэлийг гамшиг хэмээн үзэх ба байгал орчныг нөхөн сэргээх илүү олон ажлуудыг хийхийг шавдуулдаг.

Боловсрол

Америкийн Монголчууд боловсролыг их үнэлдэг. Тэд Америк оронд боловсрол эзэмшсэн Монголчууд эх орондоо шинэ технологи, мэдлэг авчирдаг гэж итгэнэ. Америкийн Монголчууд хүүхдүүдийн ирээдүйг нь амжилттай байлгахад туслах Англи хэлний сайн чадварыг тэдэнд эзэмшүүлэхийг хүсдэг. Тэд Америк болон Монголын боловсролын системд ялгаа бий гэж үзнэ. Монголд бүх шатны сургуулиуд Орос орны боловсролд суурилсан байх ба хүүхдүүдэд хэтэрхий их гэрийн даалгавар өгдөг. Америкт багш нар хүүхдүүдэд их зөөлөн хандах бөгөөд хүүхдүүд багш нарын зүгээс дарамт шахалт үзэхгүйгээр өөрсдийгөө нээж олдог гэж зарим Америкийн Монголчууд хэлдэг. Америк багш нар хүүхдүүдийг мэргэших, тодорхой салбарт амжилт гаргахыг нь чиглүүлж өгөхийн тулд хүүхэд тус бүрд ойр ажиллаж тусалдаг. Монголд бүх оюутан сурагчид сонирхолынхоо дагуу ижилхэн боловсрол олж авдаг. Америкийн Монголчууд хүүхдүүд энд бүх хичээлийг үзэж судлахын оронд сурахыг хүссэн хичээлээ өөрөө сонгож, хүсэхгүй байгаа хичээлд суухгүй байж болдог тул тодорхой чиглэлээр сурах боломжинд их баяртай байдаг.

Мөн тэд хэлэхдээ Америкийн сургуулиуд хүүхдүүдэд яаж сайн иргэн, сайн найз нөхөр болох, өөртөө үнэнч байхыг заадагт дуртай байдаг гэнэ. Америкт шинжлэх ухааны хичээл болох математик, физикийн хичээлийг, мөн хэлний хичээл Латин хэлийг эхнээс нь бага багаар заадаг бол Монголд эдгээр хичээлүүдийг илүү хүнд аргаар заадаг. Заримдаа тэдний хүүхдүүд зарим зүйлийг бага насандаа сурсанаас том болсон хойноо илүү сайн сурдаг ба зарим тохиолдолд эсрэгээрээ байдаг гэж үзнэ. Жишээлбэл, зарим эцэг эхчүүд хүүхдүүдээ бодвол анатоми, нарны систем, суурь математикийг эрт судалсан гэдэг.

Америкийн Монголчууд хүүхдүүд Америкт цагаачилж ирээд 2-3 жилийн дотор Англи хэлийг түргэн сураад тэгээд дараа нь сурлагаар шилдэг хүүхэд болж эхэлдэг гэж ярина. Ихэнх Америкийн Монголчууд гэртээ эх хэлээрээ ярих хэдий ч тэдний хүүхдүүд хоёр хэлээр чөлөөтэй ярьдаг болдог гэнэ. Тэд хүүхдүүдээ Америкт өдөр бүр Англи хэлийг сурна гэдгийг мэдэх бөгөөд тэднээс өөр хэн ч тэдний хүүхдүүдэд Монгол хэл заахгүй тул тэд хүүхдүүдээ Англи хэл биш, Монгол хэл заахыг хичээдэг.

Эрүүл мэнд ба анагаах ухаан

Америкийн Монголчууд эрүүлийг хамгаалахын олон төрлийг ашиглана. Заримдаа хүмүүс уламжлалт анагаах аргыг хэрэглэх хэдий ч ихэнх нь Барууны анагаахыг хэрэглэдэг. Тэнд олон сайн монгол эмч нар байх ба тэд өөрсөддөө болон эмч болох гэж байгаа монголчууддаа зориулан тусгай байгууллага байгуулжээ. Монгол эмч нар байгааг үл харгалзан зарим хүмүүс Монгол эмчилгээг хэрэглэдэггүй. Яагаад гэвэл Монгол эмийн жор

эмчилгээний дуусах хугацааг голдуу заадаггүй, мөн үүнийг Америкаас олж авахад хэцүү байдаг гэнэ. Монголын анагаах ухаанд Оросын анагаах ухаан нөлөөлсөн байдаг учир зарим хүмүүс Оросын эм тариаг хэрэглэх бөгөөд Сан-Францискод байх Оросын эмийн санд очиж үйлчлүүлдэг. Бусад Америкийн Монголчууд Хятадын анагаах ухааныг эрхэмлэнэ.

Монголд эрэгтэйчүүд тамхи татаж архи уух нь эрүүл мэндэд сайн биш ч, зайлсхийхээр тийм ч муу зүйл биш гэж дандаа боддог. Хэрвээ тэд хааяа ч гэсэн тамхи татах болон архийг хэтрүүлэн уух нь үхэлд хүргэдэг гэдгийг мэддэг хэрнээ хүн бүхэн ямар нэг зүйлээс болж үхдэг гэж хэлэн өөрсдийн буруу зуршлыг зөвтгөдөг. Америкт монгол эрэгтэйчүүд архи тамхинаас дандаа гарах бөгөөд тэдний байнга хардаг “энгийн Америк амьдрал”-ыг хүсдэг.

Аялал жуулчлал

Монголын аялал жуулчлалын хөгжлийг Америкийн Монголчууд дэмждэг. Тэд жуулчдын сонирхолыг татах зүйлсийг тэдний хөндөгдөөгүй газар нутаг, Оросын нөлөөт “орчин үе” ба уламжлалт амьдрал хосолсон соёл ёс заншил, өвөрмөц сайхан монгол гэр, хөдөөгийн амьдралын хэв маяг гэж нэрлэнэ. Хүмүүс Монголд аялахыг, ялангуяа Говьд очихыг хүсдэгийг тэд ажигладаг боловч Монголын цаг агаар, хүйтэн өвөлд аялал жуулчлал хөгжүүлэхэд хэцүү гэдгийг мэддэг. Монголын цаг агаар жуулчлалын улирлыг зөвхөн гурван сар болгож хязгаарлана. Аялал жуулчлалын хөгжил улс орны зам тээврийн салбарын хөгжил муу байгаагаас шалтгаалж буурдаг. Түүнчлэн, жуулчлалын хөгжлөөр мөнгө олох нь Монголчуудад хэцүү гэж тэд үзнэ.

Ганзүрхийн найзууд Монголын засгийн газар болон аялал жуулчлалын салбарт ажиллах ба тэд Америкт түүнийг Монгол руу хийх аялалыг дэмжихийг гуйсан боловч энэ гуйлтыг биелүүлэхэд бэрхшээлтэй байсан гэнэ.

Одоогоор Япон, Солонгос, Хятад, Франц, Германы жуулчид Монгол руу аялдаг. Америкийн Монголчууд Монголд Америкийн аялал жуулчлал ихсэнэ гэж боддог бөгөөд илүү олон Америкчууд Монгол руу аялахыг хүснэ. Үүний тулд энэ хоёр орон өөр хоорондоо түншлэх хэрэгтэй. Монгол руу хийх аялал үнэтэй тул Америкчууд татгалздаг. Монгол орон хол оршдог, Америкчууд Монголыг үл ойшоох хандлагатай байдаг ба зарим хүмүүс Монголыг аюултай орон гэж боддог. Америкчууд Хятад руу эсвэл Орос руу аялах амархан гэж үзэх ба дараа нь эдгээр орнуудаас Монгол руу нисэж ирдэг. Зарим Америкийн Монголчууд бидний эх оронд Америкчуудын үзэх зүйл бага гэж бодох хэдий ч монгол гэрүүд, бурханы хөрөг мэт хөдөөний амьдралын хэв маяг ба Америкийн баруун өмнөдийн кабой нар шиг анхаарал татмаар, үзүүштэй зүйлсийг эргэцүүлэн бодно. Ийм шалтгааны улмаас Америкийн Монголчууд эко-жуулчлалын (байгал орчныг аль болох сүйтгэхгүйгээр Монголын хөдөөгийн соёл ёс заншлын сайхныг үзүүлж таниулах аялал жуулчлал) илүү олон төвүүдийн хөгжлийг харахыг хүсдэг. Мөн тэд хөдөөний хүмүүс аялал жуулчлалд хамтран оролцохыг харахыг хүсдэг гэнэ.

Олон Америкийн Монголчуудын төрөлх эх орныхоо аялал жуулчлал өргөжихийг хүсэж буй нэг шалтгаан бол гадаадынхан Монголын тухай илүү мэдлэг олж авахыг хүсдэг. Гадаад хүмүүс тэдний эх орны тухай мэдлэгээ сайн нэмэгдүүлэх эсвэл зүгээр л ерөнхий мэдлэг олж авах аль нь ч байсан тэдэнд тустай хэмээн итгэнэ. Тэд гадаадынхан цөөхөн хүн амтай орон хэрхэн оршин тогтнож чаддагыг харж суралцахыг хүсэх ба Монголчууд яаж тайван амгалан амьдардагыг дэлхийд харуулах боломжид талархана.

Өөрчлөлт

Уламжлал ёс заншлын өөрчлөлт

Америкийн Монголчуудын хувьд тэдний Америк оронд хийх аялалын туршид уламжлал,

ёс заншилд хандах Монголчуудын уламжлал, хүмүүсийн харилцаа холбоо өөрчлөгдсөн. Өөр ёс заншилтай үндэстэнүүд Америкт хамтдаа холилдон амьдрах зүйрлэлийг үл харгалзан “Монголчууд холимог тогоонд холилддоггүй” гэж Америкийн Монголчууд онцлон хэлдэг. Тэд тэндэхийн бусад Монголчуудтай ойр дотно байж, өвөрмөц соёл заншлаа хадгалж, бусад гадаадынхантай харьцах харьцаагаа хязгаарлана.

Америкт тэд соёл заншлаа өөрчилдөг. Жишээлбэл, зарим Америкийн Монголчууд шинэ жил болоход өөрсдийгөө нэг нас нэмлээ гэж бодох хэрнээ төрсөн өдөр хүрглээ тэд нэг насаар илүү гэж бусад гадаадынханд хэлдэггүй. Өдөр бүр цайны дээжээ өргөхийн оронд Цагаан сар зэрэг өвөрмөц өдрүүдэд л өргөнө. Чикагод амьдардаг Монгол гэр бүл өдөр бүр цайны дээж өргөдөг байтал тааз нь нэг өдөр нураад унажээ гэсэн Америкийн Монголчуудын нэг онигоо байдаг гэнэ. Америкийн ихэнх таазнууд үргэлж норгоод байвал үйрч унах даавуун чулуугаар хийгдсэн байдаг тул ийм онигоо гарчээ. Америкт цайны дээжийг нөхрүүд биш, голдуу эхнэрүүд өргөнө. Тэд уламжлал дээрээ нэг зүйл нэмсэн нь цайны дээжийг Монголын зүг рүү өргөдөг болжээ.

(цайны дээжийг шанаганд аваад агаарт цацна) Зарим Америкийн Монголчууд хэн нэгэн зөвшөөрөхгүй байсан ч хамаагүй Христийн сүмд гэрлэх ёслолоо хийдэг. Бусад Америкийн Монголчууд уламжлалт монгол гэрлэх ёслолыг Америкт сэргээхийг хичээж тэдний хуриманд байлцах эцэг эхийгээ нисч ирэхийг урина. Заримдаа бэр, хүргэний аль нэг нь үндэсний дээл хувцастайгаа Монголоос нисч ирэх, эсвэл үндэсний хувцасыг худалдаж авна, эсвэл байгаа газраа оёулна. Тэд хааяа томоохон хуримын ёслол хийдэг. Хосууд гэрлэлтийн гэрчилгээг дандаа Монголын Элчин сайдын яамнаас авах бөгөөд тэд өөр үндэстэнтэй гэрлээгүй бол гэртээ жижигхэн хурим хийдэг. Америкийн Монголчууд өөр үндэстэнтэй гэрлэх тохиолдол их байна.

Цагаачилж ирэхээс өмнө уламжлал ёс заншилдаа хандах тэдний харилцааг социализм сулруулсан болохоор Монгол ёс заншил, уламжлалаа Америкт үргэлжлүүлэх тэдний чадвар буурсан хэмээн зарим Америкийн Монголчууд ярьдаг. “Би бол бараг л Америкийн Орос хүн. Би үүгээр бахархдаггүй. Би Монголын уламжлалыг үргэлжлүүлэхийг хүсдэг ч бидний соёл заншилд хандах хандлага маань тийм ч сайн биш” гэж Бадамцэцэг ярьсан юм.

Хоолны дэглэм

Зарим Монголчууд Америкт ирээд хоолны дэглэмээ өөрчилдөг. Зарим нь тэдний хоолны дэглэм бараг өөрчлөгдөөгүй гэнэ. Саяхан ирсэн монголчууд хэлэхдээ тэдний бие махбод Монголын хоолны дэглэмд дасан зохицсон байдаг учир тэд хоолны зуршилаа сайн өөрчилж чадаагүй байгаа гэдэг. Мөн зарим хүмүүс тэд Орос оронтой ойр харилцаатай байдаг учир тэр орны хоолны дэглэмийг сахьдаг байсан болохоор Америкт ирсэнийхээ дараа хоолны дэглэмээ бага зэрэг өөрчилсөн гэж хэлдэг. Тэдний хоолны дэглэм аль хэзээний Америкийн дэглэмтэй төстэй бөгөөд тэдний хоол тэжээлийн байдал Азийнханаас илүү Европынхонтой адил гэж бодно. Яагаад гэвэл монголын цаг агаараас шалтгаалж цөөн төрлийн хүнсний ногоо, жимс ургах бөгөөд Хятадаас олон төрлийн хүнсний зүйлсийг импортоор оруулдаг. Ийм шалтгаанаар, зарим Америкийн Монголчууд тэдний хооллох дэглэм Америкт илүү сайн байгаа ба тэд хүнсний ногоо, жимс элбэг тул илүү эрүүл хооллох боломжтой Барууны хоолны дэглэмийг илүүд үздэг хэмээн ярина.Тэд тэнд удах тусмаа хоолны зуршлаа өөрчилдөг гэж ярьдаг.

Америкт хүмүүс их хэмжээний мах идэх шаардлагагүй байдаг бол хүмүүс Монголд хүйтэн цаг ууртай газар амьдардаг учир хонины мах, бусад төрлийн мах, өөх тос идэх хэрэгтэй. Монголчууд биеийн хүчний ажил их хийх тул их мах, өөх тос хэрэглэх ба харин Америкийн Монголчууд эх орондоо байхдаа иддэг шиг Америкт идвэл биеийн хүчний ажил бага хийдэг болохоор таргалж жин нэмнэ гэж боддог.

Ирээдүй

Америкийн Монголчууд Бэй хэмээх газрын монголчууддаа болон Монгол орны ирээдүйд өндөр итгэл тавьдаг. Тэдний зарим нь сайн боловсрол эзэмшсэн Америкийн Монгол хүн АНУ-ын сенатын гишүүн болох ирээдүйтэй гэж итгэнэ. Мөн монголын залуу үеийнхэн өндөр боловсролтой болохыг тэд хүснэ. Одоогийн Америкийн Монгол эцэг эхчүүд үр хүүхдүүддээ бүхнээ зориулж, ямар нэгэн бизнес эхлэхгүй, эсвэл өөрсдийн боловсролыг анхаарахаас илүүтэйгээр тэдэнд хуримтлал үүсгэдэг. Тиймээс тэд энэ хүч чармайлтаа хүүхдүүдийнхээ ирээдүйд зориулж чаддаг. Түүнчлэн, тэдний үр хүүхэд эцэг эхийнхээ хийснээс илүү ихийг өөрсдийн амьдралдаа хийж бүтээнэ гэж тэд найдна.

Америкийн Монголчуудаас хэн нэгэн АНУ-ын хуулийг судалж, орчуулагч эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч болоод тэдний ойлгож чадахгүй хуулийн асуудал гарах үед шүүхэд өөсдийгөө хамгаалж чадна гэдгээ ухамсарлахад туслах, мөн цаашлаад хуулийг дагаж мөрддөг болохыг хүсдэг. Тэд мөн нутаг нэгтний бүлгийн бүх гишүүд Англи хэлийг сайн эзэмшиж, сайн ажиллаж, үргэлж нээлттэй сэтгэж байхыг хүснэ. Америкийн Монголчууд улам хүчтэй болж, ингэснээр тэд эх орондоо зөвхөн эдийн засаг, технологийн хувьд туслаад зогсохгүй, эзэмшсэн боловсролоороо ард түмнийг илүү сайн амьдралтай болгохыг итгэж найддаг. Олон Америкийн Монголчууд бусдыгаа Америк оронд байхдаа уламжлал соёлоо амьд хэвээр үргэлжлүүлж, дараа нь эх орондоо очоод нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулна хэмээн итгэнэ.

Тэдний эх орон хоёр том гүрний дунд байрлах жижиг орон учир амархан уусаж алга болох вий гэж Америкийн Монголчууд анхааруулж байна. Хятад улс дэлхийн том үйлдвэрлэгч орон бөгөөд Орос улс дэлхийг газрын тосоор хангадаг байхад бидний Монгол цөөхүүлээ дунд нь оршдог. Зарим Америкийн Монголчууд Монголын жижиг бизнесүүдийг дэмжихийн тулд Монгол орон худалдааны хориг тавьж, татвар авдаг болохыг хүснэ. Жишээлбэл, Аргентины хямдхан, зөөлхөн үхрийн махны үйлдвэрлэл Монголын үхрийн махны үйлдвэрлэлийг хялбархан сүйтгэж чадна гэж тэд болгоомжилдог. Мөн тэд хэлэхдээ Монголыг Хойд Солонгос шиг бүр тусгаарлахгүйгээр илүү олон улсын болон нээлттэй бодлого барихыг хүснэ. Зарим хүмүүс даяарчлал Монголчуудад сайн нөлөөтэй гэж үздэг.

Монголчууд олон зүйл үйлдвэрлэдэггүй бөгөөд нэлээд зүйлсийг импортоор авдаг учраас өвөрмөц эдийн засагтай орон. Гадаад орнууд руу зэс, алт, нүүрс, ноолуур, малын арьс шир экспортод гаргах бөгөөд Америкийн Монголчууд гадны хөрөнгө оруулагчидын сонирхолыг Монгол орон татаж чаддаггүй гэж боддог. Тэд одоо байгаа цалин 100 ам.долларыг 300 болгох ёстой гэж үзнэ.

Монгол орон илүү олон улсын анхаарлыг татахыг оролдож байгаа бөгөөд урьд өмнөхөөс илүү боломж бололцоонууд гарч байгаа гэж Америкийн Монголчууд боддог. Мөн тэд Монголын удирдлагууд анагаах ухаан, боловсролын салбар, нийслэлийн хүн ам, усны чанарт анхаарал тавьж эхэлж байгаа хэмээн итгэдэг.

Төгсгөлийн үг

Тувачууд, Дархадчууд, Америкийн Монголчууд бүгд хувирамтгай соёл ёс заншилтай бөгөөд баг бөх, гайхалтай сайхан цэцэн ухаантай ард түмэн юм. Та бүхэн энэ номонд байгаа мэдээллүүдийг уншиж гялалзсан сайхан ирээдүйг бүтээнэ гэдэгт зохиогч би эргэлзэхгүй байна.

Үгсийн тайлбар

Африк-Европ болон Европ тивийн дунд зүүн доогуур орших тив
Америкийн Африкчууд- үе удам дамжсан болон өөрөө Африкаас гаралтай
Америкийн хар арьст иргэн
Араб хүн-Азийн баруун урд байх Араб улсаас гаралтай хүн
Австрали-арал тив
Бээжин-Хятадын нийслэл хот
Камбужи хүн-Азийн зүүн өмнөдийн Камбужи улсаас ирсэн хүн
Канад-Хойд Америк тивийн АНУ-ын хойд хэсэгт байдаг орон
Кабой-үхэр хариулдаг хүн
Дээл-Монгол үндэстэний хувцас
Европ-Ази тивийн баруун талд байдаг тив
Франц-Европт байдаг орон
Гэр-модоор хийж, хонины эсгийгээр бүтээдэг үндэсний сууц
Герман-Европт байдаг орон
Дэлхийн дулаарал-дэлхийн цаг агаар хортойгоор удаан хугацааны туршид нэмэгдэх үзэгдэл
Говь-Ази тивд байдаг элсэн цөл, Азийн ихэнх элсэн цөл Монголд байдаг
График дизайн-зар сурталчилгаа, бизнесийн болон бусад чиглэлээр загвар гарган ажилладаг салбар
Хятадын Цагаан хэрэм-Хятадуудыг нүүдэлчидээс хамгаалахын тулд МЭӨ 3-р зуунд баригдсан 1 мянган километрийн урттай хана
Хайти-АНУ-ын ойр байдаг арал улс
Химба-Африкийн уугуул иргэд
Итали хүн-Европ тивийн Итали орны хүн
Латин хүн-Европ тивд байдаг Испаниас гаралтай хүн буюу Хойд болон Өмнөд Америкийн дунд байдаг орон
Япон-Зүүн Азийн орон
Казакстан-Монголтой хил залгадаг орон
Солонгос-Зүүн Азийн орон
Магистерийн зэрэг-Америкт дээд сургууль төгссөний дараа суралцаж, хамгаалдаг эрдмийн зэрэг
Москва-Оросын нийслэл хот
Хойд Солонгос-Зүүн Азийн орон
Овоо-чулуугаар овоолж нарийн мод оролцуулан хийгээд хадаг уясан шүтээн
Пакистан-зүүн дундад орших орон
PhD-Магистерийн зэрэг хамгаалсаны дараа суралцаж, хамгаалдаг эрдмийн зэрэг
Самичууд-Европын уугуул иргэд
Саудын Араб-зүүн дундад орших орон
Сингапур-Өмнөд Азийн орон
Өмнөд Африк-Африк тивийн орон
Токио-Япон улсын нийслэл
Үзбэкстан-Төв Азийн орон
Вашингтон Д.С-АНУ-ын нийслэл хот, муж биш
Улаанбаатар-Монгол улсын нийслэл
Улаан-Уул-Монголын Хөвсгөл аймгийн сум

Социализмын үе, социализмаас ардчилалд шилжих шилжилтийн үе, ардчиллын үеийн бэлчээр болон мал маллагааны тухай бодол эргэцүүлэл

Талархал

Энэхүү ажлыг хийх бололцоо олгосон Дартмаутын коллежын Ломбардын нийгэмлэгийн хөтөлбөр болон Дагэртын санд баярлалаа. Мөн миний цуглуулсан энэ бүх гайхамшигт аман яриануудыг олох, орчуулахад тусалсан хөтөч, орчуулагч Соёлоод баярласанаа хэлмээр байна.

Бүхнээс илүүтэйгээр Дархадын хотгорын бэлчээрийн мал маллагааны түүхийг ойлгох, ирээдүйдээ зөв шийдвэр гаргахад надтай хамтран ажилласан нутгийн иргэддээ талархал илэрхийлье.¹⁹

Өмнөх үг

Баянхангай бол Дархадын хотгорын 23 айлын нөхөрлөл юм. 2010 оны зун би социалист нийгмийн үед малчин байсан бөгөөд социализм, шилжилтийн үе, ардчиллын энэ бүх 3 үеүүдэд мал маллаж байсан гэр бүлүүдийн гишүүдтэй ярилцлага хийсэн билээ.

Энэ ажлын зорилго нь социалист нийгмийн үеийн бэлчээрийн мал маллагааны арга ажиллагаа өнөөдрийг хүртэл хэрхэн өөрчлөгдөж ирсэнийг жишээгээр үзүүлэх, малчдад энэ өөрчлөлтүүдийг ойлгоход нь туслах, түүнчлэн бэлчээрийг зөв зохистой ашиглах чадвартай болгоход оршино.

Үүнийг уншихдаа миний цуглуулсан эдгээр түүх ярианууд бусад бүх аман түүхүүдийн адилаар зарим зүйлүүд нь бодит бус байх ба орчуулгын явцад зарим утга санаа алдагдсан байж болохыг санах нь чухал юм. Гэхдээ энэ төсөлд оролцсон малчид хамгийн үнэн зөв мэдээлэл өгөхийг эрмэлзэж, би чадлынхаа хэрээр зөв бодитой бичиж тэмдэглэж, эмхэтгэхийг зорилоо.

Мөн жижиг нөхөрлөл хэдий ч дадлага, туршлага, дурсамж, үзэл бодлууд нь цаг хугацааны олон үед хамааралтай болохыг ойлгох буйзаа.

Оролцсон хүмүүс²⁰

Оролцсон хүмүүсийн нэрс, тэдний нас, мөн энэ дарааллаар ярилцлага өгсөн болно. Нэр нь хамт бичигдсэн хүмүүс гэр бүл, эсвэл ярилцлагыг хамтдаа өгсөн юм.

Гомбосүрэн 50 настай, Даваажав 45 настай

¹⁹ Энэ бүтээлийг аргачлал болгон хэрэглэснээс гарч болох ямар нэгэн үр дагаврыг зохиогч хариуцахгүй болно.

²⁰ Эдгээр мэдээллийг хувь хүн тус бүрээс биш, бүлэг хүмүүсээс сэдэвчилж авсан. Энд оролцсон хүмүүс өгсөн мэдээдэлтэйгээ холбоотой болно.

Балбар 41 настай, Гэрлээ 41 настай
Мөнхбат 70 настай
Эрхэмбаяр 51 настай
Даваажав 63 настай, Молоожой 62 настай. Оюунтуяа 30 настай²¹
Нямрэнчин 42 настай

Социалист төлөвлөгөө

Социалист нийгмийн үед бэлчээрийн мал аж ахуйд ба ааруул, цагаан идээ авах сар бүрийн төлөвлөгөө нормыг төр засгаас боловсруулан гаргадаг байсан бөгөөд малчид энэ төлөвлөгөөг биелүүлж цалин авдаг байв.

Мал сүрэг төрийн өмч байсан. Малчдаар мал маллуулж, сүү саалгаад цалинжуулдаг байсан ба эр ямааны оронд голдуу эм ямаа, ишиг малладаг байсан байна. Хэдэн толгой мал хариулсанаас цалингийн хэмжээ хамаарна.

Жишээлбэл 450 толгой хонь хариулбал 120 төгрөгийн цалин авах мэт. (үүнийг бичиж байх үед 1400 төгрөг 1 ам.доллартай тэнцэж байв)

Малчид мал маллаад цалин авдаг байсан бөгөөд хамгийн өндөр цалингийн хэмжээ 200 төгрөг байжээ.

Удирдлага

Тэр үед цөөн эрх мэдэлтэй удирдагчид ард түмнийг удирдан жолоодож байсан ба хүмүүс ерөнхийдөө бие даасан байдлаар дутмаг байсан нь тухайн үеийн онцлог юм. Гэхдээ ёс суртахууны боловсрол болох зарчмууд хэмээн нэрлэгддэг сайн хөдөлмөрлөх, аюулгүй орчинд амьдрах, дадлага туршлага эзэмших зэргээр нийт хүн амд сайн нөлөөтэй зүйлүүд олон байсан.

Нэмж хэлэхэд малын хоргодол багатай ажилласан малчид багийн даргаар сонгогдож ажлаа сайн хийвэл энэ албан тушаалдаа үлдэж, буруу шийдвэр гаргах хүртлээ ажилладаг байв. Багийн дарга нар малчдаа сайн удирдвал малчид тэднийг удаан хугацаагаар ажиллуулдаг байжээ.

Малын хэмжээ

Социализмын үед малчид цөөхөн малтай байсан бөгөөд голдуу хонь, ямаа, үхэртэй байсан. Гэсэн ч малчид малаа өсгөхийг их хүсдэг байсан ба (малын тоо толгойг бүрэн байлгахын тулд малыг өсгөх) малчин айл улсаас 100 толгой мал хариулахаар авсан бол дараа жилд 150 толгой болгох үүрэгтэй байсан. Иймээс тэд хэдий олон хүүхэдтэй байсан ч хүнсэндээ зориулж олон мал гаргадаггүй байсан. (малчид малыг хүнсэндээ хэрэглэх эрхтэй байсан)

Бэлчээр

Социализмын үед мал эрчимтэй өссөн. Яагаад гэвэл малыг бүтэн өдрийн туршид бэлчээрлүүлэн хариулж, хонь ямааг шөнө хашихгүйгээр чөлөөтэй бэлчээдэг байжээ. Өргөн уудам бэлчээрт бэлчээхэд мал төрөлх чанараараа сайн таргалдаг. Бэлчээрийн газрыг улирлын чанартай нөхөн сэргээхийн тулд малчид бэлчээрийн байрлалуудыг байнга сольж, зуны улиралд 4 удаа нүүх эсвэл ойр болон холын шинэ бэлчээр лүү барагцаагаар хоёр долоо хоног бүр нүүдэг байжээ.

Мөн газар нутаг бэлчээрээ хамгаалахын тулд нэг газар зөвхөн хоёр эсвэл гурван айл малаа бэлчээдэг. Малчид бэлчээрийн газартаа зам мөр гаргахдаа болгоомжтой ханддаг

²¹ Оюунтуяа социализм задрах үед хүүхэд байсан хэдий ч үнэтэй мэдээлэл өгсөн Социалист нийгмийн үе

ба шинэ бэлчээрт нүүхдээ хуучин замаар явж ингэснээр тэр газарт шинэ зам гаргаж бэлчээрийг сүйтгэхгүй байдаг.

Ингэж бэлчээрийг хайрласнаар малчид жил бүр 20 тонн хадлан авах боломжтой болдог байсан.

Отор

Отор бол хавар болон наймдугаар сарын сүүлээр өвс хамгийн өндөр байх үед хийдэг мал бэлчээх нэг арга юм. Энэ үед нь малыг саадаггүй учраас мал сайн бэлчиж өвлийг давах тарга тэвээрэг авдаг.

Отор хийхдээ малчид гэрээсээ арваас арван дөрвөн өдрийн хол, хангалттай сайн өвстэй, хүн мал нутагладаггүй газрыг сонгоно.

Жижиг малыг өдрийн цагаар бэлчээсний дараа орой бүр гэр лүүгээ, малчны хот руу буцааж тууж авчрах нь отрын үед зохимжгүй байдаг.

Малчид отрын уламжлалыг ардчиллын үед ч хадгалан үлдэх нь чухал гэж үзэж байна. Бүх малчид социалист нийгмийн үед отор хийдэг байсан боловч одоо цагт төвөгтэй таарамжгүй учраас отор хийхгүй байгаа.

Ажиллах хүч

Тухайн үед мал маллах ба бэлчээрлүүлэх нь малчдын ажил байсан. Малыг ихэнхдээ төрлөөр нь ялган тусад нь хариулдаг байсан ба нэг малчин хонь, ямаа хариулж байхад нөгөө малчин өөр газар үхэр сүрэг хариулна.

Зарим хоньчид төл малыг тусад нь хариулдаг.

Малыг өдөрт 2 удаа саадаг байсан. Хүүхдүүд сургуулийн амралтаар мал хариулдаг байсан бөгөөд малчдад амралтын өдөр байдаггүй байсан хэмээн зарим малчид гунигтайгаар дурсан санадаг. Гэхдээ сайн ажилласан хүмүүсийг төрөөс шагнаж нэгээс хоёр жилийн хугацаагаар амраадаг байжээ.

Мал саах

Социалист нийгмийн үед малыг, ялангуяа хонийг илүү их сааж цагаан идээ хийдэг байсан ба ямааг голдуу намар саадаг байжээ.

Хоньчины өдөр нар мандахад эхлэх бөгөөд хонио өдрийн 1 цаг хүртэл хариулаад эм хонийг саалгахаар авчирна. Оройдоо хонь хургийг тусад нь хариулж дараа нь хотондоо авчирдаг байжээ.

Шилжилтийн үе

1990 онд задран унасан социализмын дараа эхэлсэн социалист нийгмээс ардчилсан нийгэмд шилжих шилжилтийн үед таван хошуу мал хувьчлагдсан. Гэр бүл бүр өөртөө санаа тавьж эхэлсэн. 1993 оныг хүртэл ихэнх хүмүүс хуучин социалист төлөвлөгөөнд захирагдаж, малаа коминистуудын тушаасан бэлчээрт хариулж, байнга нүүдэллэж, машины оронд сарлаг, тэмээг хэрэглэсээр байсан гэж зарим малчид ярьж байна. Шилжилтийн үе эхэлсний дараа албадлагын байдал удаан үргэлжлээгүй хэдий ч 1993 оноос хойш цөөн хүмүүс социалист дэглэмийг дагасаар байв. Тэд бие даах чадваргүй байсан гэж зарим хүмүүс хэлдэг.

Хүмүүс тэднийг удирдах удирдагчийг хүлээн, удирдлагагүй байдлыг үнэлж ойлгож чадахгүй байсаар шилжилтийн үеийн эхний хоёр жилийг алдсан гэж зарим малчид үздэг байна.

Ардчиллын үе

Бэлчээр

Өнөө үед малчид зөвхөн улирлын байдлаар нүүдэллэдэг бөгөөд энэ нь бэлчээрийн талхлагдал ба өвсний ургалтыг удаашруулахад хүргэдэг.

Зарим малчид нэр төдий нүүдэг. Жишээ нь жилд дөрвөн удаа нүүдэллэх боловч нүүх бүртээ зөвхөн гурван километрийн зайд нүүх ба энэ нь тэд жилийн туршид нэг газарт амьдарч, нэг л газраа малаа бэлчээдэг гэсэн үг.

Хориос гучин өрх айлууд нэг газар хамт амьдарсанаас бэлчээрийн талхлагдалыг улам ихэсгэдэг.

Малын тоо өссөн нь гурван шалтгаантай. Малчид зах зээлийн эдийн засгийн өнөө үед мөнгө олохын тулд социалист нийгмийн үеийн малын тоог ардчиллын үед хоёроос гурав дахин өсгөсөн. (олон малчид ноолуурын төлөө ямааг хэт их өсгөдөг бөгөөд ямаа өвсний толгойг идээд зогсохгүй үндсийг иддэг учир бусад малыг бодвол бэлчээрийг ихээр сүйтгэдэг)

Мөн ямаа ургамлын аймгийг сүйтгэж, төрөл зүйлийг багасгаж, хөрсний байдлыг доройтуулдаг (хөрсний эвдрэл, органик бүтцийн өөрчлөлт гэх мэт)

Малыг хэт ихээр өсгөх нь өвсний дахин ургалтын хугацаа ба байгал хэрхэн нөхөн сэргэдгийг үл хайхран байгал дэлхийн баялгийг дуусашгүй мэт үзэх зэргээр бодит мэдлэг мэдээллээр дутмаг байдагтай холбоотой. Малын тоо толгой их байх нь малын илүүдэлд хүргэж улмаар бэлчээрийн доройтолд хүргэнэ.

Бэлчээрийн доройтол ихэнх бэлчээрт үүссэнээр малчид хамгийн ихдээ зөвхөн таван тонн өвс жил бүр авах боломжтой болдог. Ёс суртахууны боловсрол дутмаг байгаагаас бэлчээрийн доройтол үүсгэх шийдвэрүүдийг гаргах тал бий. Хүмүүс өөрсдөө сайхан сэтгэл, ухаалаг байдлаар газар дэлхийдээ хандаж, бэлчээрийн доройтлын хор уршгаас сэргийлэхийн тулд арваас хорин километрийн холд нүүх хэрэгтэй гэж малчид үзэж байна.

Социалист дэглэм байхгүй учраас мал бэлчээрлүүлэх буруу дадлууд бий болсон гэж олон малчид үзэж байхад зарим нь ардчилал малчин бүрийн буруу шийдвэрүүдийг буруушааж чаддаггүй гэж хэлдэг. Ямар ч гэсэн бэлчээрийн холбогдолтой асуудлуудад малчид хариуцлагатай ханддаг.

Мал саах

Зарим малчид үнээг өдөрт хоёр удаа саадаг байхад зарим нь зөвхөн өглөө нэг удаа саадаг. Хонийг зургадугаар сарын аравнаас долдугаар сарын арван хүртэл жилд зөвхөн нэг сар саах ба энэ нь өвс ургаж эхлэх үе бөгөөд энэ үед сүүний чанар сайн байдаг. Зуны үлдсэн саруудад хонийг таргалуулах, хүч тэвээрэг авахуулахад анхаардаг. Зарим малчид хонийг ерөөсөө саадаггүй.

Мал хариулах

Малчин өрх бүр мал маллагааны өөр өөрийн арга барилтай. Айл бүр малаа өөрсдөө хариулж өглөө болгон 10 цагийн үед бэлчээрт бэлчээж оройд буцаан тууж авчирна. Мал сүргийг өдрийн ихэнх цагт голдуу нэг бэлчээрт бэлчээдэг. Шөнийн цагаар хонь ямааг хашиж чоно болон хулгайчаас хамгаална. Тугалыг үнээнүүдээс өөр чиглэлд бэлчээж эхийгээ хөхөхөөс сэргийлдэг. Ардчиллын энэ үед ихэнхдээ хүмүүс үхэр ба бусад сүргийг хааяа очиж тууж хариулахын оронд өдрийн туршид сайн хариулсан нь дээр гэж малчид хэлдэг.

Баянхангай

Баянхангай нөхөрлөл олон төсөлд оролцож байгаа ба засгийн газраас гаргасан зохион байгуулалтын болон бэлчээрийн төлөвлөгөөнөөс авч өөрийн нөхөрлөлд зориулан төлөвлөгөө зохиосон. Тэд бэлчээрийн газартаа өвлийн бэлчээрийг хамгаалан хашаа барьсан учраас энэ бэлчээрийг хүйтний улиралд малаа хариулахад зориулдаг ба мөн хүндрэлтэй үед улсаас хандивладаг өвсийг малдаа хэрэглэдэг. Баянхангайн нөхөрлөлийн өөр нэг зорилго бол чанаргүй олон тооны мал өсгөхийн оронд чанартай цөөн мал өсгөх юм.

Хүмүүс өсгөж буй малынхаа хэмжээг гэр бүлийн гишүүдийн тооноос хамааруулж тогтоовол тэдний ажиллах хүч тодорхой болно гэж нөхөрлөлийн ахлагч Нямрэнчин ярьдаг. Жишээлбэл, 5 ам бүлтэй гэр бүлийн 2 гишүүн нь ажил хийж мөнгө олох, 2 гишүүн нь малаа маллах, нэг хүн нь малаа саах гэх мэт. Түүний бодлоор гэр бүлийн гишүүд бүгдээрээ энэ бүх ажлуудыг зэрэг хийхийг хичээх нь ашиггүй байдаг ба тэр хөдөлмөрийн хуваарилалтыг дэмждэг. Түүний энэ санааг дагаж буй гэр бүл 3 гишүүнтэй бол 3 хүний хариулж чадах хэмжээний малаас илүү мал маллахгүй байх буюу гурван зуугаас илүүгүй малтай байх. Ийм хэмжээний мал тэр гэр бүлийг хоол болон цагаан идээгээр хангаж чадна. Ажил хийж мөнгө олох 2 эрэгтэй гишүүд модоор сийлбэр хийж, тавилга хийж байхад эмэгтэй гишүүд хатгамал ба хэрээсэн хатгамал оёж болно.

Нямрэнчин малчин өрхүүдийг цөөн ямаатай байлгахийг хүсэх боловч ямаа бол тэдний хувийн өмч учраас ямааг ихээр өсгөхийг нь тэр зогсоож чадахгүй юм. Иймээс хүмүүс ямааг зохистой хэмжээнд байлгах хэрэгтэй гэж тэр үздэг. Ямаа байгал орчныг хэрхэн сүйтгэдэгийг засгийн газраас анхааран үзэж ямааны нөлөөг хязгаарлахын тулд ноолуурын үнийг багасгах арга хэмжээ авч байна.

Насны ялгаа

Малчид насны байдал ба дур сонирхлоосоо шалтгаалж өөр өөрөөр Баянхангай нөхөрлөлд оролцдог. Залуучууд илүү бие даасан байдалд байх ба өөрсдөө шийдвэр гаргах зорилготой байдаг бол ахмадууд хамтдаа хэрхэн үр ашигтай ажилладаг байснаа дурсан санахыг хүсдэг байна.

Залуучууд хүний үгийг сонсдоггүй гэж зарим ахмад хүмүүс хэлэх ба жишээ нь нөхөрлөл хамтдаа өвс хадахаар төлөвлөхөд залуу хүмүүс үүнийг ганцаараа хийх мэт. Зарим хүмүүс тэдний бэлчээрийн тодорхой ажлуудыг тоодоггүй, бусад хүмүүст хариуцлагаа үүрүүлж, төвөг уддаг гэж янз бүрийн насны малчид ярьдаг.

Мал маллах уламжлалууд

Малчид бэлчээрийн ирээдүй болон мал малласаар ирсэн өнгөрсөн үеэ зөвхөн социалист нийгмийн үеийн дадал зуршил биш харин тэдний уламжлал хэмээн үздэг. Отор хийх, малыг төрлөөр нь өөр өөр бэлчээрт хариулах (хэдийгээр хонь, ямаа хамт бэлчээрлэдэг), малыг шилж сонгож өсгөх, онд орохгүй туранхай ядруу малыг сүргийн тоог их байлгахын тулд хадгалж үлдээхийн оронд төхөөрөх, социализмын үе шиг малыг хэт их өсгөдөггүй зэрэг уламжлалууд Монголын ёс заншилд байдаг.

